



**ХЭЛЭЛЦҮҮЛГИЙН  
ТАЙЛАН - 2021**

# Ашигт малтмалын бүтээгдэхүүнд дагалдах металл/элементүүдэд АМНАТ ногдуулах тухай хэлэлцүүлгийн тайлан

Энэхүү тайланг Адам Смит Интернэйшнл компанийн захиалгаар Австрали-Монголын эрдэс баялгийн салбарын хамтын ажиллагааны хөтөлбөрийн (АМЕП-2) хүрээнд боловсруулав. Тус тайланг Пьетро Гуж бэлтгэсэн бөгөөд төслийн багийн дараах гишүүд мөн оролцсон болно. Үүнд:

- Алгаа Намгар: АН
- Бямбажав Лувсанчүлтэм: БЛ
- Ганбат Энхболд: ГЭ
- Кирстен Ливермор: КЛ
- Оюунбилэг Пүрэв: ОП

АМЕП-2 хөтөлбөрийг Австрали Улсын Гадаад харилцаа, худалдааны яам санхүүжүүлэн, Австрали Улсын Засгийн Газар, Монгол Улсын Засгийн Газар хамтран хэрэгжүүлж байна.

## АГУУЛГА

<b>Тайлангийн товч хураангуй ба зөвлөмжүүд.....</b>	<b>6</b>
Ерөнхий дүгнэлт.....	6
Зөвлөмж .....	8
<b>1. ТАНИЛЦУУЛГА.....</b>	<b>9</b>
1.1 Ерөнхий мэдээлэл .....	9
1.2 Монгол Улсад одоо мөрдөгдөж байгаа АМНАТ-ийн зохицуулалттай холбоотой асуудал ...	10
<b>2. АМНАТ: ЗАРЧИМ, ЗОРИЛГО, ТӨРӨЛ, ЗАХИРГААНЫ АСУУДЛУУД .....</b>	<b>11</b>
2.1 Үндсэн зарчим.....	11
2.2 АМНАТ-ийн талаарх сөргөлцсөн зорилтуудыг нэгтгэн уялдуулах.....	11
2.3 АМНАТ нь уул уурхайн татварын бүрэлдэхүүн хэсэг .....	12
2.4 АМНАТ-ийн төрлүүд .....	13
2.5 Үнэлгээнд суурилсан АМНАТ ( <i>ad valorem</i> ) .....	14
2.5.1 Татварын цэг / АМНАТ-ийн суурь үнэлгээ.....	14
2.5.2 АМНАТ-ийн хувь хэмжээ .....	17
<b>Хүснэгт 3. Монгол Улсын зэсийн бүтээгдэхүүний өсөн нэмэгдэх АМНАТ-ийн хувь хэмжээний жишээ .....</b>	<b>19</b>
<b>3. ХҮДЭР, БАЯЖМАЛЫН ОЛОН УЛСЫН .....</b>	<b>19</b>
<b>МАРКЕТИНГ, ҮНЭЛГЭЭ.....</b>	<b>19</b>
3.1 Борлуулалтын гэрээний төрлүүд .....	19
3.1.1 Ерөнхий зүйл.....	19
3.1.2 Төмрийн хүдэр, баяжмалын борлуулалт.....	19
3.1.3 Үндсэн металлын баяжмалын борлуулалт.....	20
3.2 Хайлуулах үйлдвэрийн цэвэр үнэлгээ (NSV) .....	20
<b>4 МОНГОЛЫН АШИГТ МАЛТМАЛЫН БАЯЖМАЛЫН КЕЙС СУДАЛГАА: ОЛОН УЛСЫН АМНАТ-ИЙН ХАРЬЦУУЛАЛТ.....</b>	<b>22</b>
4.1 Монголын уул уурхайн салбарын талаарх ерөнхий ойлголт.....	22
4.1.1 Монголын хүдэр/баяжмал/ металлын экспортын ач холбогдол .....	22
4.1.2 Монгол Улсын хайгуул, ашиглалтын хөрөнгө оруулалтын талаарх олон улсын ойлголт.....	22
4.2 Баяжмал дахь “дагалдах металл/элемент”-ийн АМНАТ-ийн олон улсын шилдэг туршлага	24
4.3 Монголын баяжмалын кейс судалгаа .....	26
4.3.1 Кейс судалгааны ерөнхий тойм.....	26
4.3.2 – Кейс 1: Зэсийн баяжмал .....	26
4.3.3 – Кейс 2: Цайрын баяжмал .....	30
4.3.4 – Кейс 3: Төмрийн хүдрийн баяжмал.....	33
<b>5 ЦААШДЫН АРГА ЗАМУУД: “ДАГАЛДАХ МЕТАЛЛ” -ЫН БОДЛОГЫГ ӨӨРЧЛӨХ ХУВИЛБАРУУД .....</b>	<b>35</b>
5.1 Өнөөгийн АМНАТ-ийн тогтолцоонд томоохон шинэчлэл хийх шаардлагагүй .....	35
5.2 “Дагалдах металл”-ын АМНАТ-ийн бодлогыг тогтоох логик алхмууд.....	36

<b>5.3 Энэ тайлангийн зөвлөмжийг хэргэжүүлэхэд гарах эдийн засгийн үр нөлөө .....</b>	<b>40</b>
5.3.1. "Дагалдах металл"-ын АМНАТ-ийн зохицуулалтын гажуудлыг засах өртөг.....	40
5.3.2 Мөнгөн болон мөнгөн бус үр өгөөж .....	42
5.3.3 Дагалдах металлын бодлогыг эцэслэн тодорхойлоход салбарыхны оролцоо .....	44
<b>6. ДУГНЭЛТ .....</b>	<b>45</b>
<b>7. ЗӨВЛӨМЖ .....</b>	<b>47</b>
<b>НОМ ЗҮЙ .....</b>	<b>49</b>
<b>ХАВСРАЛТУУД .....</b>	<b>50</b>
<b>Хавсралт 2 – Зарим Уул Уурхайн татварын тогтолцооны харьцуулалт.....</b>	<b>51</b>
<b>Хавсралт 3. Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөртэй холбоотой .....</b>	<b>55</b>
<b>Монгол Улсын эрх зүйн тогтолцоо.....</b>	<b>55</b>
<b>Хавсралт 4 - Монгол Улсын Засгийн Газрын 2021 оны 2 дугаар сарын 5-ны өдөр.....</b>	<b>69</b>
<b>зарласан өөр өөр чанарын Фтор, Нүүрсний үнэ.....</b>	<b>69</b>
<b>Хавсралт 5 – Кейсийн судалгаа 1 - Зэсийн баяжмал.....</b>	<b>71</b>
5.1 – Монгол Улсын АМНАТ-ийн тооцоолол .....	71
5.2 – Хайлуулах үйлдвэрийн цэвэр үнэлгээ (төлбөр)-NSV .....	74
5.3 – Баруун Австрали, Куинсландын АМНАТ-ийн тооцоолол.....	76
<b>Хавсралт 6 – Кейсийн судалгаа 2 - Цайрын баяжмал .....</b>	<b>78</b>
6.1 – Монгол Улсын АМНАТ-ийн тооцоолол .....	78
6.2 – Хайлуулах үйлдвэрийн цэвэр үнэлгээ (төлбөр) .....	81
6.3 - Баруун Австрали ба Куинсландын цайрын баяжмалын АМНАТ-ын тооцоолол .....	83
<b>Хавсралт 7 – Кейсийн судалгаа 3 – Төмрийн хүдрийн баяжмал .....</b>	<b>85</b>
7.1 – Монгол Улсын АМТХ-ийн 47 дугаар зүйл .....	85
7.2 – Борлуулалтын гэрээнд суурилсан.....	88
7.3 – Баруун Австрали, Куинсланд .....	89
<b>Хавсралт 8 – Монгол Улсын 2019-2020 онд ногдуулсан АМНАТ-ийн статистик тоон мэдээлэл .....</b>	<b>90</b>

## Хүснэгтийн жагсаалт

<b>Хүснэгт 1.</b> Олборлох салбарын татварын орлогын эх үүсвэрүүд (Эх сурвалж: Сангийн яам, ОУИТБС-ын 2020 оны тайлан) .....	12
<b>Хүснэгт 2.</b> Монгол Улсын Засгийн газраас 2021 оны 2 дугаар сарын 5-ны .....	16
<b>Хүснэгт 3.</b> Монгол Улсын зэсийн бүтээгдэхүүний өсөн нэмэгдэх АМНАТ-ийн хувь хэмжээний жишээ.....	19
<b>Хүснэгт 4.</b> Хайлуулах үйлдвэрийн цэвэр үнэлгээ(NSV)-г баяжмалд агуулагдаж буй үндсэн металлын үнэд эзлэх хувиар илэрхийлэх нь.....	21
<b>Хүснэгт 5.</b> Монгол Улсын 2019 оны ашигт малтмалын бүтээгдэхүүний экспортын тоо хэмжээ, үнэлгээ.....	22
<b>Хүснэгт 6.</b> Монгол Улсын ЗГ-аас чийгтэй, нэг тонн зэсийн баяжмалд.....	27
<b>Хүснэгт 7.</b> Монголын АМНАТ-ийн суурь үнэлгээ ба олон улсын NSV, Баруун Австрали, Куинсландын АМНАТ-ийн харьцуулалт .....	28
<b>Хүснэгт 8.</b> Зэсийн баяжмалд агуулагдаж буй үнэт металлын урамшуулал ба боловсруулалтын зардлын жишээ, (Эх сурвалж AusIMM, 2012).....	28
<b>Хүснэгт 9.</b> БНХАУ-ын импортын зэсийн баяжмалд агуулагдах .....	29
<b>Хүснэгт 10.</b> Зэсийн баяжмалд түгээмэл агуулагддаг үнэт бус металлын торгуулийн хасагдуулгын жишээ. Fountain-ий Японы хайлуулах үйлдвэрүүдийн үзүүлэлтийг саарал өнгөөр тодотгож харуулав, 2013. (Эх сурвалж: AusIMM, 2012).....	29
<b>Хүснэгт 11.</b> Зэсийн баяжмалд агуулагддаг дагалдах металл/элементийн босго агуулга, торгуулийн хэмжээ (Эх сурвалж: Саломон-де-Фридберг ба Робинсон, 2014).....	30
<b>Хүснэгт 12.</b> Монгол Улсын Засгийн Газраас чийгтэй, нэг тонн цайрын баяжмалд .....	30
<b>Хүснэгт 13.</b> Монголын АМНАТ-ийн суурь үнэлгээ ба орлогын хэмжээг олон улсын NSV болон Баруун Австрали, Куинсландын тогтолцоотой харьцуулсан нь .....	31
<b>Хүснэгт 14.</b> Цайрын баяжмалтай холбоотой үнэт металлын урамшуулал ба боловсруулалтын төлбөрийн жишээ (Эх сурвалж AusIMM, 2012. Бусад эх сурвалжийг саарал өнгөөр тодруулав).....	32
<b>Хүснэгт 15.</b> Цайрын сульфидын баяжмалын үзүүлэлт.....	32
<b>Хүснэгт 16.</b> Цайрын баяжмалд ихэвчлэн агуулагддаг хортой нөлөө бүхий металлын хасагдуулгын жишээ (Эх сурвалж: Modified from AusIMM, 2012. Л.Бямбажаваас авсан мэдээллийг саарал өнгөөр тодруулав) 33	
<b>Хүснэгт 17.</b> Монгол Улсын Засгийн Газраас төмрийн хүдрийн, чийгтэй, нэг тонн баяжмалд ногдуулж хураасан АМНАТ .....	33
<b>Хүснэгт 18.</b> Монголын төмрийн хүдрийн баяжмалын АМНАТ-ийн суурь үнэлгээ ба орлогыг олон улсын NSV болон Баруун Австрали, Куинсландын тогтолцоотой харьцуулсан нь .....	34
<b>Хүснэгт 19.</b> Төмрийн хүдрийн баяжмалд ногдуулах торгуулийн хэмжээ.....	35
<b>Хүснэгт 20.</b> Үндсэн болон дагалдах металаас 2019, 2020 онуудад төвлөрүүлсэн АМНАТ-ийн орлогын задаргаа (Эх үүсвэр: ноён Н.Мөнхбилэг, Монгол Улсын Татварын ерөнхий газар) .....	40
<b>Хүснэгт 21.</b> АМНАТ ногдуулах матриц, баяжмалын төрөл болон “урамшуулал” төлөгдөх дагалдах металлын хувь хэмжээгээр задлан харуулав. Энэхүү илтгэлийн зөвлөмжийг хэргэжүүлсэн тохиолдолд 2020 онд алдах байсан орлогыг үнэлэхэд ашиглав. ....	41
<b>Хүснэгт 22.</b> Энэхүү илтгэлийн зөвлөмжийг хэргэжүүлсэн тохиолдолд 2020 онд алдах байсан АМНАТ-ийн орлогын таамаг тооцоо .....	42
<b>Хүснэгт 233.</b> Уул уурхайн үр өгөөж, зардлын шинж чанар.....	43

## Зургийн жагсаалт

Зураг 1. Засгийн газрын зорилтыг биелүүлэхэд АМНАТ-ийн төрлүүдийн гүйцэтгэх үүрэг .....	13
Зураг 2. Нэмүү өртгийн гинжин хэлхээний дагуух АМНАТ ногдуулах боломжтой цэгүүд. (Эх сурвалж: Modified from Guj et al, 2012) .....	14
Зураг 3. Үнэлгээнд суурилсан АМНАТ-ийн тогтолцоон дахь суурь үнэлгээний схемчилсэн ангилал .....	15
Зураг 4. “Хайлуулах үйлдвэрийн цэвэр үнэ” (NSV) болон үнэлгээнд суурилсан АМНАТ тогтоох суурь үнэлгээ.....	17
Зураг 5. Үнэлгээнд суурилсан АМНАТ-ийн тогтолцоонд ашиглагддаг АМНАТ-ийн хувь хэмжээг ангилах бүдүүвч зураг.....	18
Зураг 6. Монгол Улсын өсөн нэмэгдэх АМНАТ-ийн хувь хэмжээ бүхий тогтолцоог харуулсан бүдүүвч зураг.....	18
Зураг 7. Монгол улсын зэрэглэл: Ашигт малтмалын нөөц, Татварын тогтолцоо ба хөрөнгө оруулалтыг татах байдал. Хэвийн байдлыг 100% гэж үзсэн.....	23
Зураг 8. Цайрын баяжмалын боловсруулах зардал(ТС)-ын “жишиг-benchmark” ба Спот ТС .....	31
Зураг 9. Ашигт малтмалын бүтээгдэхүүн дэх дагалдах “металл/элемент”-д АМНАТ ногдуулах зарчим.	38



## Тайлангийн товч хураангуй ба зөвлөмжүүд

### Ерөнхий дүгнэлт

Салбарын зүгээс биш, зөвхөн Засгийн Газрын өнцгөөс авч үзвэл Монгол Улсад одоо үйлчилж байгаа ашигт малтмалын борлуулалтын үнэлгээн дээр үндэслэн нөөц ашигласны төлбөр (АМНАТ) ногдуулах зохицуулалт нь олон давуу талтай бөгөөд хүдэр, баяжмал зэрэг ашигт малтмалын бүтээгдэхүүнд агуулагдах металлуудад АМНАТ ногдуулахтай холбоотой үүсэх захиргааны асуудлыг шийдвэрлэхээс өөр дорвитой нэмэлт өөрчлөлт оруулах шаардлагагүй юм. АМНАТ-ийн хэмжээг ашигт малтмалын бүтээгдэхүүнд агуулагдаж буй үндсэн болон дагалдах металл/элементүүдийн үнэ ба тухайн бүтээгдэхүүний боловсруулалтын түвшинг харгалзан ялгавартайгаар тогтоох нь АМНАТ ногдуулах тогтолцоог эдийн засгийн хувьд үр ашигтай, шударга болгодог бөгөөд ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг эцсийн бүтээгдэхүүний зах зээлийн зарлагдсан үнэ дээр үндэслэн, хайлуулалт, цэвэршүүлэлтийн зэрэг зардлыг хасахгүйгээр тооцох нь дийлэнх тохиолдолд хоёрдмол утгагүй, зайлсхийхэд хэцүү, дагаж мөрдөхөд харьцангуй хялбар байдаг.

Энэхүү тайланд авч үзсэн дагалдах металл/элементэд АМНАТ ногдуулахтай холбоотой асуудал, захиргааны бэрхшээл нь Ашигт малтмалын тухай хуулийн 47 дугаар зүйл, холбогдох журамд тусгасан “борлуулалтын үнэлгээ” гэсэн нэр томъёог “дагалдах металл/элементүүд”-тэй холбон хэт шууд утгаар тайлбарласнаас үүдэлтэй гэж үзэж болохоор байна.

Монгол Улсад одоо мөрдөгдөж байгаа аргачлал нь ашигт малтмалын бүтээгдэхүүнд агуулагдах үндсэн металлын борлуулалтын үнээс гадна олборлогчийн бага хэмжээний "урамшуулал" буюу нэмэлт төлбөр авдаг дагалдах металл/элементэд АМНАТ ногдуулдаг олон улсын нийтлэг туршлагад нийцээгүй, давсан практик бөгөөд дараах төрлийн дагалдах металл/элементүүдэд АМНАТ ногдуулж байна. Үүнд:

1. *Худалдан авагч тал хайлуулах, цэвэршүүлэх процесст хортой нөлөө үзүүлдэг гэсэн шалтгаанаар олборлогч талд төлөх ашигт малтмалын бүтээгдэхүүний борлуулалтын үнэлгээг "торгууль" ногдуулах хэлбэрээр бууруулдаг дагалдах металл/элементүүд болон,*
2. *Олборлогч үндсэн металлын борлуулалтын үнэлгээнээс гадна "урамшуулал" буюу нэмэлт төлбөр авдаггүй бөгөөд хүдэр, баяжмалд бага хэмжээгээр агуулагдсан учраас одоо байгаа болон ойрын ирээдүйн металлургийн технологиор ялган авах боломжгүй дагалдах металл/элементүүд.*

Энэхүү судалгааны хүрээнд дээрх 1-р асуудлыг шийдвэрлэхэд Монгол дахь зэс, цайр, төмрийн хүдрийн баяжмалын АМНАТ ногдуулах үнэлгээ, ногдуулсан хэмжээг тухайн баяжмалыг Баруун Австрали, Куинсланд зэрэг Австралийн уул уурхайгаар тэргүүлэх мужуудад олборлосон тохиолдолд ногдуулах байсан АМНАТ-тэй харьцуулж нарийвчилсан тоон үнэлгээ хийсэн болно. Үүнд янз бүрийн баяжмалд нийтлэг агуулагддаг дагалдах металл/элементүүдэд хайлуулах, цэвэршүүлэх үйлдвэрүүдийн зүгээс олгодог "урамшуулал" ба хасагдуулдаг "торгуулийн" хувь хэмжээний талаарх дэлгэрэнгүй мэдээллийг цуглуулж оруулсан болно.

Судалгаанд авч үзсэн гурван кейст бүгдэд нь, ялангуяа зэсийн баяжмалын хувьд Монгол Улсын татварын тогтолцооны дагуу ногдуулдаг АМНАТ-ийн хэмжээ нь Австралийн татварын горимын дагуу ногдуулах хэмжээнээс хамаагүй илүү байв. "Дагалдах металл" -д хамаарах АМНАТ-ийг хассаны дараа ч гэсэн үр дүн нь ижил байна.

Түүнчлэн, Монгол Улсын “дагалдах металл”-д ногдуулж хураасан АМНАТ-ийн эзлэх хувь нь зэсийн баяжмалын хувьд 1.5%, цайрын баяжмалын хувьд 25.6% байв.

2020 оны АМНАТ-ийн статистикаас харахад нийт 1.572.47 тэрбум төгрөг (628.99 сая доллар)-ийн үнийн дүнгийн зөвхөн 73.25 тэрбум төгрөг (29.30 сая доллар)-ийн төлбөрийг дагалдах металлууд бүрдүүлсэн байна. Эндээс үзэхэд тухайн жилийн АМНАТ-ийн орлогын 4.66% -ийг дагалдах металлууд эзэлж байгаа бөгөөд, 4.24% буюу 66.74 тэрбум төгрөг (26.70 сая доллар)-ийн төлбөрийг дагалдах хэлбэрээр агуулагдаж буй алт болон мөнгө эзэлж байна. Энд үндсэн бүтээгдэхүүн байдлаар олборлосон алтыг тооцоогүй болно. Зэс, цайр олборлогч компаниуд хайлуулах үйлдвэрээс "урамшуулал" буюу нэмэлт төлбөр авч байсан "дагалдах металл" нь зөвхөн алт болон мөнгө байсан (алт, мөнгөний үнийн дүнгийн 85 орчим хувийг “урамшуулал” хэлбэрээр авч байсан байх) бол харин олон төрлийн дагалдах металлууд,

түүний дотор “торгууль” ногдуулдаг дагалдах металлуудад Монгол Улсын Засгийн Газар АМНАТ ногдуулдаг байна. Тухайлбал зэсийн баяжмал дахь төмөр, төмрийн хүдрийн баяжмал дахь хөнгөн цагаан, хүхэр зэрэг металл/элементийг дурдаж болно. Жишээ нь, төмрийн хүдрийн баяжмалд дагалдах хөнгөн цагаанд 1.105 тэрбум төгрөг (0.44 сая доллар)-ийн АМНАТ ногдуулан хураасан байх ба энэ нь борлуулагч компаниудын хувьд нэгдүгээрт, худалдан авагчийн зүгээс “торгууль” тавигдах, хоёрдугаарт Засгийн Газарт АМНАТ төлөх зэргээр давхар “торгууль” хүлээж байгаа гэсэн үг юм. Үнэн хэрэгтээ зах зээл эдгээр дагалдах металл/элементийн агууламжийн төлөө эрдэс бүтээгдэхүүний үнэлгээг бууруулдаг бол Монгол Улсын Засгийн Газар эдгээрийн борлуулалтын үнэлгээг эсрэгээр нь, тухайн дагалдах металл/элементийг цаашид ялган авдаггүйг нь үл харгалзан, нэмэгдүүлж байна. Энд төмрийн хүдрийн баяжмал дахь хөнгөн цагааны жишээг дурьдаж болох бөгөөд ган үйлдвэрлэх явцад хөнгөн цагааныг ялган гаргаж авах боломжгүй, хөнгөн цагаан нь хайлуулах зууханд шаар болж үлддэг учраас хайлуулах үйлдвэрийн зардлыг нэмэгдүүлдэг. Энэ үүднээс уул уурхайн компаниудын зүгээс АМНАТ-ийн зохицуулалтын энэхүү орчныг шударга бус хэмээн үзэж гомдол зарга мэдүүлбэл Засгийн Газарын хувьд гайхах зүйлгүй биз ээ.

Судалгааны хоёр дахь хэсэгт “дагалдах металл” -д АМНАТ ногдуулахтай холбоотой олон улсын өнөөгийн практик ямар байгааг дээрх 2-р асуудлын хүрээнд авч үзсэн болно. Уул уурхай эрхэлдэг дэлхийн олон улс орнуудын АМНАТ-ийн зохицуулалтын орчныг тоймлон судлахад дараахь зүйлийг харуулж байна. Үүнд:

- *Судалгаанд хамрагдсан улсуудын алинд нь ч олборлогч тал төлбөр аваагүй металлд АМНАТ ногдуулах тухай заасан тодорхой хууль, журам байхгүй бөгөөд энэ нь,*
- *Монгол Улсад мөрдөгдөж буй одоогийн практик нь нэлээд өвөрмөц шинжтэй байгааг харуулж байна.*

Бүтээгдэхүүний жин, эсвэл хэмжээнд суурилсан бөгөөд борлуулалтын үнэлгээнээс хамааралгүй АМНАТ-ийн зохицуулалтыг эс тооцвол АМНАТ-ийн дийлэнх зохицуулалт нь үнэлгээ, эсвэл ашиг дээр суурилсан байдаг. Ашигт суурилсан АМНАТ-ийн тогтолцооны хувьд АМНАТ ногдуулах суурийг бүхэлд нь санхүүгийн "гүйцэтгэл"-д үндэслэн тогтоодог тул дагалдах металлтай холбоотой асуудал гардаггүй.

Үнэлгээнд суурилсан АМНАТ-ийн тогтолцоо нь дотроо АМНАТ-ийг “бодитоор биелсэн” борлуулалтын үнэлгээнд үндэслэн тооцох, эсвэл Монгол Улсынхтай адил “урьдчилж тооцоолсон” борлуулалтын үнэлгээнд үндэслэн тооцох гэсэн хоёр янз байдаг.

Гэхдээ Монгол Улс нь худалдагч тал дагалдах металлын төлбөрийг бодитоор хүлээж авсан эсэхээс үл хамааран бүх дагалдах металлд АМНАТ ногдуулдагаараа үнэлгээнд суурилсан АМНАТ-ийн тогтолцоо бүхий бусад улс орноос ялгаатай байна.

"Дагалдах металл"-ын асуудал Монголоос бусад улс орнуудад ч үүсдэг, харин тэд уг асуудлыг зөвшөөрөл олгох үйл явцын эхний шатанд, тухайлбал, Компанийн зүгээс Засгийн Газарт ашигт малтмалын ордыг ашиглах тухай Хүсэлтийн мэдэгдэл (NoI)-ийг хүргүүлэх үед шийдвэрлэдэг. Компани болон Засгийн Газрын ашиг сонирхол өргөн хүрээнд уялдах ёстой гэж үзэх нь зөв боловч энэ үе шатанд Засгийн Газар Хүсэлтийн мэдэгдэл (NoL)-ийг дагалдах Техник, эдийн засгийн үндэслэл (ТЭЗҮ)-д тусгасан бүтээн байгуулалт нь Засгийн Газрын хувьд хэр оновчтой байна вэ гэдгийг нягталж үзэх боломжтой. Ийнхүү нягталж шалгах явцад харьцангуй өндөр агууламжтай зарим “дагалдах металл”-ын үнэлгээг эдийн засгийн тооцоонд авч үзээгүйн үндэслэл, шалтгааныг асууж лавлах ёстой. Үүний дагуу тухайн ордын ашиглалтын төлөвлөгөөг дахин авч үзэх, эсвэл ашиглалтын эцсийн төлөвлөгөөнд компани нь ирээдүйд тухайн дагалдах металлын үнэ өөрчлөгдсөн, эсвэл холбогдох металлургийн технологид ахиц дэвшил гарсан нөхцөлд мөнхүү дагалдах металлын арилжааны үндэслэлийг дахин авч үзэх үүргийг уул уурхайн компанид хүлээлгэж болох юм

Өөр нэг чухал асуудал бол, “дагалдах металл”-ын агуулга нь ямар түвшингээс доош байхад ялган авах боломжгүй, эдийн засгийн хувьд ашиггүй гэж үзээд АМНАТ-өөс чөлөөлөх вэ гэдэг асуудал юм. Энэ талаарх сонирхолтой хандлагыг Баруун Австралийн АМНАТ-ийн зохицуулалтаас харж болно. Энэхүү зохицуулалтаар төмрийн хүдэр(магнетит)-ийн баяжмал дахь ванадийд АМНАТ ногдуулах хамгийн доод агууламжийг тогтоосон байдаг бөгөөд энэхүү доод хэмжээнээс давсан агуулга бүхий ванадийд цаашдын



боловсруулалтын явцад ялган авах эсэхээс нь үл хамааран АМНАТ ногдуулдаг. Төмрийн хүдрийн үнэ хурдацтай өссөн үед ихээхэн хэмжээний ванадий бүхий магнетитийн нөөцийг зохистой бус түвшинд, хурдацтай ашиглах эрсдэлтэй байсан тул энэхүү арга хэмжээг хэргэжүүлэх шаардлагатай гэж үзсэн байдаг.

Хэдийгээр “дагалдах металл”-д АМНАТ ногдуулах асуудал нь Монгол Улсад хэрэгжиж буй уул уурхайн удирдлагын өргөн хүрээний зохицуулалтын харьцангуй жижиг хэсэг боловч энэ нь олон улсын түвшинд Монгол Улсын уул уурхайн салбарын зохицуулалтын талаарх ерөнхий төсөөлөлд сөргөөр нөлөөлж, улмаар ашигт малтмалын хайгуул, ашиглалтын чиглэлээр гадаадын шууд хөрөнгө оруулалтыг татахад саад учруулж байна. Эрдэс баялгийн хүлээн зөвшөөрөгдсөн өндөр боломжтой Монгол Улсын хувьд энэ нь харамсалтай хэрэг юм.

Дагалдах металлтай холбоотой зохицуулалтын гажуудлыг арилгаснаар үүсэх шууд ба шууд бус үр ашиг нь шаардлагатай зохицуулалтын шинэчлэл хийснээр алдагдах боломж, харьцангуй бага хэмжээний орлогын бууралтаас урт хугацаандаа хамаагүй давж гарна гэж үзэх болохоор байна.

Тухайлбал, хэрэв үнэт бус дагалдах металлуудыг АМНАТ-өөс чөлөөлсөн бол 2020 онд төвлөрүүлэх АМНАТ-ийн орлого 6.513 тэрбум төгрөг (2.61 сая доллар)-өөр буурах байсан тооцоо гарч байна. Энэ нь АМНАТ-ийн нийт орлогын 0.41%-ийг л эзэлж байгаа юм. Мөн түүнчлэн үнэт бус дагалдах металлыг АМНАТ-өөс чөлөөлснөөр захиргааны үйл ажиллагааг хялбарчилж, химийн шинжилгээний зардлыг бууруулах замаар Засгийн Газар нэлээд хэмжээний хэмнэлт гаргах боломжийг бүрдүүлж болохоор байв. Уул уурхайн олборлогч компаниуд нэмэлт төлбөр “урамшуулал” авдаггүй үнэт бус дагалдах металлуудыг, ялангуяа “торгууль”-т дагалдах металл/элементүүдийг АМНАТ-аас чөлөөлбөл энэ нь уул уурхайн салбарын олборлогчид, үйлдвэрлэгчдийн хувьд шударга явдал гэж үнэлэгдэх юм.

Олборлогч компаниуд дагалдах үнэт металлын, тухайлбал алт, мөнгөний ихэнхэд нь нэмэлт төлбөр буюу “урамшуулал” авдаг. 2020 онд дагалдах үнэт металл (үндсэн металл байдлаар олборлосон алт, мөнгөнөөс бусад) ногдуулсан АМНАТ 66.742 тэрбум төгрөг (26.70 ам. доллар) байгаа бөгөөд үүний 14.6% буюу 9.715 тэрбум төгрөг (3.88 сая доллар)-ийг нь олборлогч “урамшуулал” авдаггүй дагалдах үнэт металлд ногдуулсан байна. Онолын үүднээс авч үзвэл, олборлогч “урамшуулал” авдаггүй дагалдах үнэт металлыг АМНАТ-өөс чөлөөлөх нь зөв боловч ингэснээр АМНАТ-ийн орлогыг бууруулахаас гадна Засгийн газрын хувьд ч, уул уурхайн салбарын хувьд ч захиргааны үйл ажиллагааг илүү төвөгтэй болгоно. АМНАТ ногдуулах тогтолцоонд өөрчлөлт оруулах шаардлагатай болох ба эхний ээлжинд Засгийн Газар ердийн журмаар дагалдах үнэт металлд АМНАТ ногдуулж, дараа нь худалдан авагчаас төлсөн нэмэлт төлбөр “урамшуулал”-ын баримт сэлтийг үндэслэн АМНАТ-ийг дахин тооцоолж, холбогдох тохируулга хийж байх хэрэгтэй болох юм. Энэ нь захиргааны үйл ажиллагааг илүү төвөгтэй болгож, зардал нэмэгдүүлэх үр дагавартай.

### **Зөвлөмж**

Дээрх дүгнэлтийг үндэслэн Монгол Улсад дараах зөвлөмжийг өгч байна. Үүнд:

1. Ашигт малтмалын бүтээгдэхүүнд агуулагдаж буй дагалдах металл/элемент нь ялган авахад эдийн засгийн болон технологийн хувьд ашигтай бөгөөд боломжтой бол ашигт малтмалын бүтээгдэхүүний цаашдын боловсруулалтын явцад ялган авах эсэхээс нь үл хамааран тухайн дагалдах металл/элементэд АМНАТ ногдуулах.
2. Ашигт малтмалын бүтээгдэхүүн дэх АМНАТ ногдуулах дагалдах металл/элементүүдийн жагсаалт(Хавсралт-1-д санал болгосон)-ыг олон улсын худалдаанд хүлээн зөвшөөрөгдсөн зарчим, тухайн дагалдах металл/элементийг ялган авах металлургийн технологийн практикт үндэслэн гаргаж зарлах.
3. Дагалдах металл/элементэд АМНАТ ногдуулах борлуулалтын үнэлгээг Засгийн Газраас тогтмол зарладаг жишиг үнэ болон Монгол Улсын итгэмжлэгдсэн лабораторийн шинжилгээний дүгнэлтээр тодорхойлсон агуулгын цэвэр хувь, хэмжээнд үндэслэн, дагалдах металл/элементийн агуулгын босго, хязгаарыг харгалзахгүйгээр тодорхойлох бөгөөд энэхүү борлуулалтын

үнэлгээнээс тухайн дагалдах металл/элементийг ялган авах, хайлуулах, цэвэршүүлэхтэй холбогдон гарах зардлыг хасахгүй.

4. Ашигт малтмалын бүтээгдэхүүнийг боловсруулах технологийн дэвшил, дагалдах металл/элементийн зах зээлийн үнэтэй уялдуулан АМНАТ ногдуулах дагалдах металл/элементийн жагсаалтыг үе үе хянаж, шаардлагатай тохиолдолд шинэчилж байх.
5. Хавсралт-1-д тусгагдсан ашигт малтмалын бүтээгдэхүүнд агуулагдаж буй дагалдах металл/элементүүдийг АМНАТ-аас чөлөөлөх, үүнд дараах металл/элементүүдийг хамруулах:
  - а. ашигт малтмалын бүтээгдэхүүний боловсруулалтын технологийн процесст хортой, сөрөг нөлөө үзүүлдэг учраас олон улсын худалдааны практикт “торгууль” ногдуулдаг металл/элементүүд;
  - б. ашигт малтмалын бүтээгдэхүүнийг боловсруулах техник, технологийн болон үнийн орчин үеийн түвшинд ялган авах боломжгүй, эдийн засгийн хувьд ашиггүй дагалдах металл/элементүүд.
6. Дагалдах металл/элементийг эдийн засгийн хувьд ашигтайгаар ялган авах боломжийг олгохуйц технологийн дэвшил, зах зээлийн үнэтэй уялдуулан дээр дурдсан дагалдах металл/элементийн жагсаалтыг Засгийн Газар тодорхойлж, шаардлагатай тохиолдолд үе үе хянаж байх.
7. Ашигт малтмалын ордыг ашиглах хүсэлтийн мэдэгдэлийн үндэслэл болгож компаниас ирүүлсэн ТЭЗҮ-д харьцангуй өндөр агууламжтай "дагалдах металл" -ыг ялган авч эдийн засгийн эргэлтэд оруулах боломжийг хэрхэн авч үзсэнийг нягтлан шалгах, бага агуулгатай дагалдах металлыг ялган авах боломжгүй гэж үзсэн бол ямар шалгуураар ийм шийдвэр гаргасныг хянан үзэх ажлыг уул уурхайн зөвшөөрөл олгохын өмнө хийж гүйцэтгэх.
8. Ашигт малтмалын тухай хууль болон холбогдох журмуудад нэмэлт, өөрчлөлт оруулж, дагалдах металлыг цаашдын боловсруулалтын явцад ялган авах эсэхээс үл хамааран АМНАТ ногдуулах агуулгын дээд хязгаарыг тогтоож, шаардлагатай бол үе үе хянаж шинэчилж байх бүрэн эрхийг Засгийн Газарт олгох, Засгийн Газар уг хязгаарыг тогтоохдоо уул уурхайн салбарын олон улсын практикийг үндэслэх бөгөөд металлургийн үйлдвэрлэлийн технологи болон маркетингийн нөхцөл байдалтай уялдуулан шаардлагатай үед шинэчилж байх.
9. Дагалдах металлын АМНАТ-ийн асуудлыг шийдвэрлэх арга замын талаар Засгийн Газрын түвшинд нэгдсэн саналд хүрсний дараа энд санал болгож буй өөрчлөлтийг уул уурхайн салбарыхан нааштай хүлээж авахын хэрээр дагалдах металлын АМНАТ-ийн зохицуулалтад оруулах боломжит өөрчлөлтүүдийг боловсруулах ажилд тэднийг татан оролцуулж, санал, зөвлөмжийг нь авч ажиллах.

## 1. ТАНИЛЦУУЛГА

### 1.1 Ерөнхий мэдээлэл

Монгол Улсын Засгийн газар нь Австралийн Засгийн газартай хамтран Эрдэс баялагт суурилсан Монголын эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангах, эрдэс баялгийн салбарын хөрөнгө оруулалтын орчныг сайжруулах зорилгоор Австрали Улсын Гадаад хэрэг, худалдааны яамны санхүүжилттэй Австрали-Монголын Эрдэс Баялгийн Салбарын Хамтын Ажиллагааны Хөтөлбөр (АМЕР-2)-ийг хэргэжүүлж байгаа билээ. АМЕР-2 хөтөлбөрийг Австрали улсын Гадаад хэрэг, худалдааны яам санхүүжүүлж, Адам Смит Интернэшнл байгууллага Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны (УУХҮЯ) Уул уурхайн бодлогын газрын удирдлага дор хэргэжүүлж байна.

АМЕР-2 хөтөлбөрийн энэхүү бүрэлдэхүүн хэсгийн зорилго нь ашигт малтмалын бүтээгдэхүүнд дагалдах металл/элементүүдэд АМНАТ ногдуулах зохицуулалтад нэмэлт, өөрчлөлт оруулах техникийн удирдамж боловсруулж, дагалдах металл/элементэд АМНАТ ногдуулахтай холбоотой асуудлаар Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам (УУХҮЯ), Сангийн яам (СЯ), Татварын ерөнхий газар(ТЕГ)-ын хооронд үүсээд байгаа зөрүүтэй тайлбар/ойлголтыг шийдвэрлэхэд туслах явдал юм.

Энэхүү тайланд АМНАТ-ийн үндсэн зарчим, зорилтуудыг авч үзсэнээс гадна дагалдах металл/элементүүдэд АМНАТ ногдуулахтай холбоотой олон улсын сайн туршлагыг судалж, түүний дотор “урамшуулал” тооцож болох дагалдах металл/элементүүд болон хайлуулах, цэвэршүүлэх процесст хортой нөлөөтэй “торгууль”-ийн металл/элементийн асуудлыг тусгайлан авч үзсэн болно. Түүнчлэн Монголын зэс, цайр, төмрийн хүдрийн баяжмалд ногдуулсан бодит АМНАТ-ийн тооцооллыг нарийвчлан загварчилж, ижил төрлийн баяжмалыг Баруун Австрали болон Куинсланд мужид үйлдвэрлэж экспортолсон тохиолдолд ногдуулах байсан АМНАТ-ийн хэмжээтэй харьцуулан үзэж, дүн шинжилгээ хийв.

## **1.2 Монгол Улсад одоо мөрдөгдөж байгаа АМНАТ-ийн зохицуулалттай холбоотой асуудал**

Ашигт малтмалын тухай хуулийн 47 дугаар зүйлд заасны дагуу хүдэр, баяжмал зэрэг ашигт малтмалын бүтээгдэхүүнд агуулагдах “дагалдах” металл АМНАТ ногдуулдаг Монголын практик нь захиргаа удирдлагын төвөгтэй байдлыг үүсгэхээс гадна салбарынхны зүгээс ихээхэн шүүмжлэлд өртдөг. Ашигт малтмалын тухай хуулийн 47 дугаар зүйл, холбогдох журамд тусгасан “борлуулалтын үнэлгээ” гэсэн нэр томъёоны үг үсгийг дагалдах металлын хувьд хэтэрхий шууд утгаар нь тайлбарласнаас үүдэлтэй эдгээр тулгарч буй асуудлыг шийдвэрлэхэд энэхүү тайлангийн гол зорилго оршино

Монгол Улсад одоо мөрдөгдөж байгаа аргачлал нь ашигт малтмалын бүтээгдэхүүнд агуулагдах үндсэн металлын борлуулалтын үнээс гадна олборлогчийн бага хэмжээний "урамшуулал" буюу нэмэлт төлбөр авдаг дагалдах металл/элементэд АМНАТ ногдуулдаг олон улсын нийтлэг туршлагад нийцээгүй, давсан практик байдгаараа өвөрмөц бөгөөд дараах төрлийн дагалдах металл/элементүүдэд АМНАТ ногдуулж байна. Үүнд:

- Худалдан авагч тал хайлуулах, цэвэршүүлэх процесст хортой нөлөө үзүүлдэг гэсэн шалтгаанаар "торгууль" ногдуулж, ингэснээр олборлогч талын бүтээгдэхүүний борлуулалтын үнэлгээг бууруулдаг дагалдах металл/элементүүд, болон
- Олборлогч үндсэн металлын борлуулалтын үнэлгээнээс гадна ‘урамшуулал’ буюу нэмэлт төлбөр авдаггүй дараах төрлийн дагалдах металл/элементүүд:
  - Тодорхой хүдэр эсвэл баяжмалаас ялган авах нь технологийн хувьд боломжгүй;
  - Технологийн хувьд ялгаж авах боломжтой ч агуулга нь хэт бага учраас ялгаж авахад эдийн засгийн хувьд ашиггүй.

Үүнээс гадна ямар шалгуураар тухайн дагалдах металл нь АМНАТ-т хамрагдах, яагаад хамрагдах талаар хууль, журамд ямар нэг тайлбар байхгүй, бүрхэг, тодорхойгүй байна. АМНАТ-т хамрагдах металл/элемент тус бүрийн агуулгын босго, хязгаарыг тогтоогоогүй тохиолдолд хуулийг шууд дагаж мөрдөнө гэвэл бүгдэд нь АМНАТ ногдуулах болж байгаа нь утгагүй юм. Нөгөөтэйгүүр, хууль тогтоомжоор эрх бүхий төрийн байгууллагад олгогдсон эрхийн дагуу ямар металл АМНАТ ногдуулах нь тодорхой бус байгаа нь хэрэгжилтийн удирдлагыг төвөгтэй болгож, зарим тохиолдолд дур зоргоороо шийдэх нөхцлийг ч бүрдүүлж байна.

## **2. АМНАТ: ЗАРЧИМ, ЗОРИЛГО, ТӨРӨЛ, ЗАХИРГААНЫ АСУУДЛУУД**

### **2.1 Үндсэн зарчим**

АМНАТ ногдуулах эрх зүйн үндэс нь дараах нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн зарчмууд дээр үндэслэгддэг:

- Газрын хэвлий дэх ашигт малтмал нь төрийн өмч мөн. Ганц нэг орон нутгийн чанартай тогтоосон онцгой зохицуулалтыг эс тооцвол Монгол болон бусад эрдэс баялаг олборлогч улс орнуудын ашигт малтмалын эрх зүйн үндэс нь энэ зарчим байдаг.
- Шулуухан хэлэхэд ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр нь татвар биш, харин тухайн улсын нөхөн сэргээгдэхгүй ашигт малтмалыг олборлох, борлуулах эрхийн төлөө олборлогчдын төлж буй төлөөс юм. Энэ ухагдахууныг улс орны засгийн газрууд (Монгол Улс мөн адил) болон салбарынхан ч өргөн хүрээнд хүлээн зөвшөөрдөг.
- Иймээс АМНАТ-ийг олборлолтын цэг, эсвэл уурхайн аман дээрх хүдрийн үнэлгээн дээр үндэслэж тогтоох ёстой.
- Уурхайн аман дээрх үнэлгээг ашигт малтмалын бүтээгдэхүүнийг харилцан хамааралгүй талд “сунгасан гар”-ын зарчмаар худалдсан үнэд үндэслэн тогтоох учиртай. Хэдийгээр олон улс орнууд АМНАТ- өө бодитой “биелсэн” борлуулалтын үнээс тогтоодог бол Монгол зэрэг зарим улс орнууд борлуулсан эрдсийн хэмжээг зохих зах зээлийн үнээр үржүүлж гарсан борлуулалтын “урьдчилан тооцоолсон” үнэлгээн дээр үндэслэн тогтоодог.
- Иймд уурхайн амнаас цааших эрдсийн боловсруулалтаас үүсэх нэмүү өртөгт АМНАТ ногдуулах ёсгүй. Үнэлгээнд суурилсан АМНАТ-ийн тогтолцоотой Монгол зэрэг олон улс орнууд түүхий хүдрийг ашигт малтмалын бүтээгдэхүүн болгох хүртэл хийгдсэн боловсруулалтын түвшнээс хамаарч АМНАТ-ийн хувь хэмжээг бууруулдаг зарчмыг өргөн хүрээнд мөрддөг бөгөөд үүнийг дараа илүү дэлгэрүүлж авч үзэх болно.

### **2.2 АМНАТ-ийн талаарх сөргөлцсөн зорилтуудыг нэгтгэн уялдуулах**

АМНАТ ногдуулах замаар олох орлогын хэмжээ, АМНАТ-ийн тогтолцооны төрлийг тодорхойлох бодлогыг Засгийн Газрын бусад олон зорилтыг мэдэхгүйгээр томъёолох боломжгүй, жишээ нь:

- Орлого нэмэгдүүлэх;
- Хөрөнгө оруулалт татах, татварын суурийг өргөжүүлэх;
- Эдийн засгийн үр ашгийг нэмэгдүүлэх;
- Тэгш, шударга байдлыг хангах;
- Удирдлагын тодорхой, тогтвортой, хялбар байдал.

Харамсалтай нь Засгийн Газрын зүгээс авч үзэхэд эдгээр зорилтын зарим нь хоорондоо нийцэхгүй, дангаар нь сайжруулах боломжгүй байдаг бөгөөд харин хүлээн зөвшөөрөхүйц түвшинд харилцан буулт хийх замаар зохист тэнцвэрийг олох шаардлагатай болдог.

Бүх Засгийн Газар орлогоо хамгийн их байлгахыг хүсдэг ч АМНАТ-ийн хувийг харьцангуй өндөр болговол ашигт малтмалын хайгуул, ашиглалтаас гадаадын шууд хөрөнгө оруулалтыг дайжуулж, олон улсын хэмжээнд хязгаарлагдмал байдаг хөрөнгө санхүүг илүү өрсөлдөх чадвартай улс руу түлхэнэ. Ийм үзэгдэл сүүлийн үед Монголд тодорхой хэмжээгээр тохиолдоод байгаа.

Нөгөөтэйгүүр, татварын хөнгөлөлт хөшүүргээр дамжуулан гадаадын шууд хөрөнгө оруулалтыг татах нь орлогыг бууруулж, урьдчилан таамаглах аргагүй болгохоос гадна захиргааны төвөгтэй байдлыг үүсгэнэ.

Сонгосон АМНАТ-ийн тогтолцоо нь ашигт малтмалын ордын ашиглалтыг хориглох, хязгаарлах замаар өндөр агууламжтай эрдэс баялгийн нөөцийг эдийн засгийн үр ашигтай, оновчтой байдлаар ашиглахад хөтөлдөг хөрөнгө оруулалтын шийдвэрт саад учруулах ёсгүй. Энэ утгаар нь авч үзвэл түүхий эдийн үнэ болон боловсруулалтын түвшингээс хамаарч ялгаатай байхаар тогтоосон энэхүү үнэлгээнд суурилсан Монголын систем нь эдийн засгийн хувьд харьцангуй үр ашигтай тогтолцоо юм. Удирдахад харьцангуй хялбар, зайлсхийхэд хэцүү, урьдчилан тооцож болдог бөгөөд тогтвортой орлого оруулдаг энэхүү тогтолцоогоор бага зэргийн үр ашиггүй нөхцөл байдлыг нөхөх боломжтой.

Хөрөнгө оруулагчийн хувьд АМНАТ-ийн тогтолцоо тогтвортой, ил тод байх нь маш чухал байдаг. Уурхайн бүтээн байгуулалтад ихээхэн хэмжээний анхны хөрөнгө оруулалт хийхийн өмнө тогтвортой байдлын гэрээ байгуулахыг хөрөнгө оруулагчид эрмэлздэг бөгөөд тэдний хувьд АМНАТ-ийн тогтолцоо тогтвортой, ил тод байхыг маш ихээр хүсдэг. Тогтвортой байдлын гэрээ нь урт хугацаандаа металл эрдсийн үнэ өсөх зэргээр нөхцөл байдал өөрчлөгдөх үед АМНАТ-ийн хувийг нэмэгдүүлэх Засгийн Газрын боломжийг хязгаарлахаас гадна дараа дараагийн хөрөнгө оруулагчид нь түрүүчийн хөрөнгө оруулагчидтай адил тэнцүү нөхцлийг Засгийн Газраас хүлээх сөрөг үр дагавартай байдаг. Гэсэн хэдий ч Засгийн Газар тухайн уурхайн бүтээн байгуулагчдын хэрэгцээг хангахын тулд ийм төрлийн гэрээ байгуулах шаардлагатай болдог. Ингэснээр эцэст нь АМНАТ-ийн олон тогтолцоо үүсч, улмаар түүнийг удирдахад төвөгтэй болохоос гадна өмнөх хөрөнгө оруулагчдад олгож байсан таатай нөхцлүүдийг шинэ хөрөнгө оруулагчдад олгохгүй, тэгш бус хандлага үүсгэсэн гэх гомдол гарах магадлалтай байдаг.

### 2.3 АМНАТ нь уул уурхайн татварын бүрэлдэхүүн хэсэг

Эдийн засаг бизнесийн төслүүдээс төлдөг олон жижиг төлбөр, хураамж, Засгийн Газрын эзэмшлийн хувь хэмжээг эс тооцвол уул уурхайгаас оруулдаг төсвийн орлогын гол эх үүсвэрийг АМНАТ, Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар (ААНОАТ) бүрдүүлдэг.

АМНАТ болон ААНОАТ-ын орлогын эзлэх хувь хэмжээ улс орнуудад харилцан адилгүй байдаг бөгөөд зөвхөн АМНАТ-ийн хувь хэмжээнд үндэслэн шууд харьцуулалт хийх нь учир дутагдалтай бөгөөд төөрөгдүүлэх талтай. Уул уурхайн татварын янз бүрийн тогтолцооны харьцуулалтыг татварын багцаар нь буюу бүх бүрэлдэхүүн хэсгийг нэгтгэсэн нийт орлого дээр нь хийвэл илүү учир утгатай болох юм.

Хавсралт 2-т уул уурхай зонхилдог улс орнуудын уул уурхайн татварын тогтолцооны бүрэлдэхүүн хэсгүүдийн талаархи үндсэн мэдээллийг оруулав. Монгол Улс дэлхийн хамгийн өндөр АМНАТ-ийн тогтолцоотой улсын тоонд ордог бөгөөд ААНОАТ-ын хувь хэмжээ нь олон улсын түвшинтэй харьцуулахад харьцангуй бага буюу 25%-тай байгаа нь үүнийг бага зэрэг тэнцвэржүүлж өгдөг байна. Энэ тал дээр Монгол Улс бусад олон улс орнуудын адилаар удирдахад нарийн төвөгтэй байдаг ААНОАТ-аас илүүтэйгээр, зайлсхийхэд хэцүү АМНАТ-ийн бүрэлдэхүүн хэсэгт ач холбогдол өгч байна.

Энэхүү хандлагыг Монгол Улсын 2019 онд олборлох салбарт ногдуулсан нийт татварын бүрэлдэхүүн хэсгээс буюу Хүснэгт 1-ээс харж болно. Үүнд бүх ногдуулсан татварын 45.4%-ийг АМНАТ эзэлж байсан бол ААНОАТ 27.7%-ийг эзэлж, харин нийт татварын багахан хэсэг (231.7 тэрбум төгрөг буюу 7.3%-ийг газрын тосны салбар бүрдүүлсэн байна.

Монгол Улсад АМНАТ-ийн орлого сүүлийн жилүүдэд эрс нэмэгдсэн нь түүхий эдийн үнэ болон үйлдвэрлэлийн хэмжээ өссөнтэй холбоотой бөгөөд түүхий эдийн үнэ, үйлдвэрлэлийн өсөлтөөс улбаалан ашиг, ААНОАТ-ын орлого ч мөн нэмэгдсэн байна.

2019 он	Тэрбум төгрөг	Сая ам. доллар	%
АМНАТ	1425.7	542.5	45.4%
ААНОАТ	869.2	330.7	27.7%
НӨАТ	43.1	16.4	1.4%
Бусад	800.5	304.6	25.5%
НИЙТ	3138.5	1194.3	100.0%

**Хүснэгт 1.** Олборлох салбарын татварын орлогын эх үүсвэрүүд (Эх сурвалж: Сангийн яам, ОУИТБС-ын 2020 оны тайлан)

Засгийн Газрын орлогыг АМНАТ, ААНОАТ-аас гадна олон тооны бусад татвар, төлбөр, хураамж бүрдүүлдэг. Эдгээр нь ганц нэгээрээ маш бага боловч нэгдсэн дүнгээрээ Засгийн Газрын нийт орлогын нэлээд хэсгийг эзэлдэг бөгөөд ихэнх нь (capital gain tax-CGT)-хөрөнгийн олзын татвар (ХОТ), нэмэгдсэн

өртгийн албан татвар (НӨАТ), импорт, экспортын гаалийн татвар, онцгой албан татвар, хүү болон ногдол ашиг гадаад руу шилжүүлэхэд суутган тооцох татвар, хөрөнгө шилжүүлэх тэмдэгтийн хураамж, цалин хөлс болон бусад санхүүгийн ажил гүйлгээний татвар гэх мэт эдийн засгийн өргөн хүрээнд ногдуулдаг татвар, хураамжууд байдаг. Ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөр, түрээс, хяналт шалгалтын янз бүрийн хураамж, орон нутгийн засаг захиргаанаас тогтоодог зарим хэлбэрийн хувь хэмжээ гэх мэт бусад ногдуулдаг төлбөр, хураамж нь салбарын онцлогоороо ялгаатай. Монгол Улсын хувьд олборлох салбараас авдаг ийм төлбөр, хураамж нь олборлох салбарын нийт татварын ¼ орчимтой тэнцдэг бөгөөд эдгээрийн ихэнх нь зайлсхийхэд амаргүй татвар, хураамжууд байна.

Хавсралт 3-т АМНАТ хураан авах эрхийг Засгийн Газарт олгосон Монгол Улсын бүх хууль тогтоомж, тэдгээрийн холбогдох хэсгүүдийн жагсаалтыг оруулав. Эдгээрийн хамгийн гол нь 2006 онд батлагдаж, түүнээс хойш олон удаа чухал өөрчлөлтүүд орсон (хамгийн сүүлд 2019 онд) Ашигт малтмалын тухай хууль (АМТХ) болон холбогдох журмууд юм. АМТХ нь Монгол Улсын Үндсэн хуулийн хүрээнд хэргэжиж байгаа бөгөөд Газрын хэвлийн тухай хууль, Татварын ерөнхий хууль болон бусад татварын хууль тогтоомж, Хөрөнгө оруулалтын тухай хууль болон бусад хууль тогтоомжуудтай харилцан уялдаатай үйлчилж байна.

## 2.4 АМНАТ-ийн төрлүүд

"АМНАТ-ийн суурь"-ийг "АМНАТ-ий хувь хэмжээ"-ээр үржүүлэх замаар АМНАТ-ийг тооцдог. АМНАТ-ийн өөр өөр тогтолцоо байдаг бөгөөд тухайлсан АМНАТ тус бүрээрээ ялгагддаг. Үүнд:

- Эзлэхүүн, эсвэл жин: куб метр, эсвэл тонн тутамд тогтоосон төлбөр;
- Үнэлгээ (үнэлгээнд суурилсан): Бодитой биелсэн нийт, эсвэл цэвэр “борлуулалтын үнэлгээ”-ний хувиар, эсвэл Монгол Улсад мөрдөж байгаа шиг албан ёсоор зарлагдсан үнийг жишиг болгон тооцсон “борлуулалтын үнэлгээ”-ний хувиар;
- Ашиг/түрээс: тухайлан энэ зориулалтын дагуу тооцдог ашгийн хувиар, эсвэл төсөл бүрээс авах эдийн засгийн түрээсийн дүнд эзлэх хувиар (энэ сүүлийнх нь одоогоор зөвхөн газрын тосны салбарт хэрэглэгдэж байна);
- Хосолмол: ерөнхийдөө ашигт суурилсан АМНАТ, гэхдээ орлогын тогтвортой байдлыг хангахын тулд хамгийн бага хувиар бодсон үнэлгээнд суурилсан.

Ашиг, түрээс-д суурилсан АМНАТ нь АМНАТ төлөгчийн төлбөрийн чадварын хувьд эдийн засгийн үр ашигтай, шударга хэдий ч хэрэгжүүлэхэд төвөгтэй, нөгөө талаар зайлсхийхэд хялбар, орлогын урсгалын хувьд тогтворгүй, ялангуяа төслийн эхний үе шатанд ихэнхдээ маш бага, эсвэл огт орлогогүй байдаг.

Иймээс дээрх сул талаас зайлсхийхийн тулд ихэнх уул уурхайн орнууд үнэлгээнд суурилсан АМНАТ-ийн тогтолцоог сонгосон байдаг бөгөөд Монгол Улс ч мөн тэдгээрийн нэг болж, АМНАТ-ийн хэмжээг түүхий эдийн үнэ болон боловсруулалтын түвшингээс хамааруулан тооцох тогтолцоог сонгон хэрэгжүүлсэн байна.

Зураг 1-д энэхүү илтгэлийн 2.2-р хэсэгт дурьдсан АМНАТ-ийн төрлүүд нь Засгийн Газрын зорилгод хэрхэн хүргэхийг тус бүрээр нь бүдүүвчлэн харуулав.



Зураг 1. Засгийн газрын зорилтыг биелүүлэхэд АМНАТ-ийн төрлүүдийн гүйцэтгэх үүрэг




## 2.5 Үнэлгээнд суурилсан АМНАТ (*ad valorem*)

Өмнө дурьдсанчлан олон улсад үнэлгээнд суурилсан АМНАТ-ийн тогтолцоог хамгийн түгээмэл хэрэглэдэг. АМНАТ-ийн орлого нь уурхайн аман дээрх хүдрийн үнээс хамааралтай бөгөөд маш бага хэмжээний түүхий хүдрийг уурхайн аман дээр, ихэнхийг нь тодорхой боловсруулалт хийсний дараа борлуулдаг. Ашигт малтмалын бүтээгдэхүүнийг “сунгасан гар”-ын зарчмаар харилцан хамааралгүй этгээдэд борлуулах анхны цэг дээрх үнэ нь татварын албаны үнийн найдвартай мэдээлэл болдог. Үүний дараа АМНАТ-ийн хувь хэмжээг тогтоох хоёр хувилбар байдаг:

- борлуулалт хэрэгжсэн цэг дээрх борлуулалтын үнэд тохирсон АМНАТ-ийн хувийг хэрэглэх;
- эсвэл Зураг 2-т үзүүлсний дагуу хоёр цэгийн хооронд гарсан боловсруулалтын зардлыг буцаан тооцох замаар АМНАТ-ийн суурь үнэлгээг тооцох.

Эдийн засгийн үр ашгийг дээшлүүлж, боловсруулах үйлдвэрлэлд оруулах хөрөнгө оруулалтыг дэмжихийн тулд түүхий хүдрээс цэвэр металл хүртэлх нэмүү өртгийн гинжин хэлхээний дагуух АМНАТ-ийн хувь хэмжээ нь боловсруулалтын түвшин дээшлэхийн хэрээр буурч байх ёстой.




Зураг 2. Нэмүү өртгийн гинжин хэлхээний дагуух АМНАТ ногдуулах боломжтой цэгүүд. (Эх сурвалж: Modified from Guj et al, 2012)

(Эх

### 2.5.1 Татварын цэг / АМНАТ-ийн суурь үнэлгээ

Татварын алба АМНАТ ногдуулах борлуулалтын зохих суурь үнэлгээг тогтоохдоо Зураг 3-т харуулсан үнэлгээний аль нэгийг сонгох шаардлагатай болдог.

- “Бодитоор биелсэн” борлуулалтын үнэлгээ, эсвэл
- Борлуулсан бүтээгдэхүүнд агуулагдах эрдэс(үүд)-ийн борлуулалтын “урьдчилж тооцоолсон” үнэлгээ.



**Зураг 3.** Үнэлгээнд суурилсан AMNAT-ийн тогтолцоон дахь суурь үнэлгээний схемчилсэн ангилал

Цаашилбал, хэрэв борлуулалтын бодитоор биелсэн үнэлгээг AMNAT-ийн суурь болгон сонгосон бол:

- Ямар нэгэн зардлын хасагдуулгагүй, борлуулалтын үеийн борлуулалтын нэхэмжлэлийн үнэлгээ; эсвэл
- Нэмүү өртгийн гинжин хэлхээний дагуу тухайн борлуулалтын цэг хүртэл гарсан тодорхой зардлуудыг хассан цэвэр үнэлгээ хоёрын аль нэг нь байна.

Мөн хүдэр, эсвэл баяжмал дахь металл/элемент тус бүрийн агууламжийг борлуулалтын өдрийн зах зээлийн үнээр, эсвэл AMNAT-ийн журмаар тогтоосон хугацааны дундаж үнээр үржүүлэн тооцож, төлбөрийг хүлээн авсан борлуулалтын нийт үнэлгээг AMNAT-ийн суурь болгон авах сонголт байж болох юм. Үнэлгээнд суурилсан AMNAT-ийн тогтолцоог ашигладаг улс орнуудын дунд "урьдчилж тооцоолсон" борлуулалтын үнэлгээ болон "бодитоор биелсэн" борлуулалтын үнэлгээг сонгон авсан улс орнуудын тоо үндсэндээ эн тэнцүү байдаг.

Борлуулалтын “урьдчилж тооцоолсон” үнэлгээг AMNAT-ийн суурь болгодог бусад орнуудтай харьцуулахад Монгол Улс нь борлуулагчийн нэмэлт төлбөр буюу “урамшуулал” аваагүй дагалдах металлын үнийг борлуулалтын суурь үнэлгээнд оруулан тооцдоггоороо ялгаатай бөгөөд энэ талаар дараа нь нарийвчлан үзнэ.

Монгол Улсын AMNAT-ийн тогтолцоонд борлуулсан ашигт малтмалын бүтээгдэхүүнд агуулагдаж буй металл/элемент бүрийн агууламжийн хэмжээг нэр хүндтэй эх сурвалж дээр тогтмол зарлагддаг зах зээлийн үнийн өмнөх сарын дунджаар үржүүлэх замаар борлуулалтын нийт суурь үнэлгээг тооцоолон гаргадаг. АМТХ-ийн 47.14 дүгээр зүйл, Засгийн Газрын 2013 оны 131, 2016 оны 81, 2019 оны 342, 465 дугаар тогтоолуудын дагуу Монгол Улсын Засгийн Газар экспортод гаргадаг ашигт малтмалын бүтээгдэхүүний олон улсын зах зээлийн үнийн мэдээллийг тогтмол олон нийтэд мэдээлдэг. 2021 оны 2-р сарын 5-ны өдөр зарласан эрдэс түүхий эдийн үнэ, эх үүсвэрийг Хүснэгт 2-т, төрөл бүрийн жонш, нүүрсний чанараар нь ангилсан үнийн жагсаалтыг Хавсралт 4-т үзүүлэв.

Металл	Ам.доллар/ тонн	Эх сурвалж
Цайр	2,707.70	https://www.lme.com/
Зэс	7,970.50	


Хар тугалга	2,014.93	
Цагаан тугалга	21,955.45	
Хөнгөн цагаан	2,003.80	
Молибден	22,527.91	
Төмрийн хүдэр (56%-ийн агуулгатай)	135.98	/www.umetal.com/
Төмрийн баяжмал (60%-ийн агуулгатай)	154.83	
Гянт болдын баяжмал (65% -ийнагуулгатай)	13,645.08	www.asianmetal.com
Манганы хүдэр (36%-ийн агуулгатай)	195.88	www.asianmetal.com
Алт (Төгрөг/грамм)	170,985.19	http://www.mongolbank.mn/
Мөнгө (Төгрөг/грамм)	2,276.87	

**Хүснэгт 2.** Монгол Улсын Засгийн газраас 2021 оны 2 дугаар сарын 5-ны өдөр зарласан төмөр, үндсэн болон үнэт металлын үнэ

Нийт борлуулалтын үнэлгээг тооцоход ашигладаг "жишиг" үнийг Монгол Улсын хилийн цаана байрлах нийлүүлэлтийн цэгүүд дээрх үнийг үндэслэн тогтоодог. Жишээлбэл, Лондонгийн металлын бирж(ЛМБ)-ийн үнийг CIF нөхцлөөр нэр заасан улс дахь агуулах хүртэл, төмрийн хүдрийн үнийг CFR-ийн нөхцлөөр нэр заасан боомт хүртэл (тухайлбал Тяньжин, эсвэл Чиндао) тогтоосон байдаг. АМНАТ-ийн суурь болгон ашигладаг борлуулалтын нийт тооцоолсон үнэлгээг ийнхүү хилийн цаана байрлах цэгүүд дээрх үнийг үндэслэн тогтоосноороо Монгол Улс хилээсээ цааш гарсан тээврийн зардалд АМНАТ ногдуулж байгаа юм. Ийм учраас яг ижил хувь хэмжээгээр, борлуулалтын “бодитоор биелсэн” үнэлгээнд АМНАТ ногдуулдаг улс орнуудыхтай харьцуулахад Монгол Улсад АМНАТ илүү өндөр дүнтэй байна гэсэн үг юм.

Засгийн Газрын 2019 оны 342 дугаар тогтоолоор батлагдсан “Гадаадын зах зээлд борлуулсан нүүрс, төмрийн хүдэр, төмрийн хүдрийн баяжмалд ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр ногдуулах борлуулалтын үнэлгээ тооцох журам”-д борлуулалтын нийт “урьдчилан тооцоолсон” үнэлгээний аргад үл хамаарах зүйлийг тусгасан байдаг. Энэхүү журамд зааснаар нүүрс, төмрийн хүдэр, төмрийн хүдрийн баяжмалын гэрээний үнэ болон АМТХ-ийн дагуу олон улсын худалдаанд хүлээн зөвшөөрөгдсөн тухайн сарын дунжийг тогтоох зарчмыг үндэслэн тухайн бүтээгдэхүүний олон улсын зах зээлийн үнийг баримтлан нийтэд зарласан үнийн зөрүү нь 30 болон түүнээс доош хувиар бага бол АМНАТ ногдуулах борлуулалтын үнэлгээг Монгол Улсын хилийн өртөө хүртэл бараа нийлүүлэх нөхцлөөр, хэлцлийн үнийн аргаар тодорхойлох бөгөөд хилийн өртөө хүртэл гарсан зардал ороогүй бол түүнийг нэмж тооцно гэж заажээ. Энэ нь бусад олон улс орнуудад түгээмэл ашиглагддаг АМНАТ-ийн “бодитоор биелсэн” суурь үнэлгээ байх бөгөөд үүнийг Зураг 2-т харуулснаар V2 буюу ашигт малтмалын бүтээгдэхүүний хил дээрх, эсвэл эскпортын боомт дээрх FOB үнэ байна.

Үнэлгээний бүрэлдэхүүн хэсгүүдийн хоорондын хамаарал ба төрөл бүрийн АМНАТ-ийн суурийг тодорхойлохын тулд тэдгээрийг хэрхэн нэгтгэж үздэгийг Зураг 4-т харууллаа. Энэ зурагт “бодитоор биелсэн” болон “урьдчилан тооцоолсон” АМНАТ-ийн суурь үнэлгээний ялгааг онцлохоос гадна Монгол Улсын зохицуулалт бусдаас юугаараа ялгарч байгааг онцлон харуулахыг зорив.



Зураг 4. “Хайлуулах үйлдвэрийн цэвэр үнэ” (NSV) болон үнэлгээнд суурилсан АМНАТ тогтоох суурь үнэлгээ

Баяжмалд хайлуулагчийн төлсөн үнэ (NSV) болон үнэлгээнд суурилж АМНАТ тогтоодог системд суурь болгон ашигладаг бусад нийт болон цэвэр үнэлгээ хоорондын харилцааг Зураг 4-т харууллаа.

### 2.5.2 АМНАТ-ийн хувь хэмжээ

АМНАТ-ийг үнэлгээнд суурилж тогтоох тохиолдолд Засгийн Газар АМНАТ-ийн орлогыг зорьсон түвшинд хүргэхийн тулд АМНАТ-ийн нэг, эсвэл хэд хэдэн хувь хэмжээг тогтоож хуульчлах шаардлагатай болдог. Зураг 5-д харуулснаар АМНАТ-ийн хувь хэмжээг тогтоох арга нь улс бүрд өөр өөр бөгөөд түүхий эдийг бүхэлд нь, эсвэл тус бүрээр хамруулж тогтоодог:

- I. Бүх ашигт малтмалын бүтээгдэхүүнд нэг ижил хувь хэмжээтэй;
- II. Боловсруулалтын түвшин дээшлэх тусам буурдаг хувь хэмжээ (жишээлбэл Баруун Австрали(БА)-д);
- III. Түүхий эдийн үнээс хамаарч өсөн нэмэгдэх хувь хэмжээ (жишээлбэл Куинсланд(Кл)-д);
- IV. Боловсруулалтын түвшний өсөлтөөс хамаарч буурах болон түүхий эдийн үнийн өсөлтөөс хамаарч өсөн нэмэгдэхээр хосолсон хувь хэмжээ (жишээлбэл Монгол Улсад).

Уул уурхайн үйлдвэрлэл ихтэй улс орнуудын АМНАТ-ийн хувь хэмжээг Хавсралт 2-т үзүүлэв. Өндөр татвартай улс орныг тодорхойлоход зөвхөн АМНАТ-ийн хувь хэмжээг дангаар нь харьцуулах нь ямар ч утга илэрхийлэхгүй бөгөөд харьцуулалтыг ААНОАТ болон бусад гол татвар, хураамжийг хамруулж Засгийн Газрын нийт хураах татварын хэмжээгээр харьцуулалт хийх нь зүйтэйг энд онцлон тэмдэглэж байна. Энэ хүрээнд авч үзвэл Монгол Улс дэлхийд хамгийн өндөр АМНАТ-тэй байгаа ч олон улсын түвшинд харьцангуй багад тооцогддог ААНОАТ-аар нийт татварын орлогыг тодорхой хэмжээнд барьж байна. 2019 онд олборлох салбарт ногдуулсан нийт татварын дөнгөж ¼ гаруйг ААНОАТ-ын орлого эзэлж байсан бөгөөд энэ нь АМНАТ-ийн орлогоос бараг 2 дахин бага байв (Хүснэгт 1).

Бүх ашигт малтмалын бүтээгдэхүүнд нэг ижил хувь хэмжээ тогтоох (I) нь олон улс орнуудад ашиглагддаг хэдий ч эрдэс түүхий эдийг гүнзгий боловсруулах үйлдвэрлэлд хөрөнгө оруулах сонирхлыг сааруулдаг тул хүсэх тогтолцоо биш юм.


Энэ шалтгааны улмаас Монгол Улс, БА зэрэг зарим улс, бүс нутагт боловсруулалтын түвшний өсөлтөөс хамаарч буурдаг хувь хэмжээг сонгосон байдаг (II), жишээ нь, БА-д АМНАТ-ийн хувь хэмжээ хүдэрт 7.5%, баяжмалд 5%, металлд 2.5% байдаг.



**Зураг 5.** Үнэлгээнд суурилсан АМНАТ-ийн тогтолцоонд ашиглагддаг АМНАТ-ийн хувь хэмжээг ангилах бүдүүвч зураг

Куйнсланд зэрэг муж нутгуудад түүхий эдийн үнэ нэмэгдэхийн хэрээр тасралтгүйгээр өсөн нэмэгдэж байх АМНАТ-ийн хувь хэмжээг ашигладаг (III). Уул уурхайн компаниуд өмнөх улиралд хийсэн төлбөрийн 1/3 тэй тэнцэх хэмжээний АМНАТ-ийг сар бүр урьдчилан төлдөг. Дараа нь улирлын эцэст Засгийн Газраас тогтмол нийтэлдэг түүхий эдийн дундаж үнэ болон түүнд харгалзах хувь хэмжээн дээр үндэслэн АМНАТ-ийн эцсийн тооцоог хийж тохируулдаг.

Монгол Улс нь дотоодод борлуулсан нүүрс, түгээмэл тархацтай ашигт малтмалаас бусад бүх эрдэс бүтээгдэхүүнд үндсэн хувь болох 5% дээр үнийн өсөлтөөс хамаарсан өсөн нэмэгдэх хувь хэмжээ болон боловсруулалтын түвшингээс хамаарч шатлан буурах хувь хэмжээг хэрэглэдэг хосолмол тогтолцоог ашиглагдаараа онцлог юм (Зураг 6).



**Зураг 6.** Монгол Улсын өсөн нэмэгдэх АМНАТ-ийн хувь хэмжээ бүхий тогтолцоог харуулсан бүдүүвч зураг

Монгол Улсын АМНАТ-ийн эрх зүйн орчныг хамруулсан Хавсралт 3-т одоо мөрдөж буй АМНАТ-ийн өсөн нэмэгдэх хувь хэмжээг харуулав. Ерөнхийдөө өсөн нэмэгдэх хувь хэмжээ нь түүхий эдийн үнэ бага байхад 0%, өндөр байвал 5%-ийн хооронд байхаар хэлбэлздэг. Үүнд хамаарахгүй зүйл бол зэсийн хүдэр, баяжмал бөгөөд зэсийн үнэ тонн тутамд 9000 доллараас давсан тохиолдолд зэсийн хүдэр, баяжмалд 30% -ийн нэмэлт АМНАТ ногдуулна. Ийнхүү үнэ өндөр байх үед Хүснэгт 3-т үзүүлснээр зэсийн баяжмалд 15%, металлд 5%-ийн нэмэлт АМНАТ тус тус ногдохоор байна.

№	Бүтээгдэхүүний нэр, төрөл	Хэмжих нэгж	Үнэлгээнд ашиглах лавлагаа	Зах зээлийн үнийн зааг /Ам.доллар/	Бүтээгдэхүүний боловсруулалтын түвшингээс хамаарч [үндсэн нөөц ашигласны төлбөр дээр] нэмж
---	---------------------------	-------------	----------------------------	------------------------------------	--

			бүтээгдэхүүний төрөл	ногдуулах нөөц ашигласны төлбөрийн хувь			
				Хүдэр	Баяжмал	Бүтээгдэхүүн	
1	Зэс	Тонн	Эрдэс бүтээгдэхүүн дэх зэс метал	0-5000	0.00	0.00	0.00
				5000-6000	22.0	11.0	1.00
				6000-7000	24.0	12.0	2.00
				7000-8000	26.0	13.0	3.00
				8000-9000	28.0	14.0	4.00
			9000 <	30.0	15.0	5.00	

**Хүснэгт 3.** Монгол Улсын зэсийн бүтээгдэхүүний өсөн нэмэгдэх АМНАТ-ийн хувь хэмжээний жишээ

### 3. ХҮДЭР, БАЯЖМАЛЫН ОЛОН УЛСЫН МАРКЕТИНГ, ҮНЭЛГЭЭ

#### 3.1 Борлуулалтын гэрээний төрлүүд

##### 3.1.1 Ерөнхий зүйл

Ашигт малтмалын бүтээгдэхүүнийг тухайн түүхий эдээсээ хамааран боловсруулалтын аль ч шатанд борлуулж болно.

Төмрийн хүдэр, боксит зэрэг түүхий эдийн бөөний, шууд борлуулалтыг (DSO) буталсан ба шигшсэн, эсвэл бага хэмжээгээр баяжуулсан, хольсон хэлбэрээр хийдэг.

Үүнтэй харьцуулахад үндсэн металлын хүдэр (жишээлбэл, зэс, хар тугалга, цайр, никель)-ийн борлуулалт ерөнхийдөө маш хязгаарлагдмал бөгөөд бүс нутгийн шинж чанартай байна. Үндсэн металлын хүдрийг их төлөв уурхайн талбай дээр боловсруулж баяжуулсан байдлаар экспортолж, борлуулдаг. Монгол Улсын хувьд баяжмалын түвшинд боловсруулан гаргадаг бол гүнзгий боловсруулах үйлдвэрлэл хөгжсөн, хүчин чадал өндөртэй улс орнууд металл хэлбэрт нэлээн ойртуулсан (жишээ нь блистер “хар” зэс, зэсийн катод, никель хайлш болон нунтаг гэх мэт) түвшинд боловсруулан гаргаж байна.

Төрөл бүрийн металлын зах зээлийн стандарт үзүүлэлтүүд болон өдөр тутмын үнэ олон нийтэд нээлттэй байдаг тул тухайн бүтээгдэхүүний боловсруулалтын түвшин дээшилж, цэвэршүүлсэн металл руу дөхөхийн хэрээр түүнд тохирох “борлуулалтын үнэлгээ”-г тодорхойлоход хялбар байдаг.

Хүдэр, баяжмал зэрэг ашигт малтмалын бүтээгдэхүүнийг хоёр төрлийн гэрээгээр борлуулдаг:

- Дунд болон урт хугацааны нийлүүлэлтийн ‘offtake’ гэрээ;
- Зуучлагч/худалдаа эрхлэгчдээр дамжих Спот гэрээ.

“Offtake” гэрээг ерөнхийдөө уул уурхайн олборлогч болон тодорхой хайлуулах/цэвэршүүлэх үйлдвэрлэл эрхэлдэг компаниудын хооронд байгуулдаг бөгөөд зуучлагчдыг оролцуулдаггүй. Харин Спот арилжаа нь ихэвчлэн завсрын худалдаа эрхлэгчдээр дамжиж хийгддэг бөгөөд ашигт малтмалын түүхий эд үйлдвэрлэгч болон хэрэглэгч хооронд ийм спот гэрээ байгуулагдах нь тун ховор байдаг.

##### 3.1.2 Төмрийн хүдэр, баяжмалын борлуулалт

Хүдэр, эсвэл баяжмалын бөөний борлуулалтыг ихэвчлэн дунд болон урт хугацааны нийлүүлэлтийн гэрээгээр хийдэг. Жишээлбэл, төмрийн хүдрийг буталж шигшсэн гематит-гетит-(лимонит) хүдэр буюу шууд борлуулах хүдэр (DSO), мөн баяжуулсан болон хольсон хүдэр, (ихэвчлэн магнетит) баяжмал, хорголжин, нунтаг, шахмал зэрэг хэд хэдэн төрлийн бүтээгдэхүүн хэлбэрээр борлуулдаг. DSO-г биет байдлаар нь том ширхэглэгтэй (өөрөөр хэлбэл 6.3 мм-ээс их, 31.5 мм-ээс бага хэмжээтэй) эсвэл жижиг ширхэглэгтэй (6.3 мм-ээс бага) гэж ангилдаг.

Өнгөрсөн хэсэг хугацаанд хольц багатай, өндөр агууламжтай (> 60% Fe) гематитын ширхэглэг хүдрийг ижил найрлагатай, жижиг ширхэглэгтэй гематитын хүдэртэй харьцуулахад 20-30%-ийн урамшуулалтай борлуулдаг байв. Гэвч домен зуухны ажиллагаанд өөрчлөлт орсноор энэ хэмжээ 5-10% -иас бага болж буураад байна. Писолит хэмээн нэрлэгддэг жижиг бөмбөлөг хэлбэртэй гетит хэлбэрээр



ихэвчлэн тохиолддог сувгийн тогтоц бүхий төмрийн ордууд (CID) ерөнхийдөө бага агуулгамжтай (54% орчим) боловч барьцалдах чанар сайтай байдаг учраас эрэлт ихтэй байдаг.

Төмрийн хүдрийн томоохон олборлогч ба ган хайлуулах үйлдвэрийн хооронд амжилттай хийсэн нэг жилийн гэрээний үнийг жишиг (benchmark) үнэ болгон жилийн нийлүүлэлтийн гэрээнд ашигладаг байв. Сүүлийн жилүүдэд спот болон фьючерс зах зээл идэвхтэй хөгжиж байгаа хэдий ч олон давтамжтай ачилт хийх жилийн гэрээ нийтлэг хэвээр байна. Гэхдээ ерөнхийдөө харьцангуй богино хугацаагаар, өдөр тутмын үнийн индексэд суурилсан, нэгээс гурван сарын өдөр тутмын спот зах зээлийн үнийн дундаж утгаар үнийг тогтоож байна. CFR нөхцлөөр Хятадын боомтод (жишээ нь Тяньжин, эсвэл Чиндао) нийлүүлэгддэг, төмрийн 58-65%-ийн агуулгатай, P<sub>2</sub>O<sub>5</sub>, Al<sub>2</sub>O<sub>3</sub>, SiO<sub>2</sub>, S болон бусад хольцын нормчлогдсон агуулга бүхий жижиг ширхэглэлтэй хүдэрт зориулан стандарт үзүүлэлтийн индекс (жишээлбэл, Platt's IONEX эсвэл Metal Bulletin's MBIОI индекс)-ийг боловсруулан тодорхойлсон байдаг. Монголын Улсын төмрийн хүдэр дэх хольц(дагалдах элемент)-ын агууламжийн зөвшөөрөгдөх хязгаар болон "торгуул"-ийн хувь хэмжээг төмрийн хүдрийн кейс судалгааны үр дүнгийн хамт доор дэлгэрэнгүй авч үзнэ. Борлуулсан, ачуулсан хүдэр дэх төмрийн агуулга нь ашигласан индексээс өөр байх тохиолдолд агуулгын нэгж хувьд ногдох үнийг ашиглан тухайн бодит агуулгад нь хувь тэнцүүлэн үнийг тодорхойлдог.

Заримдаа төмрийн хүдэр болон үндсэн металлын баяжмал дахь хольц нь зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс их байх тохиолдол байдаг бөгөөд ийм хүдэр, баяжмалыг борлуулах боломжгүй, эсвэл ихээхэн хямдруулсан үнээр борлуулах болдог. Тухайн хүдэр, баяжмалыг худалдан авсан этгээд нь энэхүү “бохир” хүдэр, баяжмалыг чанар сайтай өөр хүдэр, баяжмалтай холих замаар үнэ цэнийг нь өсгөдөг байна.

### **3.1.3 Үндсэн металлын баяжмалын борлуулалт**

Үндсэн металлын баяжмал нь хагас боловсруулсан эрдэс бүтээгдэхүүн бөгөөд тэдгээрт зах зээлийн стандарт үзүүлэлт, өдөр тутмын тогтсон үнэ байдаггүй. Эдгээрийг ихэвчлэн CIF нөхцлөөр дараах замаар борлуулдаг:

- Уурхай болон хайлуулагч/цэвэршүүлэгчийн хооронд дунд болон урт хугацааны ерөнхий ('Frame') гэрээ байгуулах;
- Худалдаачдаар дамжуулж спот гэрээгээр.

Үндсэн металлын баяжмал нь "шинэ" металлын нийлүүлэлтийн чухал бүрэлдэхүүн хэсэг бөгөөд олборлогчтой харилцан хамааралгүй хайлуулагч/цэвэршүүлэгчдэд худалдсан "арилжааны" баяжмалын хэмжээ нь харилцан хамааралтай (нэг харьяалалтай) хайлуулах/цэвэршүүлэх үйлдвэрт нийлүүлсэн "өөрийн" баяжмалын хэмжээнээс бараг хоёр дахин илүү байна. Жишээ нь, зэсийн хувьд, уусгалт/электролиз (SX/EW)-ын аргаар үйлдвэрлэсэн катодын зэс (нийт зэсийн 30 орчим хувь)-ийг хасаж тооцвол дээр дурдсан “бусдын” болон “өөрийн” хайлуулагч/цэвэршүүлэгчид худалдсан/нийлүүлсэн харьцаа 43% ба 27% тус тус байна.

Урт хугацааны гэрээгээр төлбөрийн чадвартай (1-р зэрэглэлийн) худалдан авагчид нийлүүлж буй бол ачилт хийгдэх үед гэрээний үнийн дүнгийн дийлэнх хэсгийн (90%) төлбөрийг хийснээр өмчлөлийн эрх шилжих бөгөөд үлдэгдэл төлбөр(10%)-ийг уг баяжмалын агуулгын сорьцын шинжилгээний хариу хайлуулагчаас гарсны дараа төлдөг. Төлбөрийн чадвар багатай (2-р зэрэглэлийн) худалдан авагчдын хувьд баяжмал боомтоос гарсан даруйд төлбөрийг бүрэн (100%) хийхийг шаарддаг.

Бараа борлуулах үнийн хамрах хугацаа, үнэ тооцох сарыг гэрээний нөхцөлд тодорхой тусгаж өгдөг бөгөөд энэ нь ихэнхдээ бараа ачигдсан, эсвэл худалдан авагчид очсон сарын тооцооны дундаж үнэ байдаг. Үүнийг МАМА систем (month after the month of arrival-хүргэлт хийгдсэн сарын дараа сар) гэж нэрлэдэг бөгөөд энэ нь эцсийн тооцоо нийлэхийг хэлж байгаа юм. Жишиг үнэ нь ихэвчлэн Platt's, Metal Bulletin зэрэгт нийтлэгддэг ЛМБ болон Лондонгийн хайлшийн зах (London Bullion Market)-ын үнэ байдаг.

### **3.2 Хайлуулах үйлдвэрийн цэвэр үнэлгээ (NSV)**

Зураг 6-д үзүүлснээр баяжмалын борлуулалтын гэрээнд тусгагдсан боловсруулалт, цэвэршүүлэлтийн зардал (TC/RC) болон бусад нөхцлүүд (жишээлбэл, металлын суутгал) нь үйлдвэрлэлийн салбарт өргөн хүрээнд хүлээн зөвшөөрөгдөж, хэрэгжиж байгаа томъёон дээр суурилсан байдаг. Баяжмалын хайлуулах үйлдвэр дээрх үнэ буюу хайлуулах үйлдвэрийн цэвэр үнэлгээг (NSV)

тодорхойлохдоо аливаа “урамшуулал”, “торгууль” бүхий дагалдах металл(ууд)-ыг тооцсоны дараа эдгээрийг баяжмалд агуулагдах үндсэн металлын үнээс хасаж тооцно.

Хэрэв тээвэрлэлт, даатгалын зардлыг NSV-ээс хасвал экспортын боомт дахь FOB үнэ гарна. Олон улс орнуудад үүнийг АМНАТ-ийн суурь үнэлгээ болгон ашигладаг.

Дээрх FOB-ын үнэлгээнээс холбогдох дотоодын тээвэр, даатгал болон бусад холбогдох зардлыг хасвал уурхайн аман дээрх Хайлуулах үйлдвэрийн цэвэр өгөөж (NSR) гарна.

NSV нь ашигт малтмалын түүхий эд, баяжмалын төрөл, агуулга, металлургийн шинж чанараас хамааран бүтээгдэхүүн бүрт харилцан адилгүй байдаг. Хүснэгт 4-т янз бүрийн үндсэн металлын сульфидын баяжмалын ердийн NSV-ийн хэмжээг (“урамшуулал” болон “торгууль”-тай дагалдах металлыг тооцолгүйгээр) баяжмалд агуулагдах үндсэн металлын үнийн хувиар илэрхийлж харуулав.

Үндсэн металл	Сульфидын баяжмалын агууламж	Баяжмалд агуулагдаж буй металлын үнэд NSV-ийн эзлэх ойролцоо хувь
Зэс, Cu	22% - 30% <sup>a</sup>	72% - 80%
Хар тугалга, Pb	45% - 70%	45% - 60%
Цайр, Zn	48% - 56%	52% - 56%
Никель, Ni	9% - 14%	65% - 75% <sup>b</sup>

**Хүснэгт 4.** Хайлуулах үйлдвэрийн цэвэр үнэлгээ(NSV)-г баяжмалд агуулагдаж буй үндсэн металлын үнэд эзлэх хувиар илэрхийлэх нь

<sup>a</sup> Үндсэндээ халькопиритийн баяжмал. Зэсийн өндөр агуулга нь зэсийн зарим хоёрдогч эрдэстэй холбоотой.

<sup>b</sup> Хольц ихтэй баяжмал, зарим урт хугацааны гэрээний хувьд NSV ийм өндөр байж болох юм.

NSV-ийн томъёо нь бүтцийн хувьд нийтлэг боловч баяжмалын төрлөөс хамаарч ялимгүй өөр өөр байдаг. Томоохон уурхай болон хайлуулах үйлдвэрийн хооронд жил бүр тохиролцсон боловсруулах (treatment), цэвэршүүлэх (refining) зардал (TC/RC)-ыг бусад үйлдвэрүүд жишиг (benchmark) болгон авч дагах хандлагатай байдаг. TC/RC хасагдуулгын хэмжээ нь янз бүрийн металлын баяжмалын хувьд олдоц, үнэлгээнээс хамаарч өөр өөр байх бөгөөд спот борлуулалтаас илүү урт хугацааны гэрээ байгуулсан тохиолдолд илүү тогтвортой байх хандлагатай байдаг.

TC/RC хэд хэдэн бүрэлдэхүүн хэсгээс бүрддэг бөгөөд үүнд:

- төлбөр авах металлын хэмжээнээс хорогдуулахаар тохирсон хамгийн доод хувь хэмжээ, эсвэл төлбөр авах металлын хувь хэмжээ;
- боловсруулах зардал (TC) - нэг тонн хуурай баяжмал тутамд тогтоосон ам.долларын хэмжээ;
- цэвэршүүлэх зардал (RC) - боловсруулах нэг фунт үндсэн металлд тогтоосон ам.долларын хэмжээ. Энэ зардал нь бүх баяжмалд, тухайлбал цайрын баяжмалд хамаарахгүй;
- дайвар бүтээгдэхүүн байдлаар ялган авдаг дагалдах “урамшуулал”-т металл/элементийн боловсруулалтын зардал, зарим тохиолдолд хасагдуулга;
- зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс хэтэрсэн агуулга бүхий "торгууль"-т металл/элементийн агуулгатай нь хувь тэнцүүлсэн хасагдуулга.

Дагалдах металл/элементийн урамшуулал, ялангуяа торгуулийн хэмжээ тухайн металлын баяжмалын төрлөөс хамаарч өөр өөр байдаг нь тэдгээрийн боловсруулалтын зардалд үзүүлэх нөлөөлөл өөр өөр байдагтай холбоотой. Монголын баяжмалын кейсүүд дээр хийсэн судалгааны хэсэгт энэ тухай дэлгэрэнгүй авч үзэх болно.

Үүнээс гадна, ялангуяа урьд өмнө нилээд хэрэглэдэг байсан, гэхдээ одоо цөөрөөд байгаа нэг практик бол металлын үнэ хэт өндөр үед хайлуулагчдад үнийн хөнгөлөлт үзүүлдэг, харин үнэ ихээр унасан үед олборлогчдод дэмжлэг үзүүлдэг үнийн оролцоо (Price Participation-PP)-ны янз бүрийн арга юм.

## 4 МОНГОЛЫН АШИГТ МАЛТМАЛЫН БАЯЖМАЛЫН КЕЙС СУДАЛГАА: ОЛОН УЛСЫН АМНАТ-ИЙН ХАРЬЦУУЛАЛТ

### 4.1 Монголын уул уурхайн салбарын талаарх ерөнхий ойлголт

#### 4.1.1 Монголын хүдэр/баяжмал/ металлын экспортын ач холбогдол

Монгол Улс нь “уул уурхай бүхий эдийн засаг”-тай орон. 2019 онд Монголын олборлох салбар нь ДНБ-ний 23.7%, аж үйлдвэрийн бүтээгдэхүүний 57.3%, экспортын 83.5%, нийт хөрөнгө оруулалтын 49.9% -ийг бүрдүүлжээ. Монгол Улсын 2019 оны ашигт малтмалын экспортын хэмжээг тонноор болон үнийн дүнгээр задалж Хүснэгт 5-д үзүүлэв. Нефтийн бүтээгдэхүүн нэмж 385 сая ам.долларыг бүрдүүлсэн.

Эрдэс түүхий эдийн нэр төрөл	2019 он		
	Мянган тонн	Сая ам. доллар	Эзлэх хувь, %
Нүүрс	36466.8	3074.4	48.7
Зэс, баяжмал	1403.6	1795.9	28.4
Төмрийн хүдэр, баяжмал	8448.8	576.4	9.1
Алт, кг	9069.5	418.4	6.6
Жонш	700.1	205.5	3.3
Цайрын хүдэр, баяжмал	134.8	189.0	3.0
Молибдений хүдэр, баяжмал	5.7	49.0	0.8
Гянтболдын хүдэр, баяжмал	0.7	6.5	0.1
БҮГД		6315.1	100.0

*Source: The Mongolian Customs Office in EITI 2020 Report*

#### Хүснэгт 5. Монгол Улсын 2019 оны ашигт малтмалын бүтээгдэхүүний экспортын тоо хэмжээ, үнэлгээ

Монгол Улсын нийт ашигт малтмалын бүтээгдэхүүний экспортын 91.3%, үүнд бүх зэс, төмрийн баяжмал мөн нүүрсний дийлэнх (98.2%) нь БНХАУ-д нийлүүлэгдсэн бол 4.1% нь Их Британи болон бусад олон орнууд руу экспортлогджээ.

Монгол орны эрдэс баялаг болон нөөцийн найдвартай тооцоо хэмжээг шууд мэдэх боломжгүй, ихэнхдээ энэ мэдээлэл нууц байдаг хэдий ч тус улс нь ашигт малтмалын нөөц ихтэй, хайгуулын боломж маш өндөр гэдэгтэй бүгд санал нийлдэг.

Ашигт малтмалын олборлолт сүүлийн жилүүдэд хурдацтай өсч байгаа бөгөөд уул уурхай нь Монгол Улсын эдийн засгийн хөгжил, өсөлтийн хөдөлгүүр болж байх болно гэдэгт эргэлзэхгүй байна.

#### 4.1.2 Монгол Улсын хайгуул, ашиглалтын хөрөнгө оруулалтын талаарх олон улсын ойлголт

Фрейзер Институтээс олон улсын уул уурхайн компаниудын үзэл бодол, ойлголт дээр жил бүр явуулдаг судалгаандаа Монгол Улсын 2002-2017 оны хоорондох зэрэглэлийг үндсэн гурван үзүүлэлтээр (тухайлбал, “Бодлогын хамгийн сайн орчин дахь геологийн потенциал”, “Татварын тогтолцоо”, “Хөрөнгө

оруулалт татах байдал”) дэлхийн бусад улс орнуудтай харьцуулан гаргасан байх бөгөөд харин 2017 оноос Монгол Улс энэ судалгаанд хамрагдахаа больсон байна.

"Бодлогын хамгийн сайн орчин дахь геологийн потенциал" гэдэг үзүүлэлтээр тухайн улсын бодлого хамгийн сайн гэсэн төсөөлөл дор тухайн орны "цэвэр" геологийн хэтийн төлвийг харьцуулдаг (өөрөөр хэлбэл дэлхийн жишигт нийцсэн зохицуулалтын орчин, өрсөлдөөнт татвар, улс төрийн эрсдэлгүй, тодорхойгүй зүйл байхгүй, уул уурхайн бүрэн тогтвортой тогтолцоо).

“Хөрөнгө оруулалт татах байдал” гэдэг нь хүрээлэн буй орчин, татвар, газрын зөрчлийн нэхэмжлэлийн асуудал зэргийг хамарсан хууль тогтоомжийн тайлбар, хэрэглээ, хэргэжилтийн удирдлага, зохион байгуулалт, хуулийг мөрдүүлэхтэй холбоотой тодорхойгүй байдлыг хамардаг. Түүнчлэн улс төрийн тогтвортой байдал, хууль дээдлэх байдал, тогтворжуулалтын болон бусад гэрээний аюулгүй байдал, хэргэжилтийг харгалзаж үздэг.



**Зураг 7.** Монгол улсын зэрэглэл: Ашигт малтмалын нөөц. Татварын тогтолцоо ба хөрөнгө оруулалтыг татах байдал. Хэвийн байдлыг 100% гэж үзсэн.

Зураг 7-д үзүүлсэнчлэн, ашигт малтмалын цэвэр нөөцийн талаарх ойлголтыг авч үзвэл Монгол Улс 2007-08 оны дэлхийн санхүүгийн хямралыг эс тооцвол 2003-2012 оны хоорондох 10 жилийн 8 –д нь хамгийн эхний дөрөвний нэгэд багтаж байсныг тэмдэглэх нь зүйтэй. 2012 онд Монгол Улс дэлхийн уул уурхайн хамгийн ирээдүйтэй орноор шалгарч байсан хэдий ч мөн тэр жилдээ уул уурхайн бодлогыг нь боловсронгуй болгох хамгийн их шаардлагатай орноор тодорхойлогдсон байдаг юм.

Хэдийгээр уул уурхайн хамгийн ирээдүйтэй орон байсан ч Монгол Улс нь хөрөнгө оруулалт татах түвшингээрээ дэлхийн дундажаас доогуур байр эзэлж байв (16 жилийн 13 жилд нь). 2012 онд геологийн потенциалгаар дэлхийн хамгийн ирээдүйтэйд шалгарч байсан Монгол орон хөрөнгө оруулалт татах байдлаараа дөнгөж 39-д жагсаж байсан бол дараа жил нь 71-р байр руу ухарсан байна. Уул уурхайн хөрөнгө оруулалт давамгайлсан оргил үе болох 2013 онд гадаадын шууд хөрөнгө оруулалт (ГШХО) 4.5 тэрбум ам долларт хүрч байсан бол 2017 онд огцом буурч 94 сая ам.доллар болж, төгрөгийн америк долларын эсрэг ханш 80% суларсан байна.

Хөрөнгө оруулалт татах зэрэглэл муу байхад нөлөөлсөн гол хүчин зүйл нь 2006 онд батлагдсан Ашигт малтмалын тухай хууль, Зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн албан татварын тухай хуулийн дагуу 2011 он хүртэл алт, зэсийн хүдэр, зэсийн баяжмалд гэнэтийн ашгийн 68 хувийн татвар ногдуулсан явдал байсан нь эргэлзээгүй. Татварын тогтолцооны хувьд Монгол Улсын нэр хүнд 2005 онд байсан дундаж түвшингээс тасралтгүй буурсаар 90-ээс доош хувьд хүрч дэлхийн хамгийн тааламжгүй тогтолцоонуудын тоонд орсон.

Уул уурхайн салбар нь татварын тогтолцоог илүү ойлгомжтой, тогтвортой байхыг илүүд үздэг, тийм ч учраас "дагалдах металл"-ын АМНАТ нь Монгол Улсын уул уурхайн засаглалын зохицуулалтын харьцангуй жижиг хэсэг ч гэлээ олон улсад уул уурхайн зохицуулалтын тогтолцоо нь тодорхойгүй, шударга бус гэж ойлгогдож, ашигт малтмал хайх, олборлоход оруулах ГШХО-ыг сааруулахад түлхэц болж байна гэж үзэж болно. Ашигт малтмалын өндөр потенциалтай нь хүлээн зөвшөөрөгдсөн тус улсын хувьд энэ нь тун харамсмаар зүйл бөгөөд бидний харж байгаагаар худалдан авагч тухайлан үнэ төлбөр өгдөггүй "дагалдах металл/элемент"-д АМНАТ ногдуулах журам, зохицуулалтаа өөрчлөхөд Засгийн Газар нэн тэргүүлэх ач холбогдол өгч ажиллах шаардлагатай болоод байна.

#### **4.2 Баяжмал дахь “дагалдах металл/элемент”-ийн АМНАТ-ийн олон улсын шилдэг туршлага**

Цөөн тооны тодорхой хэмжээ, жинд суурилсан АМНАТ-ийн тогтолцоог эс тооцвол олон улсын АМНАТ-ийн тогтолцооны дийлэнх нь үнэлгээ, эсвэл ашигт суурилсан байдаг.

Монгол Улсын АМНАТ-ийн тогтолцоо нь бүхэлдээ үнэлгээнд суурилсан бөгөөд одоогоор ашигт, эсвэл эзлэхүүн, жинд суурилсан тусгай АМНАТ ашигладаггүй.

АНУ-ын хойд Америкийн холбооны болон мужуудын ихэнх газар нутгууд, Канад улс, Австралийн Тасмани болон Хойд хэсэг, Өмнөд Америкийн Перу, Чили болон бусад хэд хэдэн улсад ашигт суурилсан АМНАТ-ийн янз бүрийн тогтолцоо үйлчилдэг. Биелсэн ашгийн хэмжээтэй уясан хосолмол АМНАТ-ийн тогтолцоо Өмнөд Африкийн БНУ зэрэг зарим оронд мөн байдаг.

Ашигт суурилсан АМНАТ-ийн тогтолцоонд “бодит биелсэн” орлогын хэмжээнд тулгуурлан АМНАТ-ийн суурь үнэлгээг тогтоодог. Ихэнх тохиолдолд АМНАТ төлөлтийн хугацаанд хуримтлагдсан орлого нь тухайн хугацаанд борлуулсан бүх ашигт малтмалын бүтээгдэхүүний борлуулалтын дүнгээр илэрхийлэгдэх бөгөөд холбогдох нэхэмжлэхийн дүнгээр баталгааждаг. Энэхүү нэхэмжлэлд аливаа үндсэн металлд төлсөн үнэ, дагалдах металл тус бүрийн урамшуулал ба/эсвэл торгууль, хайлуулах, цэвэршүүлэх зардлыг дэлгэрэнгүй тусгасан байдаг. Орлогод худалдан авагчдын дагалдах металл/элементэд төлсөн үнийг багтаана.

Бидний олж мэдсэнээр дээрх улсуудын алинд нь ч худалдагч тал нь төлбөр авдаггүй дагалдах металл/элементэд АМНАТ ногдуулдаггүй юм байна.

Цаашдаа бидний судалгаа Монгол шиг үнэлгээнд суурилан АМНАТ ногдуулдаг уул уурхай бүхий дэлхийн олон улс орнуудын АМНАТ-ийн тогтолцоон дээр төвлөрсөн юм. Дахин нэг сануулахад, "бодит биелсэн" борлуулалтын үнэлгээнд үндэслэдэг АМНАТ-ийн тогтолцоо нь тодорхойлолтоороо худалдагчийн бодитойгоор төлбөр хүлээн авсан металлын АМНАТ-өөр АМНАТ-ийг хязгаарладаг. Худалдагч төлбөрийг нь бодитойгоор хүлээн авсан эсэхээс үл хамааран тухайн металл/элементэд АМНАТ ногдуулдаг тогтолцоо Монгол Улсынхтай зэрэгцэн оршиж байна гэж бодвол энэ нь АМНАТ-ийг “урьдчилан тооцоолсон” борлуулалтын үнэлгээн дээр үндэслэж ногдуулдаг л улс байх магадлалтай юм.

Энэ хүрээнд ихээхэн материал судалж, холбогдох татварын албадуудаас өөрийн биеэр асууж лавласан ч одоогоор Монголынхтой шууд зэрэгцэхээр тогтолцоог олж тогтоож чадаагүй байна. Иймд Монголын энэ тогтолцоо нь өвөрмөц, эсвэл маш ховор гэж дүгнэж болохоор байна.

Маркетингийн хэвийн нөхцөлд борлуулагч нь өөрийн хүдэр, эсвэл баяжмалдаа агуулагдаж байгаа үнэт металлд төлбөр авахгүйгээр худалдана гэж байхгүй бөгөөд хэрэв дагалдах металлд худалдан авагч төлбөр төлөөгүй бол тэдгээр нь зах зээлийн ямар ч үнэ цэнэгүй гэдгийг тэд хүлээн зөвшөөрсөн гэсэн үг юм. Хүдэр ба баяжмалын үнийг харилцан хамааралгүй хоёр талын хооронд “сунгасан гар”-ын зарчмаар хэлэлцэн тохирсон тохиолдолд Засгийн Газар болон уурхайчдын ашиг сонирхол уялдсан байх ёстой.

Цаашилбал, уул уурхайн олон хуульд борлуулагч нь зах зээлд давамгайлж буй нөхцлөөр, хамгийн сайн үнээр ашигт малтмалын бүтээгдэхүүнээ борлуулахыг эрмэлзэхийг шаардсан заалтууд байдаг. Харин Сайдын хувьд хэрэв холбогдох металл(ууд)-ын үнэ боломжит түвшинд биш байна гэж үзэн сэтгэл хангалуун бус байгаа бол өөр зах зээлийн илүү найдвартай мэдээллийг үндэслэн, тохирох өөр үнээр тооцох эрхийг дээрх хуулиудаар Сайдад олгосон заалтууд байдаг.

Энэ нь "дагалдах металл"-ын асуудал Монголоос өөр улсуудад үүсдэггүй гэсэн үг биш, харин уг асуудал зөвшөөрөл олгох үйл явцын эхний шатанд, тухайлбал, Компанийн зүгээс Засгийн Газарт ашигт малтмалын ордыг ашиглах тухай Хүсэлтийн мэдэгдэл (NoI)-ийг хүргүүлэх үед шийдвэрлэгддэг гэсэн үг юм. Компани болон Засгийн Газрын ашиг сонирхол өргөн хүрээнд уялдах ёстой гэж үзэх нь зөв боловч энэ үе шатанд Хүсэлтийн мэдэгдэл(NoL)-ийг дагалдах Техник, эдийн засгийн үндэслэл (ТЭЗҮ) -д тусгасан бүтээн байгуулалт нь Засгийн Газрын хувьд хэр оновчтой байна вэ гэдгийг нягталж үзэх боломжтой. Ийнхүү нягталж шалгах явцад харьцангуй өндөр агууламжтай зарим "дагалдах металл"-ын үнэлгээг эдийн засгийн тооцоонд авч үзээгүйн үндэслэл, шалтгааныг асууж лавлах ёстой. Үүний дагуу тухайн ордын ашиглалтын төлөвлөгөөг дахин авч үзэх, эсвэл ашиглалтын эцсийн төлөвлөгөөнд компани нь ирээдүйд тухайн дагалдах металлын үнэ өөрчлөгдсөн, эсвэл холбогдох металлургийн технологид ахиц дэвшил гарсан нөхцөлд дагалдах металлын арилжааны үндэслэлийг дахин авч үзэх үүргийг уул уурхайн компанид хүлээлгэж болох юм

Өөр нэг чухал асуудал бол, "дагалдах металл"-ын агуулга нь ямар түвшингээс доош байхад ялган авах боломжгүй, эдийн засгийн хувьд ашиггүй гэж үзээд АМНАТ-өөс чөлөөлөх вэ гэдэг асуудал юм.

Үүнтэй холбоотой сонирхолтой шийдлийг Баруун Австралийн уул уурхайн тухай хууль тогтоомжийн төмрийн хүдэртэй холбоотой зарим элементээс харж болно. БА-ийн Пилбара мужийн манганцаар баялаг төмрийн хүдрийн олборлолтыг зохицуулдаг "Нимингарра" ба "Норе Down"-ийн гэрээнд манганы 2%-иас дээш агуулга бүхий төмрийн хүдрийг "манганы хүдэр" хэмээн тодорхойлсон байдаг. Энд зааснаас доош агуулгатай манган нь эдийн засгийн ач холбогдолгүй бөгөөд хайлуулах үйлдвэрээс уг төмрийн хүдэрт төлөх үнэд нөлөөлөхгүй, өөрөөр хэлбэл манганд нэмэлт "урамшуулал" төлөхгүй байх магадлалтай юм. Гэвч эдгээр хүдэрт агуулагдах манганы агууламж ерөнхийдөө өндөр байгааг харгалзан БА-ийн Засгийн Газар гэрээнд дараахь үүргийг компаниудын талд тусгаж өгсөн байдаг:

*"Компани нь энд дурдсан ашигт малтмалын "Б" талбайн хүдрийг баяжуулах боломжтой эсэх, мөн Баруун Австрали мужид металлжуулсан бүтээгдэхүүн буюу ферроманганы үйлдвэр байгуулах боломжийг судалж, цаашид үйлдвэр байгуулах саналыг Засгийн Газарт тавих боломжийг үе үе авч үзэж байхаар тохиролцов."*

Металлжуулсан бүтээгдэхүүн буюу ферроманган үйлдвэрлэх нь өнөөг хүртэл эдийн засгийн хувьд боломжгүй байсаар байна.

Дагалдах металлын талаарх өөр нэг сонирхолтой заалтыг Баруун Австралийн Уул уурхайн журмын 5-р бүлгийн 86-р хэсгээс олж болох (1981 оны нэмэлт, өөрчлөлтөөр) бөгөөд үүнд ялган авах эсэхээс нь үл хамааран төмрийн хүдэр (магнетит)-ийн баяжмал дахь ванадийд АМНАТ ногдуулах доод хязгаарыг заасан байдаг:

- a) ванадийн баяжмал (ванадийн исэл) борлуулсан бол ванадийн пентоксидын үнийн 5%;
- b) металл хэлбэрээр (феррованадиум) борлуулсан бол феррованадиумын үнийн 2½%;
- c) хүдэр дэх V<sub>2</sub>O<sub>5</sub>-ийн дундаж агуулга 0.275% -иас дээш бол - ванадийн пентоксидын үнийн 5%".

Төмрийн хүдрийн үнэ маш хурдацтай өсч байгаа цаг үед тухайн нутгийн чухал баялаг болох ванадий бүхий магнетитын нөөцийг хурдавчилсан, оновчгүй байдлаар олборлох эрсдлийг харгалзан дээрх арга хэмжээг авах шаардлагатай гэж үзсэн байдаг.

Монгол Улсын Засгийн Газар олборлогчийн төлбөр авдаггүй дагалдах металл/элементэд АМНАТ ногдуулдаг практикаа зогсоохыг бид зөвлөж байгаа боловч Засгийн Газар үүнийг зөвшөөрөхгүй тохиолдолд хамгийн түгээмэл байдаг дагалдах металлуудыг ялган авах эсэхээс нь үл хамааран, тэдгээрт АМНАТ ногдуулах агууламжийн хязгаарыг хуульчлан тогтоож өгөх нь зохистой буулт байж болох юм.



Дагалдах металл/элементийн энэхүү агууламжийг тогтоохдоо дэлхий дахинд дайвар бүтээгдэхүүн болгон ялган авч буй тухайн дагалдах металл/элементийн хүдэр, баяжмал дахь дундаж агуулгыг жишиг болгох нь зүйтэй бөгөөд үе үе нягталж, металлургийн технологи, маркетинг сайжрахын хэрээр шинэчилж байх хэрэгтэй.

Үүнийг хэрэгжүүлэхийн тулд Уул уурхайн сайдад дагалдах металл/элементэд АМНАТ ногдуулах агууламжийн хязгаарыг тогтоох, үе үе эргэн нягталж, шаардлагатай бол шинэчилж байх бүрэн эрхийг холбогдох сайдад олгох, уг эрхээ хэрэгжүүлэхдээ салбарын стандартыг мөрдөж, үйл ажиллагааны шударга байдлыг хангаж байхаар заасан өөрчлөлтийг Ашигт малтмалын тухай хууль болон холбогдох журамд оруулах хэрэгтэй.

### **4.3 Монголын баяжмалын кейс судалгаа**

#### **4.3.1 Кейс судалгааны ерөнхий тойм**

Энэхүү тайлангийн 4.1.1-д илүү дэлгэрүүлж тайлбарласанчлан, “дагалдах металл”-ын ямар нэгэн асуудалгүй нүүрс, хайлуур жонш, алтнаас гадна Монголын ашигт малтмалын экспортын үнийн дүнгийн дийлэнх хувийг зэс, цайрын баяжмал, төмрийн хүдэр эзэлдэг. Иймээс дараах ашигт малтмалын баяжмалын кейсүүд дээр төвлөрч, тэдгээрт агуулагдаж буй дагалдах металл/элементэд ногдуулдаг АМНАТ-ийн тогтолцоог авч үзсэн болно.

Бид дүн шинжилгээнийхээ энэ хэсэгт Монгол Улсын гол нэрийн ашигт малтмалын баяжмалуудыг сонгон авч, баяжмал тус бүрийн хувьд дараах зүйлсийг тооцож, харьцуулсан хүснэгтийг гаргав. Үүнд:

- Монгол Улсын Ашигт малтмалын тухай хуулийн дагуу төлсөн АМНАТ;
- Олон улсад нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн хайлуулах, цэвэршүүлэх гэрээний нөхцлөөр олборлогчдын хүлээн авсан “хайлуулах үйлдвэрийн цэвэр үнэлгээ-NSV” буюу “гэрээний борлуулалтын үнэ”;
- Австралийн уул уурхайн тэргүүлэх хоёр бүс нутаг (Баруун Австрали-БА ба Куинсланд-Кл)-ийн АМНАТ-ийн тогтолцоогоор Монголын баяжмалд төлөх байсан АМНАТ.

Уг загваруудад олборлогч баяжмалын үндсэн металлын үнэ дээр нэмэлт төлбөр буюу "урамшуулал" авдаг дагалдах металл/элементүүд болон баяжмалын үнийг бууруулж, "торгууль" тавигддаг дагалдах металл/элементүүдийн ялгааг гаргаж, авч үзсэн. Ийнхүү ялгаж авч үзсэн нь олборлогч ямар ч төлбөр авдаггүй бүх төрлийн дагалдах металл/элементийг АМНАТ-аас чөлөөлөх, ингэснээр алдах байсан орлогыг тооцоход чухал хэрэгтэй юм.

Дараах хэсгүүдэд уг санхүүгийн загварчлалаас гарсан үндсэн дүгнэлтийг нэгтгэн харуулсан бөгөөд бүрэн боловсруулсан загварын тооцоог хавсралтаар оруулсан болно.

#### **4.3.2 – Кейс 1: Зэсийн баяжмал**

Энэ жишээнд ашигласан зэсийн баяжмалын агууламж (22.41% Cu) дээр үндэслэсэн АМНАТ-с гадна Хавсралт 4-т дэлгэрэнгүй тайлбарласны дагуу Монгол Улсын Засгийн Газар зэсийн баяжмал дахь өндөр агуулга бүхий төмөр (23.42% Fe) болон мөнгөн (80.42 g/t Ag) –нд АМНАТ ногдуулсан бөгөөд харин зэсийн баяжмал дахь цайр (1.08% Zn), хөнгөн цагаан (1.09% Al), бага зэргийн молибден (615 ppm) зэрэг бусад металл болон гаалийн лабораторийн шинжилгээгээр маш бага агуулгатай нь тогтоогдсон F, Pb, Cd, Se зэрэг бусад элементэд АМНАТ ногдуулаагүй байна.

Хүснэгт 6-д үзүүлсэн АМНАТ-ийг Засгийн Газар эдгээр металлуудын урьдчилан тооцоолсон борлуулалтын үнэлгээнд үндэслэн гаргасан, өөрөөр хэлбэл борлуулсан тоо хэмжээг тус тусын зарласан үнээр үржүүлэн тооцсон.

## 1 тонн баяжмалд

Зэсийн баяжмал	Агуулга	АМНАТ-ийн хувь хэмжээ, %		АМНАТ, ам.доллар
		Үндсэн	Өсөн нэмэгдэх	
<b>Үндсэн металл</b>	%			
<b>Зэс</b>	<b>22.41</b>	<b>5.0</b>	<b>12.0</b>	<b>209.90</b>
<b>Дагалдах металл</b>	%			
Төмөр	<b>23.42</b>	<b>5.0</b>	<b>1.2</b>	<b>1.22</b>
<b>Мөнгө</b>	<b>0.0084</b>	<b>5.0</b>	<b>0.0</b>	<b>2.09</b>
<b>Дагалдах металлын дүн</b>				<b>3.31</b>
<b>БҮГД</b>				<b>213.21</b>
	Худалдан авагчаас төлбөр төлөгдсөн үндсэн ба дагалдах металл			

**Хүснэгт 6.** Монгол Улсын ЗГ-аас чийгтэй, нэг тонн зэсийн баяжмалд ногдуулж авсан АМНАТ, үүнд олборлогч ямар ч төлбөр аваагүй төмөрт ногдуулсан 1.22 ам. доллар багтсан байна.

БА-д FOB нөхцөлтэй зээнд АМНАТ-ийн хувь хэмжээ 5%, мөнгөнд 2.5% байдаг. Харин Кл-ийн хувьд АМНАТ-ийн хувь хэмжээ нь 2019-20 оны 3-р улиралд борлуулсан зэсийн дундаж үнийн 4.70%, мөнгөний 5.0% байв.

Кейс 1-ийн загварчлалын тооцооллын дэлгэрэнгүй хүснэгтийг Хавсралт 5-д үзүүлэв.

Хүснэгт 7-д Монгол Улсад төлсөн АМНАТ-ийг БА ба КЛ-д төлөх байсан АМНАТ-тэй харьцуулж харуулав. Хүснэгт 7-ийн голын хоёр баганад Хайлуулах үйлдвэрийн цэвэр үнэлгээ (NSV)-г харуулав, өөрөөр хэлбэл “CIF-хайлуулах үйлдвэр” нөхцлөөр баяжмалыг борлуулахад олборлогчийн хүлээн авсан үнэ, үүнд Австралиас экспортлох боомтын FOB үнээс далайн тээвэр, даатгалын зардлыг хасч тооцсон болно. Эцэст нь БА ба КЛ-ийн АМНАТ-ийн суурь үнэлгээний тооцооллыг хүснэгтийн баруун багануудад харуулав.

Өмнө дурьдсанчлан NSV нь хайлуулах үйлдвэрийн төлбөр болон хайлуулах/цэвэршүүлэх зардал (TC/RC)-ыг хассан цэвэр дүн бөгөөд хайлуулах үйлдвэрийн төлбөр болон хайлуулах/цэвэршүүлэх зардал (TC/RC) нь тухайн үеийн үнэлгээгээр зэсийн 1% -ийн хасагдуулга, хайлуулах зардал (TC) хуурай тонн баяжмал тутамд 60 доллар, цэвэршүүлэх зардал (RC) нэг фунт металл тутамд 0.06 доллар тус тус байсан байна.

Монголын зэсийн баяжмалаас хураасан АМНАТ-ийн хэмжээ нь дагалдах металлуудын АМНАТ-ийг тооцоогүй тохиолдолд ч Австралийнхаас хамаагүй өндөр байгааг харж болно (Монголд \$ 209.90, харин Австралид 52.97 болон 49.80 ам.доллар). Монголын АМНАТ-ийн үлэмж хэсэг нь үндсэн 5%-иас гадна зэсийн үнэ харьцангуй өндөр байсантай холбоотой 12% -ийн өсөн нэмэгдэх АМНАТ-өөс үүдэлтэй.

Зэсийн баяжмал	Монгол Улсын АМТХууль			Олон улсын	Австрали Улсын Уул уурхайн хууль				
	АМНАТ-ийн суурь үнэлгээ	АМНАТ		Хайлуулах үйлдвэрийн цэвэр төлбөр	Экспортын боомтын FOB үнэ	Баруун Австралийн АМНАТ		Куйнсландын АМНАТ	
		Америк доллар	Америк доллар	%	Америк доллар	ам.доллар	Америк доллар	%	Америк доллар
<b>Үндсэн металл</b>									
Зэс	1234.73	209.9	98.45	1106.48	1059.48	52.97	98.99	49.80	97.88
<b>Дагалдах металл</b>									
Худалдан авагчаас төлөгдсөн	41.74	2.09	0.98	21.61	21.61	0.54	1.01	1.08	2.12
Худалдан авагчаас төлөгдөөгүй	19.64	1.22	0.57	ө/б	ө/б	ө/б		ө/б	
Торгууль				0	Тайлбар 1				
<b>Дагалдах металлын дүн</b>	61.38	3.31	1.55	21.61	21.61	0.54		1.08	
<b>БҮГД</b>	1296.11	213.21	100.0	1128.09	1081.09	53.51	100.0	50.88	100.0
<b>Нийт АМНАТ-д дагалдах металлын эзлэх хувь, %</b>	4.74%	1.55%		1.92%	2.00%	1.01%		2.12%	
Тайлбар 1:	Торгууль болон далайн тээврийн зардлыг худалдан авагчаас төлөгдсөн үндсэн металлын үнийн дүнгээс хасаж FOB үнийг гаргасан болно.								

### Хүснэгт 7. Монголын АМНАТ-ийн суурь үнэлгээ ба олон улсын NSV, Баруун Австрали, Куинсландын АМНАТ-ийн харьцуулалт

#### 4.3.2.1 – Урамшуулалт (credit) металл

Жишээнд авч үзсэнээр худалдан авагчаас нэмэлт төлбөр төлөгдсөн (өөрөөр хэлбэл 2.09 доллар) дагалдах металл-мөнгөнд АМНАТ ногдуулсан бол харин худалдах авагчаас төлбөр төлөгдөөгүй төмөрт АМНАТ (1.22 доллар) ногдуулсан байна.

Хайлуулах үйлдвэрүүд зарим төлбөр төлөгддөг дагалдах металлд “урамшуулал” өгдөг. Эдгээр нь дандаа биш ч ихэнхдээ үнэт металл (жишээлбэл, алт, мөнгө, цагаан алтны группийн металлууд гэх мэт) байдаг. Уг жишээнд мөнгийг “урамшуулалт” металл гэж хүлээн зөвшөөрч худалдан авагчаас нэмэлт төлбөр-урамшуулал төлсөн байна. Харин эсрэгээрээ зэсийн баяжмал дахь төмөрт худалдан авагч нэмэлт төлбөр хийгээгүй байхад Монгол Улс АМНАТ ногдуулсан байна.

Зэсийн баяжмалд түгээмэл агуулагддаг үнэт металлд төлөх магадлалтай нэмэлт төлбөр, мөн хасах магадлалтай боловсруулалтын зардлыг Хүснэгт 8-д (AusIMM, 2012) харуулав. Энэхүү хасаж тооцогддог боловсруулалтын зардал болон харьцангуй бага АМНАТ-ийн хувь хэмжээ нь БА ба Кл-ын дагалдах металл-мөнгөнд ногдуулдаг АМНАТ-ийн хэмжээ Монголынхоос бага байгаа (0.54 ба 1.08 доллар) шалтгааныг тайлбарлаж байна.

Дагалдах үнэт металл	Цэвэршүүлэх зардал	Нэмэлт төлбөр төлөгдөх металлын хувь ба агуулгын босго	Тайлбар
Алт	Үнэлгээ бүхий унци тутамд 3-7 ам. Доллар	0%: < 1 г/т 90%: <3 г/т 94%: <5 г/т 95%: <10 г/т 96%: <15 г/т 96.5%: <20 г/т 97%: <30 г/т 98%: <50 г/т 98.25%: >50 г/т	Алтны агуулга 1г/т-оос бага бол төлбөр төлөхгүй. Алтны агуулга 5 г/т-оос дээш бол энэ агуулгаас дээш гарсан металлын 94%-д нь нэмэлт төлбөр буюу урамшуулал төлнө
Мөнгө	Үнэлгээ бүхий унци тутамд 0.3-0.4 ам. доллар	90% - 20 - 30 г/т хасагдуулга	Мөнгөний агуулгаас 20-30 г/т-ыг хасаж, үлдэх мөнгөний 90%-д төлбөр төлнө

### Хүснэгт 8. Зэсийн баяжмалд агуулагдаж буй үнэт металлын урамшуулал ба боловсруулалтын зардлын жишээ, (Эх сурвалж AusIMM, 2012)

#### 4.3.2.2 – Торгуульт металл

Тодорхой металл/элементийн агуулга нь технологийн процесст сөрөг нөлөө үзүүлэх босго хэмжээнээс давсан тохиолдолд хайлуулах үйлдвэрүүд тухайн металл/элементэд "торгууль" тавьж, улмаар байжмалын үнийг бууруулдаг. Сөрөг нөлөө гэдэг нь:

- Байгал орчин, хөдөлмөрийн эрүүл мэндийн хяналтын нэмэгдэл зардал;
- Үйлдвэрлэлийн хаягдлыг зайлуулах нэмэлт зардал;
- хайлуулах нэмэлт зардал;
- цэвэршүүлэх нэмэгдэл зардал;
- хайлуулах болон боловсруулах үйлдвэрийн бүтээмжийн бууралт.

БНХАУ-ын Засгийн Газар баяжмалд агуулагдах зарим элементийн агууламжийн дээд хязгаарыг тогтоож (Хүснэгт 9), агууламжийн хэмжээ үүнээс хэтэрсэн тохиолдолд импортлохыг хориглодог (FitzGerald, 2012).

Элемент	Дээд хязгаар (%)
Хар тугалга, Pb	≤6.0
Хүнцэл, As	≤0.5
Фтор, F	≤0.1
Кадмий, Cd	≤0.05
Мөнгөн ус, Hg	≤0.01

**Хүснэгт 9.** БНХАУ-ын импортын зэсийн баяжмалд агуулагдах элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хязгаар

Үүнтэй адил зэсийн баяжмалд түгээмэл агуулагддаг төрөл бүрийн металл/элементүүдийн агууламжийн босго, торгуулийн хувь хэмжээг Хүснэгт 10, Хүснэгт 11-д харуулав

Металл	Торгууль тавигдах босго агуулга (ppm/хуурай тонн)	Босго давсан агуулгын нэгж тутамд тавих торгууль
Хүнцэл	2000	US\$2 (to \$2.50) /1000 ppm
	>10,000	US\$5+/1000 ppm
Хар тугалга	10000	US\$1.50/10000 ppm
Цайр	30000	US\$1.50/10000 ppm
Мөнгөн ус	10	US\$0.20/1 ppm
Висьмут	500	US\$2.00 (to \$3)/100 ppm
Сурьма	1000	US\$0.50/100 ppm
Никель + Кобальт	5000	US\$0.30/1000 ppm
Al <sub>2</sub> O <sub>3</sub> + MgO	10000	US\$4.50/10000 ppm
Хлор	500	US\$0.50/100 ppm
Фтор	330	US\$0.10/10 ppm

**Хүснэгт 10.** Зэсийн баяжмалд түгээмэл агуулагддаг үнэт бус металлын торгуулийн хасагдуулгын жишээ. Fountain-ий Японы хайлуулах үйлдвэрүүдийн үзүүлэлтийг саарал өнгөөр тодотгож харуулав, 2013. (Эх сурвалж: AusIMM, 2012)

Элемент	Торгуулийн босго агуулга, %	Босго давсан 0.1 % тутамд ногдуулах торгууль, ам.доллар/тонн
Сурьма	0.05	15
Хүнцэл	0.2	2
	>1	>5
Висьмут	0.02	25
Кадмий	0.03	30
Фтор	0.03	15
Хар тугалга	1	0.3
Мөнгөн ус	0.0005	3000
Никель + Кобальт	0.5	1
Селен	0.03	15
Цайр	0.3	0.3

**Хүснэгт 11.** Зэсийн баяжмалд агуулагддаг дагалдах металл/элементийн босго агуулга, торгуулийн хэмжээ (Эх сурвалж: Саломон-де-Фридберг ба Робинсон, 2014)

#### 4.3.3 – Кейс 2: Цайрын баяжмал

Энэ кейсийг гаалийн лабораторийн шинжилгээгээр тогтоогдсон, Хүснэгт 12-т харуулсан химийн найрлага бүхий цайрын баяжмал дээр хийлээ.

**1 тонн баяжмалд**

Цайрын баяжмал	Агуулга	АМНАТ-ийн хувь хэмжээ, %		АМНАТ, ам.доллар
		Үндсэн	Өсөн нэмэгдэх	
<b>Үндсэн металл</b>	%			
<b>Цайр</b>	<b>47.81</b>	<b>5.0</b>	<b>2.4</b>	<b>87.84</b>
<b>Дагалдах металл</b>	%			
Хөнгөн цагаан	0.39	5.0	0.0	0.36
Молибден	0.00144	5.0	0.0	0.01
Хар тугалга	0.85	5.0	1.6	1.04
Зэс	1.17	5.0	13.0	15.39
Төмөр	10.81	5.0	3.5	2.17
	гр/т			
Алт	0.56	5.0	0.0	1.68
<b>Мөнгө</b>	<b>240.27</b>	<b>5.0</b>	<b>0.0</b>	<b>9.60</b>
<b>Дагалдах металлын дүн</b>				<b>30.25</b>
<b>БҮГД</b>				<b>118.09</b>
	Худалдан авагчаас төлбөр төлөгдсөн үндсэн ба дагалдах металл			

**Хүснэгт 12.** Монгол Улсын Засгийн Газраас чийгтэй, нэг тонн цайрын баяжмалд ногдуулсан АМНАТ

Монгол Улсын Засгийн Газар цайр (47.81% Zn) –аас гадна дагалдах 7 металлд АМНАТ ногдуулсан байх бөгөөд эдгээрээс олборлогч зөвхөн мөнгөнд нэмэлт төлбөр хүлээн авсан байна. Харин хүхэр (31.73%), кадмий (0.246%) зэрэг бусад металл/элементэд АМНАТ ногдуулаагүй байна.

Монгол Улсын Засгийн Газраас цайрын баяжмалд урьдчилан тооцоолсон борлуулалтын үнэлгээг үндэслэн АМНАТ ногдуулсан бөгөөд борлуулсан баяжмал дахь металл/элементийн жин хэмжээг тус тусын зарласан үнээр үржүүлэх замаар энэхүү суурь үнэлгээг тодорхойлдог.

Цайрын баяжмал	Монгол Улсын АМТХууль			Олон улсын	Австрали Улсын Уул уурхайн хууль				
	АМНАТ-ийн суурь үнэлгээ	АМНАТ		Хайлуулах үйлдвэрийн CIF цэвэр төлбөр	Экспортын боомтын FOB үнэ	Баруун Австралийн АМНАТ		Куйнсландын АМНАТ	
		Америк доллар	Америк доллар	%	Америк доллар	ам.доллар	Америк доллар	%	Америк доллар
Үндсэн металл									
Цайр	1186.97	87.84	74.38	902.11	851.24	42.56	95.49	35.75	89.89
Дагалдах металл									
Худалдан авагчаас төлөгдсөн	191.97	9.60	8.13	80.36	80.36	2.01	4.51	4.02	10.11
Худалдан авагчаас төлөгдөөгүй	167.81	20.65	17.49	ө/б	ө/б	ө/б		ө/б	
Торгууль				-3.86					
Дагалдах металлын дүн	359.78	30.25	25.62	76.50	80.36	2.01	4.51	4.02	
БҮГД	1546.75	118.09	100.0	978.61	931.60	44.57	100.0	39.77	100.0
Нийт АМНАТ-д дагалдах металлын эзлэх хувь, %	23.26%	25.62%		7.82%	8.63%	4.51%		10.11%	


**Хүснэгт 13.** Монголын АМНАТ-ийн суурь үнэлгээ ба орлогын хэмжээг олон улсын NSV болон Баруун Австрали, Куйнсландын тогтолцоотой харьцуулсан нь

БА-д FOB нөхцөлтэй цайрт АМНАТ-ийн хувь хэмжээ 5%, мөнгөнд 2.5% байдаг. Харин Кл-ийн хувьд АМНАТ-ийн хувь хэмжээ нь 2020-2021 оны 3-р улиралд борлуулсан цайрын дундаж үнийн 4.20%, мөнгөний 5.0% байв.

Кейс 2-ын тооцооллын хүснэгтийн дэлгэрэнгүйг Хавсралт 6-д үзүүлэв.

Хүснэгт 13-т Монгол Улсад төлсөн АМНАТ-ийг БА болон Кл-д төлөх байсан АМНАТ-тэй харьцуулж харуулав. Хүснэгт 13-ын голын хоёр багананд Хайлуулах үйлдвэрийн цэвэр үнэлгээ (NSV)-г, өөрөөр хэлбэл “CIF-хайлуулах үйлдвэр” нөхцөлтэй баяжмалыг борлуулахад олборлогчийн хүлээн авсан үнийг харуулсан бол харин баруун хэсэгт БА ба Кл-ийн АМНАТ-ийн суурь үнэлгээ болох экспортын боомт дээрх FOB нөхцөлтэй баяжмалын үнийг харуулав.

Өмнө дурьдсанчлан хайлуулах үйлдвэрийн цэвэр үнэлгээ (NSV) нь хайлуулах үйлдвэрийн зардал бөгөөд энэ нь тухайн үед металл цайрын 8%-тай тэнцэх хасагдуулга, боловсруулах зардал (ТС)-ын "жишиг" нэг тонн баяжмал тутамд 86 доллар байсан байна. Зураг 8-д үзүүлснээр, нэг тоннд 300 орчим доллар байсан цайрын баяжмалын боловсруулах зардал (ТС) нь сүүлийн үед цайрын сайн чанарын баяжмалын олдоц муудсанаас болж буурсаар байна. Цаашилбал, урьд нь томоохон баяжмал нийлүүлэгчид болон хайлуулагчдын хооронд тохиролцдог ТС-ийн “жишиг-benchmark”-тай "spot" гэрээний боловсруулах зардал (ТС) нь ойролцоо байдаг байсан бол саяхнаас эрс буурч, уг “жишиг-benchmark”-ийн талд нь ч хүрэхгүй буюу ойролцоогоор нэг тоннд 86 ам.доллар болоод байна.



**Зураг 8.** Цайрын баяжмалын боловсруулах зардал(ТС)-ын “жишиг-benchmark” ба Спот ТС



Зэсийн жишээнээс ялгаатай нь цайрын баяжмалаас цэвэршүүлэлтийн зардал (RC) авдаггүй. Гэхдээ цэвэр металлын суурь (босго) үнийг тохиролцож гэрээнд тусгадаг. Жишээ нь суурь үнийг 2500 доллар/т-оор тохиролцсон гэж үзвэл зах зээл(ЛМБ)-ийн үнэ 2500 доллар/т-оос давсан тохиолдолд (тухайлбал 2785 доллар/тн) тонн тутамд 0.06 ам.долларын үнийн өсөлтийн төлбөр(эскалатор)-ийг нэмж ((2785-2500)х0,06=17,1 доллар/т) тооцдог. Хэрэв зах зээлийн үнэ нь суурь үнээс бага байвал хасаж тооцно.

Монголын цайрын баяжмалаас хураасан АМНАТ нь дагалдах металлуудын АМНАТ-ийг тооцоогүй тохиолдолд ч Австралийнхаас ойролцоогоор хоёр дахин их байгааг (Монголд 87,84 доллар, Австралид 42.56 ба 35.75 доллар) 13-р хүснэгтээс харж болно. Монголын АМНАТ-ийн 1/3 орчим нь тухайн үед цайрын үнэ харьцангуй өндөр байсантай холбоотой цайрын баяжмалд ногдуулдаг үндсэн 5% дээр нэмж төлсөн 2.4% -ийн өсөн нэмэгдэх АМНАТ-тэй холбоотой байна.

#### 4.3.3.1 Урамшуулалт металл

Цайрын баяжмалд агуулагдаж буй дагалдах 7 металлд АМНАТ ногдуулсан байх ба үүнээс худалдан авагч зөвхөн мөнгөнд нэмэлт төлбөр-урамшуулал авсан байна. Цайрын баяжмалд нийтлэг агуулагддаг үнэт металлын нэмэлт төлбөр-урамшууллын болон боловсруулах зардлыг Хүснэгт-14-т үзүүлэв. Баяжмалд агуулагдаж буй мөнгөнөөс 90 гр (3 трой унци)-ыг хасаад үлдэх мөнгөний 60-90%-д нь нэмэлт төлбөр-урамшуулал төлдөг. Бид загвартаа үүний консерватив хувилбарыг ашигласан болно.

Харин худалдан авагчаас нэмэлт төлбөр буюу урамшуулал төлөгдөөгүй бусад дагалдах металлд 20.65 ам.долларын АМНАТ ногдуулсныг Хүснэгт 13-т харуулав.

Дагалдах үнэт металл	Цэвэршүүлэх зардал	Нэмэлт төлбөр буюу урамшуулал
Алт	Хасагдуулах 1 грамм	Үлдсэн хэсгийн 70 хувьд төлбөр төлнө.
Мөнгө	<ul style="list-style-type: none"> <li>Хэрэв Ag агууламж &gt;200 г/т бол: 90 граммыг хасна</li> <li>Хэрэв Ag агууламж &lt;200 г/т бол: 50 г хасна</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Үлдсэн хэсгийн 90 хувьд төлбөр төлнө</li> <li>Үлдсэн хэсэгт төлбөр төлнө</li> </ul>
	<ul style="list-style-type: none"> <li>Хэрэв Ag агууламж &gt;3 Т.унц/т бол: 90 г хасна</li> <li>Хэрэв Ag агууламж &lt;3 Т.унц/т бол:</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Үлдсэн хэсгийн 60 хувьд төлбөр төлнө</li> <li>Төлбөр төлөхгүй</li> </ul>

**Хүснэгт 14.** Цайрын баяжмалтай холбоотой үнэт металлын урамшуулал ба боловсруулалтын төлбөрийн жишээ (Эх сурвалж AusIMM, 2012. Бусад эх сурвалжийг саарал өнгөөр тодруулав)

#### 4.3.3.2 – Торгуульт металл

Хүснэгт 15-д цайрын сульфидын баяжмалын нийтлэг үзүүлэлтийг харуулав.

Металл/Элемент	Зааг (%)
Цайр, Zn	40.0 – 56.0
Хүхэр, S	30.5 – 32.5
Төмөр, Fe	1.5 – 10.0
Хар тугална, Pb	1.0 – 3.0
Зэс, Cu	0.1 – 1.5
Кадмий, Cd	0.15 – 0.30
Мөнгө, Ag	10 – 200 g/t
Алт, Au	0 – 2 g/t

**Хүснэгт 15.** Цайрын сульфидын баяжмалын үзүүлэлт

Хүснэгт 16-д цайрын баяжмалд агуулагдах хортой нөлөө бүхий металл/элементийн торгуулийн нийтлэг хувь хэмжээ, зөвшөөрөгдсөн босгыг харуулав.

Дагалдах металл/элемент	Босго агуулга (%)	Торгууль, босго давсан агуулгад, доллар/тонн
Хүнцэл	0.2%	US\$2/1% Хүртгэл
Магнийн исэл (MgO)	0.3%	US\$1.5/0.1%
Магнийн исэл (MgO)	0.4%	US\$1.5/0.1%
Мөнгөн ус	50 ppm	US\$2/100 ppm
Мөнгөн ус	102 ppm	US\$1.5/10 ppm
Зэс	1%	US\$1.5/0.1%
Кобальт	0.035%	US\$1/0.001%
Хар тугалга	1.5%	US\$1.5/0.1%
Төмөр	8%	US\$1.5/1%
Манган	0.5%	US\$1.5/0.1%
Цахиурын исэл (SiO <sub>2</sub> )	2.5%	US\$2/1%
Хар тугалга	3.5	US\$2/1%

**Хүснэгт 16.** Цайрын баяжмалд ихэвчлэн агуулагддаг хортой нөлөө бүхий металлын хасагдуулгын жишээ (Эх сурвалж: Modified from AusIMM, 2012. Л.Бямбажаваас авсан мэдээллийг саарал өнгөөр тодруулав)

Тухайн жишээн дээр 8% -ийн босго хэмжээнээс 2.81% -иар хэтэрсэн, нийт дүндээ 10.81% буюу 3.86 долларыг хайлуулагч төмрийн агууламжийн торгууль болгож хасагдуулсан байхад Монгол Улсын Засгийн Газар төмрийн агууламжийн борлуулалтын үнэлгээг эерэг буюу 25.60 доллар байна гэж үзэн 2.17 долларын АМНАТ ногдуулсан байна (Хүснэгт 13).

#### 4.3.4 – Кейс 3: Төмрийн хүдрийн баяжмал

Энэхүү кейст 54.84% агуулгатай төмрөөс гадна Хүснэгт 17-д үзүүлсэнчлэн бага хэмжээний Cu, Zn, Pb, Ag зэрэг бусад олон метал/элементийг агуулсан төмрийн хүдрийн баяжмалыг авч үзлээ. Гаалийн итгэмжлэгдсэн лабораторийн шинжилгээгээр баяжмал нь хөнгөн цагаан, цахиур, фосфор, хүхэр зэрэг олон төрлийн хортой нөлөө бүхий металл/элемент агуулсан болохыг тогтоосон бөгөөд сүүлийнх нь 2.34% буюу зөвшөөрөгдөх хэмжээнээс дээгүүр байгаа тул торгууль ногдуулсан байна.

Төмрийн хүдрийн баяжмал	Агуулга	1 тонн баяжмалд					
		АМНАТ-ийн хувь хэмжээ, %		АМНАТ, АМТХ-ийн 47-р зүйлээр		АМНАТ, ЗГ-ын 342-р тогтоол, гэрээний үнээр	
		Үндсэн	Өсөн нэмэгдэх	Төгрөг	ам. доллар	Төгрөг	ам. доллар
<b>Үндсэн металл</b>	%						
<b>Төмөр</b>	54.84	5.0	3.5	29661.86	10.41	31843.16	11.17
<b>Дагалдах металл</b>	%						
Зэс	0.0273	5.0	12.0	1011.91	0.36		
Цайр	0.0175	5.0	2.4	101.19	0.04		
Хөнгөн цагаан	1.26	5.0	0.0	3575.47	1.25		
Хар тугалга	0.0047	5.0	1.6	15.86	0.01		
Хүхэр	2.43					-4307.59	-1.51
	гр/т						
Мөнгө	2.68	5.0	0.0	279.73	0.10		
<b>Дагалдах металлын дүн</b>				4984.16	1.76	-4307.59	-1.51
<b>БҮГД</b>				34646.03	12.17	27535.57	9.66
	Худалдан авагчаас төлбөр төлөгдсөн үндсэн ба дагалдах металл						

**Хүснэгт 17.** Монгол Улсын Засгийн Газраас төмрийн хүдрийн, чийгтэй, нэг тонн баяжмалд ногдуулж хураасан АМНАТ

Олборлогч зөвхөн төмрийн агууламжид төлбөр авсан бөгөөд хүхрийн агууламжид торгууль төлсөн байна.

Засгийн Газрын 2019 оны 342 дугаар тогтоолын дагуу төмрийн хүдрийн АМНАТ-ийг:

- АМТХ-ийн 47 дугаар зүйлийн дагуу тооцоолсон "борлуулалтын үнэлгээ", эсвэл
- хил хүртэлх тээврийн зардлыг багтаасан бодит "гэрээний борлуулалтын үнэлгээ"-ний аль нэгийг суурь болгон тогтооно.

Дээр дурдсан хоёр аргаар тодорхойлсон АМНАТ-ийн дүнгүүдийн зөрүү нь 30%-иас бага байх тохиолдолд гэрээний борлуулалтын үнэлгээг ашиглана. Бидний жишээнд дээрх зөрүү нь 30%-иас бага байсан тул гэрээний борлуулалтын үнэлгээг АМНАТ-ийн суурь үнэлгээний жишиг болгож ашигласан (Хүснэгт 18).

Хүснэгт 17-д үзүүлснээр төмөрт ногдуулах АМНАТ-ийн хувь хэмжээ 5%, өсөн нэмэгдэх хувь хэмжээ 3.5%, харин бусад дагалдах металлд янз бүр, жишээ нь, хөнгөн цагаанд 0%, зэсэд 12% байна.

#### ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА, КЕЙС 3: ТӨМРИЙН ХҮДРИЙН БАЯЖМАЛ

Чийгтэй 1 тонн баяжмалд

Төмрийн хүдрийн баяжмал	Монгол Улсын АМТХууль				Олон улсын	Австрали Улсын Уул уурхайн хууль				
	АМНАТ-ийн суурь үнэлгээ	АМНАТ			Хайлуулах үйлдвэрийн CIF цэвэр төлбөр	Экспортын боомтын FOB үнэ	Баруун Австралийн АМНАТ		Куйнсландын АМНАТ	
		АМТХ, 47-р зүйлээр	Америк доллар	%			ЗГ-ын 342-р тогтоолоор	Америк доллар	Америк доллар	%
Үндсэн металл										
Төмөр	122.46	10.41	85.61	11.17	122.46	104.07	7.81	100.00	1.65	100.00
Дагалдах металл										
Худалдан авагчаас төлөгдсөн	0.00	0.00		0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00
Худалдан авагчаас төлөгдөөгүй	29.70	1.75	14.39	-1.51	ө/б	ө/б	ө/б		ө/б	
Торгууль					-10.39	Тайлбар 1				
Дагалдах металлын дүн	29.7	1.75	14.39	-1.51	-10.39	0.00	0		0	
<b>БҮГД</b>	<b>152.16</b>	<b>12.16</b>	<b>100.0</b>	<b>9.66</b>	<b>112.07</b>	<b>104.07</b>	<b>7.81</b>	<b>100.0</b>	<b>1.65</b>	<b>100.0</b>
Нийт АМНАТ-д дагалдах металлын эзлэх хувь, %	19.52%	14.39%		-15.63%	-9.27%	0.00%	0.00%		0.00%	
Тайлбар 1:	Торгууль болон далайн тээврийн зардал(\$8.0/тонн)-ыг худалдан авагчаас төлөгдсөн үндсэн металлын үнийн дүнгээс хасаж FOB үнийг гаргасан болно.									

**Хүснэгт 18.** Монголын төмрийн хүдрийн баяжмалын АМНАТ-ийн суурь үнэлгээ ба орлогыг олон улсын NSV болон Баруун Австрали, Куинсландын тогтолцоотой харьцуулсан нь

Засгийн газрын 2019 оны 432 дугаар тогтоолын дагуу болон АМТХ-ийн 47 дугаар зүйлийн дагуу тооцсон АМНАТ-ийн зөрүү 30 хувиас хэтрэхгүй тохиолдолд бага дүнгээр нь ногдуулна.

Төмрийн 54.84%-ийн агуулга бүхий Монголын баяжмал нь БА-иас экспортолсон баяжмалаас нилээд бага (60-70% Fe) агуулгатай байх бөгөөд "beneficiated" буюу сайжруулсан төмрийн хүдэрт ангилагдах магадлалтай тул дараах тооцооллыг хийсний дараах FOB үнэлгээн дээр стандарт хувь болох 7.5%-иар АМНАТ-ийг бодож ногдуулах учиртай байх:

- Төмрийн 56%-ийн агуулга бүхий стандарт баяжмалаас 1.16% -иар бага агуулгатай байгаа тул түүнтэй уялдуулж үнийг тохируулах;
- доор дурдсанчлан баяжмалын хайлуулах үйлдвэрийн цэвэр үнэлгээ (NSV)-г гаргахын тулд торгуулиудыг хасах;

- үүнээс экспортын боомтоос цаашхи далайн тээврийн зардлыг чийгтэй тонн тутамд 8 ам.доллараар тооцож хасах.

Кл-ын хувьд төмрийн хүдрийн FOB үнэлгээнд хамаарах АМНАТ-ийн хувь хэмжээ нь хоёр шатлалтай бөгөөд төмрийн хүдрийн үнэ 100 доллар/т-оос бага байвал 1.25%, түүнээс дээш байвал 2.5% байна. Баяжмал борлуулах үеийн Австрали долларын Америк доллартай харьцах ханш 0.7596 байсныг хөрвүүлэхэд 75.96 ам.доллар хүртэл үнэтэй бол АМНАТ 1.25%-иар, үүнээс дээш бол 2.5%-иар тооцогдоно гэсэн үг юм.

Кейс 3-ын тооцооллын хүснэгтийн дэлгэрэнгүйг Хавсралт 7-д үзүүлэв.

Бусад түүхий эдийн хувьд Монголын төмрийн хүдрийн АМНАТ 9.66 ам.доллар байгаа нь төмрийн хүдрийн экспортоор тэргүүлэгч БА-ийн 7.81 ам.доллараас болон Кл-ын 1.75 ам.доллараас өндөр байна. Энэ ялгаа нь Монгол Улсын ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн хувь хэмжээ (өөрөөр хэлбэл үндсэн дээр 8.5% хүртэл нэмдэг) нь БА-д ашиглагддаг 7.5% -иас өндөр байгаатай ихээхэн холбоотой юм.

#### 4.3.4.1 Торгууль

Тяньжин Бохайн таваарын биржээр дамжуулдаг төмрийн хүдрийн баяжмалын CFR спот борлуулалтын гэрээний үзүүлэлтүүд болон торгуульгүй зөвшөөрөгдөх хязгаарыг харгалзан (Гуж нар, 2017) баяжмалын үнэлгээг хийсэн болно. Эдгээр нөхцлүүд нь багийн гишүүдийн харсан хэд хэдэн нууц гэрээнийхтэй ижил төстэй байв. Монголын жишээн дэх төмрийн хүдрийн баяжмалын дагалдах металл/элементүүдийн агуулга нь зөвшөөрөгдөх дээд хязгаараас хэтрээгүй, харин хүхрийн агуулга нь зөвшөөрөгдөх 0.10% -ийн үзүүлэлтийг давсан тул давсан хувь тутамд 44.5 долларын буюу нийт 10.39 ам.долларын торгууль төлсөн байгааг тэмдэглэх нь зүйтэй.

Торгуулийн металл/элемент	Стандарт агуулга, %	Зөвшөөрөгдөх дээд агуулга, %	Зөвшөөрөгдөх агуулгаас давсан 1% тутамд ногдуулах торгууль
Хөнгөн цагаан	1.60	2.70	1.5\$/1.0%
Цахиур	6.50	8.00	1.5\$/1.0%
Фосфор	0.08	0.15	4.5\$/1.0%
Хүхэр	0.06	0.10	4.5\$/1.0%
Бүхэллэг >10мм	8.00	15.00	0.18\$/1.0%

Хүснэгт 19. Төмрийн хүдрийн баяжмалд ногдуулах торгуулийн хэмжээ

## 5 ЦААШДЫН АРГА ЗАМУУД: “ДАГАЛДАХ МЕТАЛЛ” -ЫН БОДЛОГЫГ ӨӨРЧЛӨХ ХУВИЛБАРУУД

### 5.1 Өнөөгийн АМНАТ-ийн тогтолцоонд томоохон шинэчлэл хийх шаардлагагүй

Монголын АМНАТ-ийн тогтолцооны суурь нь эрүүл бөгөөд хүдэр/баяжмалд агуулагддаг, худалдан авагч төлбөр хийдэггүй "дагалдах металл"-д АМНАТ-ийг олон улсын практикт нийцэхгүй горимоор тогтоодгоос бусад хэсэгт өөрчлөлт оруулах шаардлагагүй гэж бид үзэж байна. Цаашилбал, "торгууль" ногдуулдаг, боловсруулах технологид хортой нөлөө бүхий, зах зээлийн сөрөг үнэлгээтэй металл/элементүүдэд ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр ногдуулж байгаа нь логикгүй бөгөөд процедурын хувьд ч шударга бус юм.

Гэхдээ Монголын АМНАТ-ийн тогтолцоо нь салбарын зүгээс бус, харин Засгийн Газрын зүгээс авч үзвэл олон сайн талуудтай. Жишээ нь:

- АМНАТ-ийг ямар нэгэн хасагдуулгагүйгээр, борлуулалтын нийт үнэлгээнд үндэслэн тооцох нь зайлсхийхэд хэцүү болгож байгаа бөгөөд энэхүү судалгааны тайлангаар санал болгож буй бага зэргийн өөрчлөлтийг оруулсан тохиолдолд бүр ч ойлгомжтой бөгөөд удирдахад хялбар болох юм.
- АМНАТ-ийн хувь хэмжээг тухайн бүтээгдэхүүний үнэ ба боловсруулалтын түвшинтэй нь уялдуулан тогтоож байгаагаараа Монголын энэ тогтолцоо үнэлгээнд суурилдаг олон улсын тогтолцооны дундаас эдийн засгийн хувьд хамгийн үр ашигтай нь юм.
- Гаалийн болон түүний магадлан итгэмжлэгдсэн лабораториудын физик/химийн шинжилгээ, хяналтаар уг тогтолцоог дэмжиж байгаа нь харагдаж байна.

Монгол Улсын уул уурхайн салбарын борлуулалтын дүнд АМНАТ-ийн орлогын эзлэх хувь нь олон улсын жишгээс харьцангуй өндөр байгаа бөгөөд түүний тодорхой хэсгийг харьцангуй бага түвшинд байдаг ААНОАТ-аар нөхөх хэдий ч энэ нь ГШХО-г үргээж, улмаар тус улсын татварын баазын тэлэлтийг хязгаарлаж байна.

Сайн тал нь "дагалдах металлын" асуудлыг шийдвэрлэхэд хууль тогтоомжид томоохон өөрчлөлт оруулах шаардлагагүй бөгөөд одоогийн захиргааны процессыг хялбарчлахад үр дүн гаргаж болохоор харагдаж байна. Одоогоор салбарынхныг тайтгаруулах зэрэг эдийн засгийн шууд бус үр нөлөөг үл тооцлоо гэхэд зайлшгүй хийх хэрэгтэй хэмээн доор дэлгэрүүлэн тайлбарлаж, санал болгож байгаа өөрчлөлтүүдийг харьцангуй бага өртгөөр хэргэжүүлэх боломжтой.

## **5.2 “Дагалдах металл”-ын АМНАТ-ийн бодлогыг тогтоох логик алхмууд**

Өмнө дурьдсанчлан, Монгол Улсад “дагалдах металл”-д АМНАТ ногдуулахад тулгардаг гол асуудал нь АМТХ-ийн 47 дугаар зүйл, холбогдох журмын “борлуулалтын үнэлгээ” гэсэн нэр томъёог хэтэрхий шууд утгаар тайлбарлаж байгаагаас үүдэлтэй юм.

Зураг 9-ийн диаграмм нь хүдэр, баяжмалыг зах зээлд гаргаж буй байдлаар авч үзэхэд түүнд агуулагдах металл нь "борлуулалтын үнэлгээ"-гэй байна уу, үгүй юу гэдгийг тайлбарлах логик алхмуудыг харуулах зорилготой зурагдсан юм.

Диаграммын орой хэсгээс харахад гол металл болон дагалдах металл (ууд) -ыг хүдэр, баяжмалаас ялган авч болох тохиолдолд тэр нь борлуулалтын үнэлгээтэй байх тул АМНАТ-д хамрагдах ёстой.

Харин эсрэгээрээ, жишээ нь төмрийн хүдэрт агуулагддаг хөнгөн цагаан нь гангийн үйлдвэрлэлд шаарга үүсгэдэг шиг хүдэр/баяжмалд агуулагдах металл/элемент нь тухайн хүдэр/баяжмалыг хайлуулах/цэвэршүүлэх процесст хортой нөлөө үзүүлдэг бол худалдагч талд үнийн "торгууль" ногдуулдаг, өөрөөр хэлбэл тухайн металл/элементийн борлуулалтын үнэлгээ нь үнэн хэрэгтээ сөрөг байна гэсэн үг юм. Тийм учраас “торгууль” тавигддаг “металл/элемент”-д АМНАТ ногдуулах ёсгүй.

Хэрэв дагалдах метал/элементэд худалдан авагч төлбөр төлсөн бол, өөрөөр хэлбэл үндсэн металл(ууд)-ын үнэнд "урамшуулал"-ыг нэмж оруулсан бол түүнийг хүдэр/баяжмалаас ялгаж авах эсэхээс үл хамааран АМНАТ ногдуулах ёстой.

Хэрвээ тухайн дагалдах металл/элементийг техник технологийн хувьд ялгаж авах боломжгүй бол хүдэр/баяжмал дахь агууламжаас үл хамааран борлуулалтын ямар ч үнэлгээгүй байх тул түүнд АМНАТ ногдуулах ёсгүй.

Тухайн дагалдах металл/элементийг техник технологийн хувьд ялгаж авах боломжтой боловч худалдагч тал ямар нэг төлбөр эсвэл "урамшуулал" аваагүй бол түүнд дээрхтэй нэгэн адил АМНАТ ногдуулах ёсгүй.

Зарим тохиолдолд тодорхой металл/элементүүд үнийн маш өөдрөг төсөөлөлтэйгөөр, өндөр технологиор ч ялган авах боломжгүй тийм бага агуулгатай бол тэдгээрийг ямар ч үнэ цэнэгүй гэж итгэлтэйгээр тооцож болох юм.

Бусад тохиолдолд металл/элементийн агуулга нь өнөөгийн нөхцөл байдалд, эсвэл ирээдүйн зах зээл, технологийн дэвшлийн нөхцөлд ялган авах асуудлыг арилжааны хувьд нухацтай авч үзэх хэмжээнд хангалттай өндөр байж болох бөгөөд дараах хүчин зүйлүүдээс хамааран хэлбэлзэж болох юм. Үүнд:

- хүдрийн агуулга, металлургийн шинж чанар;
- байршил/тээвэрлэлттэй холбоотой ложистикийн асуудлууд, боловсруулалтад шаардлагатай ус, эрчим хүчний хангамж гэх мэт;
- орон нутгийн нийгэм, байгаль орчны хандлага, хог хаягдалд тавьдаг шаардлагууд;
- ашигт малтмалын ордын металл/элементийн нийт агууламж нь боловсруулах үйлдвэрийн анхны хөрөнгө оруулалтыг нөхөхөд хангалттай хэмжээнд байгаа эсэх;
- улс орны болон бусад эрсдэл.

Уул уурхайн боломжит бүтээн байгуулалтын өгөөжийг нэмэгдүүлж, оновчтой болгох тал дээр ихэнх тохиолдолд салбарын болон Засгийн Газрын ашиг сонирхол нийцэж байх ёстой гэж үзвэл төлбөр авдаггүй метал/элементүүдэд АМНАТ ногдуулахгүй байх бодлого баримтлах ёстой.

Нөгөө талаар зарим тохиолдолд ашиг сонирхол нь тэр бүр салбарын ашиг сонирхолтой бүрэн нийцэхгүй байх талтай гэж Засгийн Газар үзвэл дараах чиглэлийг баримтлах боломжтой:


- Ашигт малтмалын ордыг ашиглах Хүсэлтийн мэдэгдэл (NoI) -ийн үндэслэл болгож компаниас ирүүлсэн ТЭЗҮ-д тусгагдсан бүтээн байгуулалт нь улс орны зүгээс авч үзэхэд оновчтой юу, харьцангуй өндөр агууламжтай байгаа "дагалдах металл" -ыг ямар үндэслэлээр ялган авч эдийн засгийн эргэлтэд оруулах боломжгүй гэж үзсэнийг асууж тодруулах хэрэгтэй. Хэрэв эдийн засгийн ач холбогдолтой гэж ерөнхийд нь үзэж болохоор зарим дагалдах металлыг ялгаж авахад шаардлагатай хөрөнгийг гаргах сонирхолгүй байна гэж Засгийн Газар сэжиглэвэл яагаад ийм эдийн засгийн хувьд ашиггүй байх үйлдэл гаргаж байгаа учир шалтгааныг судалж, мэдэх ёстой. Үүний шалтгаан нь нэлээн нарийн төвөгтэй бөгөөд техникийн, байгаль орчин, санхүү, геополитикийн эрсдлүүдийг цогцоор нь тооцсон байж магадгүй бөгөөд тэр нь олох ашиг орлогын хэвийн хэмжээнээс өндөр байж болох талтай. Үүн дээр үндэслэн тухайн ордын ашиглалтын төлөвлөгөөг дахин авч үзэх, эсвэл ашиглалтын эцсийн төлөвлөгөөнд компани нь ирээдүйд тухайн дагалдах металлын үнэ өөрчлөгдсөн, эсвэл холбогдох металлургийн технологид ахиц дэвшил гарсан нөхцөлд дагалдах металлын арилжааны ач холбогдлыг дахин авч үзэх үүргийг олборлогч уул уурхайн компанид хүлээлгэж болох юм.
- Засгийн Газар тодорхой төрлийн хүдэр, баяжмал дахь тодорхой металл/элементийн агууламжийн ерөнхий босго хязгаарыг хуульчлан тогтоож болох бөгөөд тухайн хязгаараас дээш агуулга бүхий металл/элемент нь онолын хувьд арилжааны ач холбогдолтой гэж үзэн уг металл/элементэд худалдан авагч мөнгө төлсөн эсэх, ялгаж авах эсэхээс үл хамааран АМНАТ ногдуулах боломжтой юм. Дээрх хүчин зүйлсээс шалтгаалан эдгээр хязгаарыг дэлхийн уул уурхайн үйл ажиллагааны нөхцөл байдлыг ерөнхийд нь харгалзан нилээд баримжаалсан, ерөнхий түвшинд тогтоож болох бөгөөд зах зээлийн өөрчлөлт, техник технологийн дэвшилтэй уялдуулан тогтмол хугацаанд албан ёсоор эргэн нягталж, шинэчилж байх шаардлагатай. Эдгээр хязгаарыг Монголд болон бусад газарт бүтээн байгуулалт хийх боломжтой эсэхийг тогтоох техникийн үндэслэл баримжаа болгох зорилгоор тогтоохгүй бөгөөд энэхүү хязгаар нь зөвхөн АМНАТ тогтоох захиргааны хэрэгсэл байх юм. Энд дурдан буй аргыг БА-ийн манган болон ванадий агуулсан төмрийн хүдэр, баяжмалд тусгайлан хэргэжүүлсэн байдаг. Бодит байдал дээр ийм бодлогын хүрээнд ногдуулан авах АМНАТ-ийн хэмжээ нь харьцангуй бага байж болох юм. Ялангуяа холбогдох захиргааны зардлыг тооцсоны дараа ерөнхий түвшиндөө бүр ч бага байна. Ийм тохиолдолд олборлогч ямар нэг төлбөр, урамшуулал авдаггүй бүх металл/элементүүдийг, ялангуяа дор дурдсанчлан үнэт бус дагалдах металл/элементүүдийг АМНАТ-аас чөлөөлөх үндэслэлийг эргэн харж болох юм.

Дээрх тайлбарт үндэслэн, мөн олон улсын туршлагын дагуу доорх метал/элементэд АМНАТ ногдуулах ёсгүй гэсэн гол дүгнэлтэд хүрч байна:

1. худалдагч талд "торгууль" ногддог металл/элементүүд;



2. хүдэр/ баяжмал дахь агуулгаас үл хамааран одоогийн болон ойрын ирээдүйн техник технологийн шийдлээр ялган авах боломжгүй металл/элементүүд;
3. үнийн хамгийн өөдрөг төсөөлөлтэйгөөр, хамгийн дэвшилтэт технологиор ч ялгаж авах боломжгүй маш бага агуулгатай металл/элементүүд;
4. Засгийн Газраас эдийн засгийн ач холбогдолтойд тооцохоор тогтоосон хамгийн доод босгоос доогуур агуулгатай бөгөөд захиргаа удирдлагын зардлыг тооцсоны дараа үлдэх орлого нь харьцангуй бага байх металл/элементүүд;
5. эсрэг тохиолдолд, худалдагч тал нэмэлт төлбөр урамшуулал авдаггүй бүх металл/элементүүдийг, тухайлбал үнэт бус металл/элементүүдийг АМНАТ-аас чөлөөлөх хувилбарыг цаашдын үйл ажиллагааны үндсэн чиглэл гэж авч үзэх нь зүйтэй юм.





### 5.3 Энэ тайлангийн зөвлөмжийг хэргэжүүлэхэд гарах эдийн засгийн үр нөлөө

Дагалдах металлтай холбоотой зохицуулалтын гажуудлыг арилгахын шууд ба шууд бус үр ашиг нь зохицуулалтыг хийснээр алдагдах боломжоос урт хугацаандаа хамаагүй давж гарна гэж үзэж болохоор байна. Зохицуулалтын хоёр хувилбарыг авч үзсэн бөгөөд үүний дагуу дараах дагалдах металлуудыг АМНАТ-өөс чөлөөлнө. Үүнд:

- бүх үнэт бус дагалдах металлууд;
- нэмэлт төлбөр “урамшуулал” төлөгдөөгүй, багахан хэмжээний дагалдах үнэт металлууд, өөрөөр хэлбэл алт, мөнгө (энд үндсэн бүтээгдэхүүн хэлбэрээр олборлосон алт, мөнгө орохгүй).

Доор тодорхой дурдсанчлан, дээрх хоёр зохицуулалтыг хэргэжүүлснээр алдах АМНАТ-ийн орлого нь харьцангуй бага байх бөгөөд Засгийн Газрын хувьд захиргааны нэлээд хэмжээний арвилан хэмнэлт дагуулах боломжтой.

#### 5.3.1. "Дагалдах металл"-ын АМНАТ-ийн зохицуулалтын гажуудлыг засах өртөг

Энэхүү тайлангийн зөвлөмжийг хэргэжүүлсэн тохиолдолд алдах байсан АМНАТ-ийн орлогын хэмжээг 2019-2020 онд дагалдах металлуудад ногдуулсан АМНАТ-ийн орлогын бүрдүүлэлтийн түүхэн мэдээг үндэслэн нарийвчлан тооцсон болно. АМНАТ-ийн 2019-2020 оны орлогын мэдээллийг Монгол Улсын Татварын Ерөнхий газрын ноён Н.Мөнхбилэг гаргаж өгсөн бөгөөд мэдээллийг Хавсралт 8-д үзүүлж, Хүснэгт 20-д нэгтгэн харуулав.

Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн орлого	2019	2020	
	Тэрбум төгрөг	Тэрбум төгрөг	Сая ам. доллар
<b>Нийт металл, Үүнд:</b>	<b>1,323.40</b>	<b>1,572.47</b>	<b>628.99</b>
<i>1-Үндсэн металл</i>	<i>1,262.79</i>	<i>1,499.22</i>	<i>599.69</i>
<i>2-Дагалдах металл</i>	<i>60.61</i>	<i>73.25</i>	<i>29.30</i>
<b>Дагалдах металлууд, Үүнд:</b>			
<b><i>1-Үнэт металл</i></b>	<b><i>55.91</i></b>	<b><i>66.74</i></b>	<b><i>26.70</i></b>
<i>Алт</i>	<i>47.73</i>	<i>49.98</i>	<i>19.99</i>
<i>Мөнгө</i>	<i>8.18</i>	<i>16.76</i>	<i>6.71</i>
<b><i>2-Үнэт бус дагалдах металл</i></b>	<b><i>4.70</i></b>	<b><i>6.51</i></b>	<b><i>2.61</i></b>
Нийт АМНАТ-ийн орлогод дагалдах металлын эзлэх хувь, %	4.58%	4.66%	
Нийт АМНАТ-ийн орлогод үнэт дагалдах металлын эзлэх хувь, %	4.22%	4.24%	
Дагалдах металлын АМНАТ-ийн орлогод үнэт бус дагалдах металлын эзлэх хувь, %	0.36%	0.41%	

**Хүснэгт 20.** Үндсэн болон дагалдах металлаас 2019, 2020 онуудад төвлөрүүлсэн АМНАТ-ийн орлогын задаргаа (Эх үүсвэр: ноён Н.Мөнхбилэг, Монгол Улсын Татварын ерөнхий газар)

2020 онд дагалдах металлд ногдуулсан АМНАТ-ийн дүн 73.25 тэрбум төгрөг буюу ойролцоогоор 29.3 сая доллартай тэнцэж байгаа бөгөөд тухайн жилд төвлөрүүлсэн нийт АМНАТ (1.572.47 тэрбум төгрөг буюу 628.99 сая доллар)-ийн орлогын дөнгөж 4.7% -ийг эзэлжээ.

Үнэт бус дагалдах металлын АМНАТ-ийн орлого нь 6.51 тэрбум төгрөг буюу 2.61 сая доллартай тэнцүү байсан бөгөөд тухайн жилд төвлөрүүлсэн дагалдах металлын АМНАТ-ийн орлогын 8.9%, нийт АМНАТ-ийн орлогын 0.41% -ийг тус тус эзэлж байна.

Энэхүү харьцангуй бага хэмжээний тоон үзүүлэлт нь үнэт бус дагалдах металлыг АМНАТ-өөс чөлөөлсөн тохиолдолд алдах байсан орлогын хэмжээг илэхрийлж байгаа юм. Гэхдээ энэхүү орлогын алдагдлын тодорхой хэсэг нь захиргааны болон лабораторийн химийн шинжилгээний зардлын хэмнэлтээр нөхөгдөнө.

Дагалдах металлын АМНАТ-ийн дийлэнх хэсгийг төрөл бүрийн, ялангуяа зэсийн баяжмалд агуулагдаж буй алт, мөнгөнд ногдуулсан АМНАТ (66.74 тэрбум төгрөг буюу 26.7 сая доллар) бүрдүүлж байна. Мөн үндсэн металл байдлаар олборлосон алтанд ногдуулсан АМНАТ (142.71 тэрбум төгрөг буюу

57.08 сая доллар) үүн дээр нэмэгдэж байгаа бөгөөд эдгээр мэдээллийг Хүснэгт 21-д тодорхой харуулсан болно.

АМНАТ ногдуулсан алт, мөнгөний (төмрийн хүдрийн баяжмал дахь алтыг эс тооцвол) дийлэнх хэсгийг Засгийн Газар, эсвэл хайлуулах үйлдвэрүүдийн зүгээс “урамшуулал” буюу нэмэлт төлбөр хийгдсэн алт, мөнгө эзэлж байна.

Дараагийн хүснэгтүүдэд металлын хасагдуулга хийгдсэн, цэвэршүүлэх зардлыг хасаж тооцсон дагалдах үнэт металл болон маш бага агуулгатай учраас нэмэлт төлбөр “урамшуулал” төлөгдөөгүй дагалдах үнэт металл ногдуулсан АМНАТ-ийн харьцааг үзүүлэхийг зорьсон болно.

Металл	Зэсийн баяжмалд	Үндсэн металл хэлбэрээр олборлосон	Цайрын болон хар тугалганы баяжмалд	Төмрийн хүдрийн баяжмалд	Нийт дүн, тэрбум төгрөг
Үнэт металл					
Алт	45.937	1.859	2.182	0.0003	49.979
Мөнгө	6.669	5.207	4.857	0.0001	16.763
Үнэт металлын дүн, тэрбум төгрөг	52.637	7.066	7.039	0.0004	66.742
Үнэт бус металлын дүн, тэрбум төгрөг	0.000	0.343	4.415	1.7545	6.513
<b>БҮГД</b> (нийт дагалдах металлууд), тэрбум төгрөг	<b>52.637</b>	<b>7.409</b>	<b>11.454</b>	<b>1.7549</b>	<b>73.255</b>
Үнэт металлын нийт үнэлгээнд нэмэлт төлбөр буюу “урамшуулал” төлөх хувь хэмжээ	100%	төлдөг	85%	Ихэнхдээ төлдөг	
	50%	Хэсэгчлэн төлдөг	0%	Төлдөггүй	

**Хүснэгт 21.** АМНАТ ногдуулах матриц, баяжмалын төрөл болон “урамшуулал” төлөгдөх дагалдах металлын хувь хэмжээгээр задлан харуулав. Энэхүү илтгэлийн зөвлөмжийг хэргэжүүлсэн тохиолдолд 2020 онд алдах байсан орлогыг үнэлэхэд ашиглав.

Энэхүү илтгэлийн зөвлөмжийг хэргэжүүлж, олборлогч төлбөр авдаг дагалдах металлуудын АМНАТ-ийг хязгаарласан тохиолдолд алдах байсан АМНАТ-ийн орлогыг үнэлэх зорилгоор Хүснэгт 21-д үзүүлснээр Монголбанкинд тушаасан алт, мөнгөний 100% (ногоон өнгөөр тэмдэглэв), зэсийн баяжмал дахь алт, мөнгө, цайр, хар тугалганы баяжмал дахь мөнгөний 85% (хүрэн өнгөөр тэмдэглэв), цайр, хар тугалганы баяжмал дахь алтны 50% (хөх өнгөөр тэмдэглэв)-д төлбөр авах байв. Харин төмрийн хүдрийн баяжмал дахь үнэт металл болон бүх үнэт бус дагалдах металлаас төлбөр авахгүй байв (шар өнгөөр тэмдэглэв).

Дээрх таамаглалд үндэслэн тооцвол, олборлогч уурхай нэмэлт төлбөр “урамшуулал” авдаггүй үнэт металлыг АМНАТ-өөс чөлөөлсөн тохиолдолд 2020 онд алдах байсан орлого 9.719 тэрбум төгрөг буюу 3.89 сая ам. доллар орчим болох байв (Хүснэгт 22). Энэ тооцоо нь маш ойролцоо тооцоо боловч алдах байсан АМНАТ-ийн орлого тийм ч их биш, нийт дагалдах үнэт металлын АМНАТ-ийн 14,6%-ийг л эзлэх байв.

Үнэт бус дагалдах металлаас ялгаатай нь, үнэт дагалдах металтай холбоотой дээрх хөнгөлөлт чөлөөлөлтийг уул уурхайн салбарт үзүүлсэн тохиолдолд захиргааны нарийн төвөгтэй ажиллагаа, нэмэлт зардал шаардагдах магадлалтай. Тухайлбал, эхний ээлжинд Засгийн Газар ердийн журмаар дагалдах үнэт металл АМНАТ ногдуулах авах бөгөөд харин дараа нь АМНАТ төлөгчийн өргөдөл, тодорхойлолт, эрх бүхий байгууллагын аудит, худалдан авагчаас төлсөн нэмэлт төлбөр “урамшуулал”-ын баримт сэлтийг үндэслэн АМНАТ-ийг дахин тооцоолж, холбогдох тохируулга, буцаан олголт хийж байх хэрэгтэй болох юм.

Засгийн Газарт АМНАТ-өөс чөлөөлөх дараах хувилбарууд байж болох юм. Үүнд:

- бүх төрлийн үнэт бус дагалдах металлуудыг АМНАТ-аас чөлөөлөх. Ингэснээр 6.51 тэрбум төгрөг (2.61 сая доллар)-өөр буюу дөнгөж 0.41%-иар АМНАТ-ийн орлого буурах боловч нөгөө талдаа тогтолцоог ихээхэн хялбаршуулж, захиргааны зардлыг хэмнэх юм.
- Мөн олборлогч нэмэлт төлбөр “урамшуулал” авдаггүй дагалдах үнэт металлуудыг АМНАТ-өөс чөлөөлөх. Ингэснээр 9.715 тэрбум төгрөг (3.89 сая доллар)-өөр буюу 0.62%-иар АМНАТ-ийн орлого буурах боловч нөгөө талдаа мөн л захиргааны ажиллагааг ихээхэн хялбаршуулж, зардлыг хэмнэх юм.
- Эсвэл, олборлогч нэмэлт төлбөр “урамшуулал” авдаггүй бүх төрлийн дагалдах металлыг АМНАТ-өөс чөлөөлөх. Ингэснээр 16.228 тэрбум төгрөг (6.49 сая доллар)-өөр буюу 1.03%-иар нийт АМНАТ-ийн орлого, 21.15%-иар дагалдах металлын АМНАТ-ийн орлого тус тус буурах юм. АМНАТ-ийн орлого буурах дээрх тооцооллуудыг 2020 оны нийт АМНАТ-ийн орлого (73.255 тэрбум төгрөг буюу 29.30 сая доллар)-той харьцуулан хийсэн болно.

Дагалдах металл	Зөвлөмжийг хэргэжүүлснээр 2020 оны алдах байсан АМНАТ-ийн орлого	
	Тэрбум төгрөгөөр	Сая ам доллароор
Үндсэн металл хэлбэрээр олборлосон алт, мөнгө	0.000	0.00
Зэсийн баяжмал дахь алт, мөнгө	7.896	3.16
Цайр, хар тугалганы баяжмал дахь мөнгө	0.729	0.29
Цайр, хар тугалганы баяжмал дахь алт	1.091	0.44
Төмрийн хүдрийн баяжмал дахь алт, мөнгө	0.000	0.00
Нийт дагалдах үнэт металл	<b>9.715</b>	<b>3.886</b>
Нийт дагалдах үнэт бус металл	<b>6.513</b>	<b>2.61</b>
“Урамшуулал”-гүй нийт дагалдах металлуудын дүн	<b>16.228</b>	<b>6.491</b>

**Хүснэгт 22.** Энэхүү илтгэлийн зөвлөмжийг хэргэжүүлсэн тохиолдолд 2020 онд алдах байсан АМНАТ-ийн орлогын таамаг тооцоо

Энэхүү алдах байсан орлого нь уул уурхайн салбарын татварын нийт орлоготой харьцуулахад тийм ч их биш бөгөөд доор өгүүлсэнчлэн зөвлөмжийг хэргэжүүлснээр бий болох мөнгөн ба мөнгөн бус үр өгөөжийг тооцож үзвэл бүр ч их биш юм.

### 5.3.2 Мөнгөн болон мөнгөн бус үр өгөөж

Доорх Хүснэгт 23-т уул уурхайн үр өгөөж нь мөнгөн/санхүүгийн ба мөнгөн бус/эдийн засгийн байдгийг нэгтгэн харуулав.

Эхний бүлэгт голчлон:

- АМНАТ-ийн орлогыг төвлөрүүлэх, үүнтэй холбоотой эрх зүйн маргааныг хянан шийдвэрлэх захиргааны үйл явцыг хялбаршуулах замаар мөнгөн хөрөнгийн хэмнэлт бий болох,
- Шинээр бий болох уул уурхайн төслүүдээс татан төвлөрүүлэх АМНАТ, аж ахуйн нэгжийн орлогын албан татвар (ААНОАТ) болон тус бүрдээ бага боловч нийт дүнгээрээ нэлээд хувийг эзлэх бусад төрлийн татвар, хураамжууд. Дагалдах металлын АМНАТ-ийн тогтолцооны “гажиг”-ийг зассанаар Монгол Улсын АМНАТ-ийн тогтолцоог уул уурхайн салбар илүү нааштай хүлээн авч, Засгийн Газар нь салбарыхаа эрэлт хэрэгцээнд илүү мэдрэмжтэй ханддаг гэсэн ойлголт төрөх магадлалтай. Энэ нь явцдаа геологи хайгуул болон орд газруудын ашиглалтад хөрөнгө оруулалтыг татаж, татварын бааз суурийг өргөтгөснөөр эцсийн дүндээ татан төвлөрүүлэх татварын хэмжээг нэмэгдүүлэх юм.
- Хайгуулын болон ашиглалтын шинэ төслүүдэд ажиллагсад болон тэдний ханган нийлүүлэгчид, үйлчилгээ үзүүлэгч зомпаниудад ажиллагсдын хувь хүний орлогын албан татвар.
- Бусад ажлын байрнуудын татварын нэмэлт орлого. Vivens (2019)-ийн тооцоолсноор, уул уурхайн салбар дахь ажлын нэг байр нь эдийн засагт 3,9 ажлын байр шинээр бий болгодог байна.

Хоёрдугаарт, мөнгөн бус/эдийн засгийн бүлэгт уул уурхайн компанид ашиглалтын тусгай зөвшөөрлийг олгохдоо ихээхэн хэмжээний үүрэг хариуцлагыг ногдуулдаг. Зарим тохиолдолд "бараг АМНАТ" гэж нэрлэгддэг үүргүүдийн дотор нийтийн хэрэгцээний дэд бүтэц байгуулах, орон нутгийн иргэдэд учруулж буй нөлөөллөөс давсан хэмжээнд төлбөр төлөх, зах зээлийн бус давуу таатай нөхцлөөр орон нутгаас худалдан авалт хийх, компанийн шууд хэрэгцээнээс гадуурх боловсрол, сургалтаар хангах зэрэг шаардлага, нөхцлүүд багтдаг.

Мөнгөн бус нийгэм-эдийн засгийн үр өгөөж, өртөг зардал нь төслийн нөлөөллийн бүс нутгаас гадна улс орны эдийн засагт шууд бус хэлбэрээр мөн нөлөөлөх магадлалтай. Эдийн засагчид эдгээрийг эдийн засагт үзүүлэх нөлөө гэж үздэг бөгөөд энэ нь эерэг, сөрөг аль аль нь байж болно.

Эдийн засагт үзүүлэх нөлөөг мөнгөн дүнгээр тооцохын тулд эдийн засгийн цогц загварчлал хэрэглэх, мөн өртөг, үр ашгийн дүн шинжилгээ хийх шаардлагатай бөгөөд энэ нь бидний энэ ажлын хүрээнээс хальсан асуудал юм.

	<b>Мөнгөн/Санхүүгийн</b>	<b>Мөнгөн бус/Эдийн засгийн</b>
<b>Шууд</b>	<ul style="list-style-type: none"> <li>• АМНАТ</li> <li>• ААНОАТ</li> <li>• Хөрөнгө борлуулсны орлогын албан татвар</li> <li>• Засгийн Газрын хувьд ногдох ашиг</li> <li>• Экспорт, импортын татвар, онцгой албан татвар</li> <li>• Түрээсийн төлбөр</li> <li>• Хил дамнасан ногдол ашиг, хүү болон бусад шилжүүлгийн суутган</li> <li>• Бусад янз бүрийн татвар, ногдуулалт, жишээ нь, НӨАТ, тэмдэгтийн хураамж, цалингийн суутган гэх мэт.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Нийтлэг хэрэглээний дэд бүтцийг бүтээн байгуулах, сайжруулах зардалд оруулсан хувь нэмэр</li> <li>• Уурхайн ойролцоох иргэдэд үзүүлсэн ахуйн үйлчилгээ</li> <li>• Иргэдэд учирсан бодит нөлөөллөөс давсан нөхөн төлбөр</li> <li>• Орон нутагт сургалт явуулах, ажлын байр бий болгох</li> <li>• Орон нутгийн ханган нийлүүлэгчдэд давуу эрх олгон худалдан авалт хийх</li> </ul>
<b>Шууд бус</b>	<p>Улсын хэмжээн дэх ажил эрхлэлт болон бусад үржүүлэгчдийн үр нөлөө:</p> <ul style="list-style-type: none"> <li>• Ажиллагсдаас хураасан хувь хүний орлогын албан татвар: <ul style="list-style-type: none"> <li>○ Уул уурхайн компаниудын ажиллагсдын болон,</li> <li>○ Тэдгээрийн ханган нийлүүлэгчид, үйлчилгээ үзүүлэгч компаниудын ажиллагсдын.</li> </ul> </li> <li>• Үйлчилгээ үзүүлэгч, ханган нийлүүлэгч компаниудад ногдуулдаг ААНОАТ болон бусад татвар, ногдуулалт;</li> <li>• Хувьцаа эзэмшигчдийн ногдол ашгийн татвар.</li> </ul>	<p>Нийгэм, эдийн засагт үзүүлэх нөлөөлөл:</p> <ul style="list-style-type: none"> <li>• Эерэг: <ul style="list-style-type: none"> <li>○ Хил орчмын бүс нутгийн хөгжил;</li> <li>○ Бүс нутгийн геологийн шинжлэх ухааны мэдлэг, хөрөнгө оруулалтыг татахад оруулах хувь нэмэр;</li> <li>○ Улс орны стратегийн нөөцийг хангахад оруулах хувь нэмэр.</li> </ul> </li> <li>• Сөрөг: <ul style="list-style-type: none"> <li>○ Байгаль орчинд үзүүлэх нөлөө;</li> <li>○ Нутгийн уугуул иргэдэд нөлөөлөх байдал.</li> </ul> </li> </ul>

**Хүснэгт 233.** Уул уурхайн үр өгөөж, зардлын шинж чанар.

(Эх сурвалж: Шинэчилсэн Lilford and Guj, 2020)



### 5.3.3 Дагалдах металлын бодлогыг эцэслэн тодорхойлоход салбарыхны оролцоо

Уул уурхайн төслүүдээс гарах олон талын эерэг нөлөөллийг тус салбарыхан тодотгож, онцлохыг чармайдаг хэдий ч уул уурхайн татварын яриа хэлэлцүүлэг бараг л бүхэлдээ мөнгөн дүнгийн асуудлыг тойрон явагддаг. Энэ харилцаа нь Засгийн Газрын богино ба дунд хугацааны орлогыг уул уурхайн компаниудын орлого ашигтай баланслуулахад нэгнийх нь ашиг нөгөөд нь алдагдал болж байдаг “тэг тэнцэл”-тэй тоглоом шиг харагддаг.

Хэдийгээр Засгийн Газар ба салбарын хооронд үр дүнтэй, харилцан хүлээн зөвшөөрөх зохицуулалтыг тогтооход симбиотик харилцаа байх ёстой боловч хамтран зөвлөлдөж, харилцаж, бие биенийхээ эрэлт хэрэгцээ, хүлээлтийг мэдрэх замаар аль аль талдаа ашигтай шийдлийг олж тохиролцох боломж тун ховор тохиодог. Энэ шалтгааны улмаас тухайн салбар болон Засгийн Газар бие биендээ тодорхой хэмжээгээр сэжиглэнгүй хандах явдал байдаг бөгөөд ихэнх улс орнуудад салбар болон Засгийн газар хоорондын харилцаа нь хамтын ажиллагаа, ил тод байдлаас нэлээн хол хөндий, түүгээр ч барахгүй олон тохиолдолд тэдний харилцаа бүр эсрэг тэсрэг байх нь бий.

Манай тохиолдолд ийм асуудал байхгүй бөгөөд учир нь Засгийн Газар “дагалдах металл” -тай холбоотой асуудлыг шийдэх хэрэгцээ, шаардлага байгааг олж хараад, асуудлыг шийдэх стратегийг судалж байгаа билээ. Дагалдах металлын АМНАТ-ийн асуудлыг шийдвэрлэх арга замын талаар Засгийн Газрын түвшинд нэгдсэн саналд хүрсний дараа энд санал болгож буй өөрчлөлтийг уул уурхайн салбарыхан нааштай хүлээж авахын хэрээр дагалдах металлын АМНАТ-ийн зохицуулалтад оруулах боломжит өөрчлөлтүүдийг боловсруулах ажилд тэднийг татан оролцуулж, санал, зөвлөмжийг нь авч ажиллах нь илүү үр дүнтэй байх юм. Салбарыхантай ийнхүү хамтран ажиллах нь АМНАТ-ийн тогтолцоонд өөрчлөлт оруулснаар Засгийн Газрын татварын орлогод үзүүлэх сөрөг нөлөөллийг зөөллөх арга замыг хамтран судлах боломжийг нээж болох юм.

## 6. ДҮГНЭЛТ

Энэхүү судалгааны ажлын үр дүнд дараах дүгнэлтэд хүрч байна:

1. Монгол Улсад одоо үйлчилж байгаа ашигт малтмалын борлуулалтын үнэлгээн дээр үндэслэн АМНАТ ногдуулах зохицуулалт нь Засгийн Газрын зүгээс харахад олон давуу талтай бөгөөд хүдэр, баяжмал зэрэг ашигт малтмалын бүтээгдэхүүнд агуулагдах дагалдах металлуудад АМНАТ ногдуулахтай холбоотой үүсээд буй захиргааны болон тэгш шударга байх тухай асуудлыг шийдвэрлэхээс бусдаар дорвитой нэмэлт өөрчлөлт оруулах шаардлагагүй юм. Дагалдах металлд АМНАТ ногдуулахтай холбоотой захиргаа удирдлагын асуудал нь Ашигт малтмалын тухай хуулийн 47 дугаар зүйл, холбогдох журамд тусгасан “борлуулалтын үнэлгээ” гэсэн нэр томъёоны үг үсгийг дагалдах металлуудтай холбон хэтэрхий шууд утгаар нь тайлбарласнаас үүдэлтэй гэж үзэж болохоор байна.
2. Монгол Улсад одоо мөрдөгдөж байгаа аргачлал нь хүдэр болон баяжмалд агуулагдах үндсэн металлын борлуулалтын үнээс гадна олборлогчийн бага хэмжээний "урамшуулал" буюу нэмэлт төлбөр авдаг дагалдах металл/элементэд АМНАТ ногдуулдаг олон улсын нийтлэг туршлагад нийцээгүй, давсан практик бөгөөд дараах төрлийн дагалдах металл/элементүүдэд АМНАТ ногдуулж байна:
  - а) худалдан авагч тал хайлуулах, цэвэршүүлэх процесст хортой нөлөө үзүүлдэг гэсэн шалтгаанаар олборлогч талд төлөх ашигт малтмалын бүтээгдэхүүнд агуулагдах үндсэн металлын борлуулалтын үнэлгээг "торгууль" ногдуулах хэлбэрээр бууруулдаг дагалдах металл/элементүүд;
  - б) олборлогч үндсэн металлын борлуулалтын үнээс гадна "урамшуулал" буюу нэмэлт төлбөр авдаггүй, хүдэр, баяжмалд маш бага хэмжээгээр агуулагддаг учраас одоо байгаа болон ойрын ирээдүйн металлургийн технологиор ялган авах боломжгүй дагалдах металл/элементүүд.
3. Дэлхийн олон улс орнуудын АМНАТ-ийн зохицуулалтыг судалж үзэхэд худалдан авагчаас нэмэлт төлбөр авдаггүй дагалдах металл АМНАТ ногдуулдаг нэг ч улс орон байхгүй байгаа нь Монголын өнөөгийн практик өвөрмөц болохыг илтгэж байна.
4. Монголын зэс, цайр, төмрийн хүдрийн баяжмалд АМНАТ ногдуулсан суурь үнэлгээ болон төлбөрийн хэмжээг хайлуулах үйлдвэрийн цэвэр үнэлгээ (NSV) болон Баруун Австрали ба Куинсланд зэрэг Австралийн уул уурхайгаар тэргүүлэх мужуудад тэдгээрийг олборлосон тохиолдолд ногдуулах байсан АМНАТ-тэй харьцуулж нарийвчилсан тоон үнэлгээ хийсэн болно. Энэхүү үнэлгээ дараах зүйлийг харуулж байна:
  - а) Монгол Улсын татварын тогтолцооны дагуу ногдуулж хураасан АМНАТ-ийн хэмжээ нь Австралийн болон бусад олон улс орнуудын ногдуулдаг хэмжээнээс эрс өндөр байв. "Дагалдах металл" -д хамаарах АМНАТ-ийг хассаны дараа ч гэсэн үр дүн нь ижил байна;
  - б) Монгол Улсын “дагалдах металл/элемент”-д ногдуулж хураасан АМНАТ-ийн нийт АМНАТ-д эзлэх хувь нь зэсийн баяжмалын хувьд 1.5%, цайрын баяжмалын хувьд 25.6% байна. 2020 онд ногдуулж хураасан нийт АМНАТ-ийн 4,7% нь дагалдах металл/элементэд ноогдож байгаа бөгөөд үүний 22,0%-ийг нь олборлогч ямар нэгэн нэмэлт төлбөр урамшуулал аваагүй дагалдах металл/элементэд ногдуулан хураасан байна;
  - в) Зэс, цайр олборлогчид хайлуулах үйлдвэрээс "урамшуулал" авч байсан ганц "дагалдах металл" нь мөнгө байсан бол харин хайлуулах процесст хортой, сөрөг нөлөөтэй гэдэг үндэслэлээр “торгууль” ногдуулж, үнэлгээг бууруулах хэд хэдэн төрлийн дагалдах металлд Монгол Улсын Засгийн Газар АМНАТ ногдуулж байна. Энэ нь логикийн хувьд ч, шударга ёсны хувьд ч учир дутагдалтай юм. Жишээ нь, төмрийн хүдрийн баяжмал дахь хөнгөн цагааныг ган үйлдвэрлэх

явцад ялгаж авах боломжгүйгээр үл барам хөнгөн цагаан нь домен зууханд шаарга үүсгэж үйлдвэрлэлийн зардлыг нэмэгдүүлдэг хорт хольц юм.

5. Ихэнх улс орнуудад энэхүү "дагалдах металл"-ын асуудлыг зөвшөөрөл олгох үйл явцын эхний шатанд, тухайлбал, Компанийн зүгээс Засгийн Газарт ашигт малтмалын ордыг ашиглах Хүсэлт (NoI) -ийг өгөх үед авч үзэж, шийдвэрлэдэг. Энэ нь ТЭЗҮ-д тусгасан бүтээн байгуулалт нь Засгийн Газрын хувьд хэр оновчтой байх вэ гэдгийг нягталж, асууж тодруулах хамгийн боломжтой үе шат юм. Ялангуяа харьцангуй өндөр агууламжтай зарим "дагалдах металл"-д нэмэлт төлбөр "урамшуулал" авахгүйгээр эдийн засгийн тооцоололд тусгасан шалтгааныг асууж лавлах шаардлагатай. Үүний дагуу тухайн ордын ашиглалтын төлөвлөгөөг дахин авч үзэх, эсвэл ашиглалтын эцсийн төлөвлөгөөнд ирээдүйд тухайн дагалдах металлын үнэ өөрчлөгдсөн, эсвэл холбогдох металлургийн технологид ахиц дэвшил гарсан нөхцөлд тухайн дагалдах металлын арилжааны үндэслэлийг дахин авч үзэх үүргийг олборлогч уул уурхайн компанид хүлээлгэж болох юм.
6. Өөр нэг чухал асуудал бол, "дагалдах металл"-ын агуулга нь ямар түвшингээс доош байхад ялган авах боломжгүй, эдийн засгийн хувьд ашиггүй гэж үзээд АМНАТ-аас чөлөөлөх вэ гэдэг асуудал юм. Энэ талаарх сонирхолтой хандлагыг Баруун Австралийн АМНАТ-ийн зохицуулалтаас харж болно. Энэхүү зохицуулалтаар төмрийн хүдэр(магнетит)-ийн баяжмал дахь ванадийд АМНАТ ногдуулах хамгийн доод агууламжийг тогтоосон байдаг бөгөөд энэхүү доод хэмжээнээс давсан агуулга бүхий ванадийд цаашдын боловсруулалтын явцад ялган авах эсэхээс нь үл хамааран АМНАТ ногдуулдаг. Төмрийн хүдрийн үнэ хурдацтай өссөн үед ихээхэн хэмжээний ванадий бүхий магнетитийн нөөцийг зохистой бус түвшинд, хурдацтай ашиглах эрсдэлтэй байсан тул энэхүү арга хэмжээг хэргэжүүлэх шаардлагатай гэж үзсэн байдаг.
7. Хэдийгээр 'дагалдах металл'-д АМНАТ ногдуулах асуудал нь Монгол Улсад хэрэгжиж буй уул уурхайн удирдлагын өргөн хүрээний зохицуулалтын харьцангуй жижиг хэсэг боловч энэ нь олон улсын түвшинд Монгол Улсын уул уурхайн салбарын зохицуулалтын талаарх ерөнхий төсөөлөлд сөргөөр нөлөөлж, улмаар ашигт малтмалын хайгуул, ашиглалтын чиглэлээр ГШХО-ыг татахад саад учруулж байна. Эрдэс баялгийн ихээхэн нөөцтэй нь хүлээн зөвшөөрөгдсөн Монгол Улсын хувьд энэ нь харамсалтай хэрэг юм.
8. "Дагалдах металл"-тай холбоотой зохицуулалтын гажуудлыг арилгахын шууд ба шууд бус үр ашиг нь шаардлагатай зохицуулалтын шинэчлэл хийснээр алдагдах боломжоос урт хугацаандаа хамаагүй давж гарна гэж үзэж болохоор байна. Бүх төрлийн үнэт бус дагалдах металлуудыг АМНАТ-өөс чөлөөлсөн тохиолдолд 2020 онд алдах байсан АМНАТ-ийн орлого 6.51 тэрбум төгрөг буюу 2.61 сая доллар болох байсан бол олборлогч нэмэлт төлбөр "урамшуулал" авдаггүй дагалдах үнэт металлыг АМНАТ-өөс чөлөөлсөн тохиолдолд алдах байсан орлого 9.715 тэрбум төгрөг буюу 3.89 сая доллар болох байв.
9. Бүх төрлийн үнэт бус дагалдах металлуудыг АМНАТ-өөс чөлөөлснөөр захиргааны үйл ажиллагааг үлэмж хялбаршуулж, шаардлагыг хэргэжүүлэх, лабораторийн химийн шинжилгээний зэрэг зардлыг хэмнэх боломж бүрдэх юм. Харин олборлогч "урамшуулал" авдаггүй дагалдах үнэт металлыг АМНАТ-өөс чөлөөлөх нь захиргааны үйл ажиллагааг илүү төвөгтэй болгож, зардлыг нэмэгдүүлнэ.

## 7. ЗӨВЛӨМЖ

Дээрх дүгнэлтийг үндэслэн Монгол Улсын Засгийн Газарт дараах зөвлөмжийг өгч байна. Үүнд:

1. Ашигт малтмалын бүтээгдэхүүнд агуулагдаж буй дагалдах металл/элемент нь ялган авахад эдийн засгийн болон технологийн хувьд ашигтай бөгөөд боломжтой бол ашигт малтмалын бүтээгдэхүүний цаашдын боловсруулалтын явцад ялган авах эсэхээс нь үл хамааран тухайн дагалдах металл/элементэд АМНАТ ногдуулах.
2. Ашигт малтмалын бүтээгдэхүүн дэх АМНАТ ногдуулах дагалдах металл/элементүүдийн жагсаалт(Хавсралт-1-д санал болгосон)-ыг олон улсын худалдаанд хүлээн зөвшөөрөгдсөн зарчим, тухайн дагалдах металл/элементийг ялган авах металлургийн технологийн практикт үндэслэн гаргаж зарлах.
3. Дагалдах металл/элементэд АМНАТ ногдуулах борлуулалтын үнэлгээг Засгийн Газраас тогтмол зарладаг жишиг үнэ болон Монгол Улсын итгэмжлэгдсэн лабораторийн шинжилгээний дүгнэлтээр тодорхойлсон агуулгын цэвэр хувь, хэмжээнд үндэслэн, дагалдах металл/элементийн агуулгын босго, хязгаарыг харгалзахгүйгээр тодорхойлох бөгөөд энэхүү борлуулалтын үнэлгээнээс тухайн дагалдах металл/элементийг ялган авах, хайлуулах, цэвэршүүлэхтэй холбогдон гарах зардлыг хасахгүй.
4. Ашигт малтмалын бүтээгдэхүүнийг боловсруулах технологийн дэвшил, дагалдах металл/элементийн зах зээлийн үнэтэй уялдуулан АМНАТ ногдуулах дагалдах металл/элементийн жагсаалтыг үе үе хянаж, шаардлагатай тохиолдолд шинэчилж байх.
5. Хавсралт-1-д тусгагдсан ашигт малтмалын бүтээгдэхүүнд агуулагдаж буй дагалдах металл/элементүүдийг АМНАТ-аас чөлөөлөх, үүнд дараах металл/элементүүдийг хамруулах:
  - с. ашигт малтмалын бүтээгдэхүүний боловсруулалтын технологийн процесст хортой, сөрөг нөлөө үзүүлдэг учраас олон улсын худалдааны практикт “торгууль” ногдуулдаг металл/элементүүд;
  - д. ашигт малтмалын бүтээгдэхүүнийг боловсруулах техник, технологийн болон үнийн орчин үеийн түвшинд ялган авах боломжгүй, эдийн засгийн хувьд ашиггүй дагалдах металл/элементүүд.
6. Дагалдах металл/элементийг эдийн засгийн хувьд ашигтайгаар ялган авах боломжийг олгохуйц технологийн дэвшил, зах зээлийн үнэтэй уялдуулан дээр дурдсан дагалдах металл/элементийн жагсаалтыг Засгийн Газар тодорхойлж, шаардлагатай тохиолдолд үе үе хянаж байх.
7. Ашигт малтмалын ордыг ашиглах хүсэлтийн мэдэгдэлийн үндэслэл болгож компаниас ирүүлсэн ТЭЗҮ-д харьцангуй өндөр агууламжтай "дагалдах металл" -ыг ялган авч эдийн засгийн эргэлтэд оруулах боломжийг хэрхэн авч үзсэнийг нягтлан шалгах, бага агуулгатай дагалдах металлыг ялган авах боломжгүй гэж үзсэн бол ямар шалгуураар ийм шийдвэр гаргасныг хянан үзэх ажлыг уул уурхайн зөвшөөрөл олгохын өмнө хийж гүйцэтгэх.
8. Ашигт малтмалын тухай хууль болон холбогдох журмуудад нэмэлт, өөрчлөлт оруулж, дагалдах металлыг цаашдын боловсруулалтын явцад ялган авах эсэхээс үл хамааран АМНАТ ногдуулах агуулгын дээд хязгаарыг тогтоож, шаардлагатай бол үе үе хянаж шинэчилж байх бүрэн эрхийг Засгийн Газарт олгох, Засгийн Газар уг хязгаарыг тогтоохдоо уул уурхайн салбарын олон улсын практикийг үндэслэх бөгөөд металлургийн үйлдвэрлэлийн технологи болон маркетингийн нөхцөл байдалтай уялдуулан шаардлагатай үед шинэчилж байх.
9. Дагалдах металлын АМНАТ-ийн асуудлыг шийдвэрлэх арга замын талаар Засгийн Газрын түвшинд нэгдсэн саналд хүрсний дараа энд санал болгож буй өөрчлөлтийг уул уурхайн салбарыхан нааштай хүлээж авахын хэрээр дагалдах металлын АМНАТ-ийн зохицуулалтад

оруулах боломжит өөрчлөлтүүдийг боловсруулах ажилд тэднийг татан оролцуулж, санал, зөвлөмжийг нь авч ажиллах.

## НОМ ЗҮЙ

- Australasian Institute of Mining and Metallurgy (AusIMM) (2012) Cost Estimation Handbook. AusIMM Monograph N. 27
- Bivens, J. (2019) [Updated employment multipliers for the U.S. economy | Economic Policy Institute \(epi.org\)](#)
- Extractive Industry Transparency Initiative (EITI) (2020) [Mongolia 2019 EITI Report | Extractive Industries Transparency Initiative](#)
- Fountain, C. (2013). The Whys and Wherefores of Торгууль Elements in Зэсийн баяжмал. Metallurgical Plant Design and Operating Strategies (MetPlant 2013) 15 - 17 July 2013, Perth WA
- Frazer Institute (2020) Annual Surveys of Mining Companies, 2020. <https://www.fraserinstitute.org/categories/mining>
- Guj P., Bocoum B., Limerick J., Meaton M. and Maybee B. (2013) – “*How to Improve Mining Tax Administration and Collection Frameworks: A Source Book*” – Published jointly by the World Bank and the centre for Exploration Targeting (UWA)
- Lilford, E. and Guj, P. (2020) *Mineral Taxation: Reconciling the interests of government and industry*. Springer
- Salomon-de-Friedberg, H. and Robinson, T. (2014) Tackling impurities in Зэсийн баяжмал. Teck Resources Limited, 12380 Horseshoe Way Richmond, BC Canada V7A 4Z1



## ХАВСРАЛТУУД

**Хавсралт 1 – Сонгон авсан ашигт малтмалын бүтээгдэхүүн дэх АМНАТ ногдуулах болон АМНАТ-аас чөлөөлөгдөх дагалдах металл/элементийн жагсаалт**

Ашигт малтмалын бүтээгдэхүүн	АМНАТ ногдуулах дагалдах металл/элемент	АМНАТ-аас чөлөөлөгдөх дагалдах металл/элемент
Зэсийн баяжмал	Алт	ТөмөрIron
	Мөнгө	Цайр
	Селен	Хар тугалга
	Теллур	Цагаан тугалга
	Цагаан алт	Никель
		Кобальт
		Хөнгөн цагаан
		Магний
		Молибден
		Мөнгөн ус
		Висьмут
		Сурьма
		Хүнцэл
		Кадмий
Цайрын баяжмал	Алт	Төмөр
	Мөнгө	Зэс
	Кадмий	Кобальт
		Хар тугалга
		Цагаан тугалга
		Никель
		Молибден
		Гянтболд
		Сурьма
		Хүнцэл
		Магний
		Мангани
		Мөнгөн ус
		Цахиурын исэл
Төмрийн хүдэр, баяжмал		Хүнцэл
		Хөнгөн цагаан
		Зэс
		Цайр
		Хар тугалга
		Мөнгө
		Титан
		Цахиур
		Фтор
		Хлор
	Фосфор	

**Хавсралт 2 – Зарим Уул Уурхайн татварын тогтолцооны харьцуулалт**

АНХААРАХ НЬ – АМНАТ-ийг өөрөөр заагаагүй бол үнэлгээний хувь хэмжээгээр тогтоодог. Хувь хэмжээгээр тооцох тогтолцоотой зэрэг оршиж болох бүтээгдэхүүний жин дээр суурилсан АМНАТ-ийг жагсаалтанд оруулаагүй болно.						
Улс	ААНОАТ-ын хувь хэмжээ	АМНАТ-ийн зааг	НӨАТ/ GST	Импорт/ Экспортын татвар	Суутган татвар	ЗГ/Орон нутаг/Нийгмийн оролцоо
Аргентин	35.0%	Уурхай дээрх бодит үнийн 3%	х/г	5 – 10%	0%	Ү
Афганистан		Бүтээгдэхүүн: Нийт орлого буюу зах зээлийн үнэлгээний Анхдагч 7.5%; Хоёрдогч 5%; Гуравдагч 2.5%				
Австрали	30.0%-аас 26% хүртэл буурах	Бүх мужууд 1.6 – 15.0%	х/г	х/г	30%	N (Уугуул иргэдийн эрх)
a – Бариуун Австрали		Металл, баяжмал, хүдрийн бодит FOB үнийн 2.5 – 5 - 7.5%				
b – Куинсланд		Үнийн 1.5 – 15.0% өсөн нэмэгдэх				
c – Нью Сауф Вэйлс		Нүүрс 6.2 – 8.2% Гүний болон ил Нүүрснээс бусад: уурхайн ам дээрх үнийн 4.0%				
d – Викториа		Цэвэр зах зээлийн үнийн 2.75%				
e – Хойд Муж		Ашгийн 22.5%				
f – Тасман		Холимог, NSR + ашгийн 1.9%. Дээд түвшин 5.35% NSR				
Боцвана	22.0%	Үнэт чулуу:10% Үнэт метал: 5% Бусад эрдэс-Уурхайн ам дээр нийт зах зээлийн үнийн 3%	12%	хувьсагч	7.5%	N
Буркина Фасо	28%	5%	18%	30%	12.5%	Ү
Бразил	34.0%	Чулуу, элс гэх мэт.: 1% Алт: 1.5% Очир: 2% Боксит, Mn, Nb, давс: 3% Төмрийн хүдэр: 3.5%	3.65 – 9.25%	0%	0%	N

Камбуж	20%	3 - 5%	10%	хувьсагч	0%	Y
Канад улс (Мужууд ороогүй)	15.0% (Fed. only)	Орлого/ашгийн 1 – 20%	х/г	х/г	25%	Y
a – Онтарио	10%	Ашгийн 10% (алслагдсан бүст 5% )				
b- Сакатчеван	10%	Уурхайг эхэлснээс хойшх 1Moz үнэт буюу 1Mt суурь металлын хуримтлагдсан үйлдвэрлэлийн цэвэр ашгийн 5%, үүнээс дээш 10%				
c – Бритиш Колумб	12%	Ашгийн 2%, орлогын 13%				
d – Кубек	11.6%	Ашгийн 16%				
e – Ньюфаундланд	15%	Ашгийн 20%				
f – Алберта	11.5%	Уурхайн ам дээрх орлогын 1% дээр нэмэх нь ашгийн 12%				
Чиле	18.5%	Ашгийн 0 – 14%	х/г	х/г	35%	N
БНХАУ	Nat. 25.0% Prov. 3%	0.5 – 4%	13%	хувьсагч	10%	Y
Конго БНУ	30.0% and 50% on super- profit	0.5 – 10%	16%	х/г	10%	Y
РОКонго	30.0%	3 – 5%	0.2 – 1%	х/г	20%	Y
Герман	30.0%	х/г	х/г	х/г	26.375%	N
Гана	35.0%	Нийт орлогын 5%	15%	х/г	8%	Y
Энэтхэг	25.0%	2 – 10%	1 - 5%	10 – 40%	0%	Y
Индонез	25.0%	Нүүрсний хувьд (үйлдвэрлэлийн тонноос хамаарч хувь хэмжээ хэлбэлзэнэ)3 – 7% 13.5%	х/г	х/г	20%	Y
Япон	41%	0.7 – 1%	10%	х/г	20%	N
Казахстан	20.0%	0 – 5.7%	хувьсаг ч %	Нүүрс 2%	15%	Y
Кени	37.5%	5 – 12%	16%	Эрдсийн 0 – 5%	10%	Y
Солонгос	20%	х/г	10%	х/г	27.9%	N
Лаос	20%	Үнэт чулуу: борлуулалтын үнэлгээний 10% Хагас үнэт чулуу, үнэт болон ердийн бус метал: 7%	10%	хувьсагч	5 – 20%	N

		Хар ба үндсэн металл: 6% бусад: 2-4%				
Либер	30%	3% дээр нэмэх 2% урьдчилж тооцоолсон АМНАТ	10%	2.5 – 20%	5%	Y
Малайз	25%	5%	10%	0 – 10%	15%	N
Мали	30%	6%	18%	Хувьсагч	10%	Y
Мянмар	25%	3 – 8%	10%	х/г	0%	Y
Мексик	30.0%	х/г	16%	х/г	10%	Y
Монгол	Татвар төлөх орлого 3 тэрбум төгрөгөөс бага бол 10%. Дээш бол MNT 300 мян.төг + 3 тэрбум төгрөгөөс дээш орлогын 25%	Дотоод: Нүүрс ба бусад нийтлэг эрдэс: 2.5% Алт: 5% Экспорт: Үндсэн 5% + Нэмэлт татвар (бүтээгдэхүүний үнэ /төрөлтэй холбоотой): Зэс 0 -30% Бусад, Аи: 0 - 5%-г ороогүй	10%	0 - 40% ихэвчлэн 5%	10 -20%	N
Мозамбик	32%	1.5 – 8%	17%	х/г	20%	Y
Намиб	37.5% (55% очир)	Очир, үнэт чулуу: Зах зээлийн үнэлгээний 10% Талсттай чулуу: 5% Ац, суурь металл, U: 3% Үйлдвэрлэлийн болон хагас үнэт: 2%	15%	Хувьсагч	10%	Y
Нигери	30%	3 – 5%	5%	Хувьсагч	10%	Not specified
Папуа Нью Гвиней	30% (ОСБ. 40%)	2%	10%	Хувьсагч	Int. 15% Div. 10%	N
Перу	29.5%	ЗГ-ын 3 түвшинд ашигт суурилсан: АМНАТ 1 - 12%, Онцгой нөөцийн татвар 2 - 8.4%, Нөөцийн төлбөр 3.4 - 13.2%	х/г	х/г	5%	Y
Филиппин	30%	2 – 8%	0 – 12%	х/г	12%	Y
Орос	35.5%	4.8 – 8%	х/г	Зарим бүтээгдэхүүн	15%	Y
Өмнөд Африк	28.0%	ЕВИТ-ийн функцээр тодорхойлсон хувь хэмжээ	15%	х/г	10%	Y

		бүхий "нийт борлуулалт" -ын 0.5-7% 'Цэвэршүүлээгүй' нөөцөд нийт борлуулалтын орлогын 5%, 'цэвэршүүлсэн' нөөцөд 7%				
Танзани	Ерөнхий. 30.0% Эрдэс. 35%	Нийт үнийн дүнгийн 6% дээр нэмэх 1% Гаалийн шалгалтын төлбөр	18%	х/г	10%	Y
Тайланд	20%	2 – 10%	7%	хувьсагч	15%	Not specified
Украйн	18.0%	хувьсагч/t	20%	зарим бүтээгдэхүүн	15%	Y
Их Британи	19.0%	х/г	хувьсагч/t	зарим бүтээгдэхүүн	0%	N
АНУ	48.0% - 21% хүртэл буурах	0 – 12.5%	4.4%	х/г	30%	N
a – Монтана		ЦБО-ын 5 - 8%				
b – Аляск		Орлогын 3 - 7%				
c – Аризон		Орлогын 2%				
d – Калифорни		Ашгийн 10% аас багагүй				
e – Айдахо		Орлогын 5%				
f – Шинэ Мексик		Нийт өгөөжийн 5% аас доошгүй				
g – Орегон		Орлогын 5%				
h – Юта		Ашгийн 4% (Металл бус) - 8% (Металл)				
Вьетнам	20% (32 - 50% үнэт метал)	1 to 5%	10%	0 – 45%	10%	N
Замби	30%	Си: үнээс хамаарч 5 - 10% Эрчим хүчний: 5% Үнэт чулуу: 6% ААНОАТ-аас хасагдахгүй	16%	0 – 25%	20%	Y
Зимбаве	25% (+3% AIDS levy)	1 – 15%	15%	хувьсагч	10 – 15%	Y

### Хавсралт 3. Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөртэй холбоотой

#### Монгол Улсын эрх зүйн тогтолцоо

Монгол Улсад олборлосон ашигт малтмалд ногдуулах ашигт малтмалын нөөц ашигласны төлбөртэй холбоотой дараахь хууль тогтоомжууд үйлчилж байна

1. Монгол улсын Үндсэн хууль
2. Газрын хэвлийн тухай хууль
3. Ашигт малтмалын тухай хууль болон АМНАТ ногдуулалтын журмууд
4. Татварын ерөнхий хууль
5. Нэмэгдсэн өртөгийн албан татварын тухай хууль
6. Хөрөнгө оруулалтын тухай хууль

#### **НЭГ МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛЬ**

Монгол улсын Үндсэн хуулийн 6-р зүйлд ашигт малтмалын баялгийн эзэмшлийн хууль эрх зүйн үндсийг зааж өгсөн. Энэ хуулийн 6-р зүйлд УИХ-аас 2019-11-14-нд өөрчлөлт орж, 2020-5-25-наас хүчин төгөлдөр үйлчилж эхэлсэнб Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам нь Ашигт малтмалын тухай хуулийг Үндсэн хуулийн уг өөрчлөлттэй уялдуулан өөрчлөхөөр ажиллаж байна. Одоогоор уг төслийг нийтийн хэлэлцүүлэгт зориулж ил тавиагүй байна.

6-р зүйлийн 1-р заалт

- 6.1. *Монгол Улсад газар, түүний хэвлий, ой, ус, амьтан, ургамал болон байгалийн бусад баялаг гагцхүү ард түмний мэдэлд, төрийн хамгаалалтад байна*
- 6.2. *Монгол Улсын иргэдэд өмчлүүлснээс бусад газар, түүнчлэн газрын хэвлий, түүний баялаг, ой, усны нөөц, ан амьтан төрийн нийтийн өмч мөн.*

*Байгалийн нөөцийг ашиглах талаар төрөөс баримтлах бодлогыг урт хугацааны хөгжлийн бодлогод үндэслэн боловсруулж, одоогийн болон ирээдүйн иргэн бүрийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг хангахад чиглүүлж, газрын хэвлийн баялгаас хүртэх үр өгөөжийг Үндэсний баялгийн санд хуримтлуулж, тэгш, шударгаар хуваарилна.*

*Эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийн хүрээнд иргэн газар доорхи баялгийг ашиглах аливаа үйл ажиллагааны байгаль орчинд үзүүлж буй нөлөөллийн талаар мэдэх эрхтэй.*

*Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын нөөц ашигласны үр ашгийн дийлэнх хувийг хуваарилах эрх зүйн үндэс нь байгалийн баялаг ард түмний мэдэлд байх ёстой гэсэн зарчмын дагуу хуулиар зохицуулагдана.”*

#### **ХОЁР ГАЗРЫН ХЭВЛИЙН ТУХАЙ ХУУЛЬ**

Энэхүү хууль одоогийн Монгол Улсын 1992 оны Үндсэн хуулиас өмнө 1989 онд батлагдсан бөгөөд геологийн судалгаа, хайгуул, ашиглалтын нарийвчилсан горимууд нь Ашигт малтмалын тухай хууль, Газрын тосны тухай хууль, Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хууль, Цөмийн энергийн тухай хууль гэх мэт тусдаа хуулиудаар тогтоогддог тул түүний хэрэглээ тун хязгаарлагдмал болоод байна.

Гэсэн хэдий ч ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн тухайд (1) ашигт малтмалын нөөц ашигласны төлбөртэй байх, ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг хуулиар тодорхойлсон хуулийн ерөнхий үндэслэл болж, 2) иж бүрэн судалгаа хийх, хамгийн үр дүнтэй технологи ашиглах, эдийн засгийн ач холбогдол бүхий эрдэс баялгийн агуулгатай хаягдал/бохирдлыг бүртгэж байх шаардлагыг тавих замаар ашигт малтмалын үр шимийг аль болох хамгийн их байлгах Төрийн шаардлагуудыг тавьж өгсөн. Энэ чиглэлд хууль, журмын дараах зүйл, заалтууд хамаарч байна:

*" 3-р зүйл Монгол Улсын Үндсэн хуульд зааснаар газрын хэвлий нь төрийн өмч,*

өөрөөр хэлбэл Монголын бүх ард түмний хөрөнгө мөн. Газрын хэвлийг зөвхөн ашиглуулахаар олгоно. Газрын хэвлийг төр өмчлөх эрхийг аливаа хэлбэрээр зөрчихийг хориглоно

### **10-р зүйл Газрын хэвлийг ашиглах зориулалт:**

1. Газрын хэвлийг дор дурдсан зориулалтаар ашиглуулахаар олгоно:

- 1) геологийн судалгаа хийх;
- 2) ашигт малтмал олборлох;
- 3) ашигт малтмал олборлохоос өөр зориулалтаар газар доор барилга байгууламж, түүний дотор нефть, хий, бусад бодис, материал хадгалах, хорттой бодис, үйлдвэрлэлийн хаягдлыг хамгаалан булах, бохир ус зайлуулахад зориулан барилга байгууламж барих, ашиглах;
- 4) аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн бусад хэрэгцээг хангах

2. Газрын хэвлийд ашигт малтмалын хайгуул хийх, ашигт малтмал олборлохтой холбогдсон харилцааг Ашигт малтмалын тухай хуулиар зохицуулна

3. Газрын хэвлийг ашиглагчид нь газар эзэмшигч, ашиглагчдаас зохих журмын дагуу зөвшөөрөл авна.

### **11 дүгээр зүйл Газрын хэвлийг ашигласны төлбөр**

1. Газрын хэвлийг төлбөртэй ашиглана.
2. Газрын хэвлийг ашигласны төлбөрийн дээд, доод хэмжээг хуулиар тогтооно.

## **ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ ГАЗРЫН ХЭВЛИЙГ АШИГТ МАЛТМАЛ ОЛБОРЛОХ ЗОРИУЛАЛТААР АШИГЛАХ**

### **31 дүгээр зүйл Газрын хэвлийг ашигт малтмал олборлох зориулалтаар ашиглах журам**

1. Ашигт малтмал олборлох аж ахуйн нэгж, байгууллага батлагдсан зураг төсөл, уулын ажлын төлөвлөгөө, техник ашиглалтын журмын дагуу газрын хэвлийг ашиглана.
2. Ашигт малтмал олборлох аж ахуйн нэгж, байгууллагын техник ашиглалтын журмыг геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын зөвшөөрөлтэйгээр холбогдох төрийн захиргааны төв байгууллага батална.
3. Ашигт малтмал олборлох аж ахуйн нэгж, байгууллага нь байгаль орчныг бохирдуулсан, түүний баялгийг зүй бусаар ашигласан, гэмтээж сүйтгэсэн зэргээс учирсан хохирлыг арилгах үүрэгтэй

### **32 дүгээр зүйл Газрын хэвлийг ашигт малтмал олборлох зориулалтаар ашиглахад тавих үндсэн шаардлага**

Газрын хэвлийг ашигт малтмал олборлох зориулалтаар ашиглахдаа дараахь үндсэн шаардлагыг хангасан байвал зохино:

- 1/үндсэн болон түүнтэй хамт орших ашигт малтмал, түүний үйлдвэрлэлийн ач холбогдол бүхий бүрэлдэхүүн хэсгийг үр ашигтай иж бүрэн, бүрэн гүйцэд олборлох аргыг хэрэглэх;
- 2/ашигт малтмалын хаягдал, бохирдлыг тогтоосон хэмжээнээс хэтрүүлэхгүй байх, ордын зөвхөн баялаг хэсгийг нь сорчлон олборлохгүй байх;
- 3/ашигт малтмалын ордод хийвэл зохих гүйцээх болон ашиглалтын хайгуул, геологийн бусад ажил, түүнчлэн ашиглалтын геологи, маркшейдерийн ажлыг бүрэн гүйцэтгэж, техникийн зохих баримт бичгийг гүйцэд хөтлөх;
- 4/ашигт малтмалын нөөцийн байдал, хөдөлгөөн, хаягдал, бохирдлыг тооцож байх;
- 5/уулын ажлын явцад ашиглаж байгаа болон түүнтэй зэрэгцэн оршиж байгаа ордыг гэмтээхгүй байх, нөөцөд үлдээсэн ашигт малтмалыг хадгалж хамгаалах;
- 6/үйлдвэрлэлийн явцад дайвраар олборлосон бөгөөд эдийн засгийн хувьд ач холбогдолтой бүрэлдэхүүн хэсгийг агуулсан ашиглагдаагүй үйлдвэрлэлийн хаягдлыг бүртгэх, хадгалах;
- 7/уулын малталтын чулуулаг, үржил шимтэй хөрс, үйлдвэрлэлийн хаягдлыг зөв зохистой ашиглах байршуулах;



8/ажиллагсад болон хүн амын аюулгүй байдлыг хангах, газрын хэвлий, байгаль орчны бусад объект, барилга байгууламжийг хамгаалах, аюул ослоос урьдчилан сэргийлэх, аюул ослын үр дагаврыг арилгах төлөвлөгөөг батлан хэрэгжүүлэх, ордыг ашиглаж дууссаны дараа тогтоосон журмын дагуу дарах буюу улс ардын аж ахуйн хэрэгцээнд цаашид ашиглаж болохуйцаар засаж тохижуулах

### **33 дугаар зүйл Эрдэс түүхий эдийг боловсруулахад тавих үндсэн шаардлагууд**

Эрдэс түүхий эдийг боловсруулахдаа дор дурдсан үндсэн шаардлагыг хангасан байвал зохино:

1/эрдэс түүхий эдэд байгаа ашигтай бүрэлдэхүүн хэсгийг иж бүрэн, бүрэн гүйцэд ялган авах технологи хэрэглэх;

2 олборлосон /эрдэс түүхий эдийн ялгарцын түвшин, хэмжээг боловсруулалтын шат бүрт бүртгэж, хяналт тавьж байх;

3/эрдэс түүхий эдийн найрлага, технологийн шинж чанарыг цаашид судлан, боловсруулалтын технологийг боловсронгуй болгох;

4/эрдэс түүхий эдийг боловсруулахад гарсан хаягдлыг ашиглах;

5/ашигтай бүрэлдэхүүн хэсгийг агуулсан бөгөөд ашиглаагүй байгаа үйлдвэрлэлийн хаягдлыг бүртгэн тооцож хамгаалж байх.

## **НАЙМДУГААР БҮЛЭГ**

### **АШИГТ МАЛТМАЛЫН НӨӨЦ, ОРДЫН БОЛОН ГАЗРЫН ХЭВЛИЙН УЛСЫН ТОО БҮРТГЭЛ**

#### **45 дугаар зүйл Ашигт малтмалын нөөц, ордын улсын тоо бүртгэл**

1. Ашигт малтмалын нөөц, орд, илрэлийг улсын нэгдсэн тоо бүртгэлд заавал бүртгэнэ.

2. Газрын хэвлийн геологийн судалгааг төлөвлөх, ашигт малтмал олборлох үйлдвэрийг байршуулах, ашигт малтмалын ордыг иж бүрэн, оновчтой ашиглах, түүнчлэн эдийн засгийн бусад зорилтыг шийдвэрлэх зорилгоор ашигт малтмалын ордын улсын данс хөтөлж, ашигт малтмалын нөөцийн улсын баланс зохионо.

3. Ашигт малтмалын нөөц, ордын болон газрын хэвлийн улсын тоо бүртгэл, ашигт малтмалын ордын данс, нөөцийн балансыг Улсын геологийн сан эрхлэн хөтөлнө.

#### **46 дугаар зүйл Ашигт малтмалын ордын улсын данс**

Ашигт малтмалын ордын улсын данс нь үндсэн болон түүнтэй хамт орших ашигт малтмал, тэдгээрт байгаа бүрэлдэхүүн хэсгийн нөөцийн хэмжээ, чанар, ордыг ашиглах уул-техник, гидрогеологийн болон бусад нөхцөл, түүний геологи-эдийн засгийн үнэлгээг орд тус бүрээр, ашигт малтмалыг илрэл бүрээр нь тусган харуулсан байвал зохино

#### **47 дугаар зүйл Ашигт малтмалын нөөцийн улсын баланс**

Ашигт малтмалын нөөцийн улсын балансад үйлдвэрийн ач холбогдол бүхий орд тус бүрийн байриил, ашигт малтмалын нөөцийн хэмжээ, чанар, судалсан байдал, үйлдвэрлэлийн ашиглалтын түвшин, олборлолт, хаягдлын тухай болон хайгуул хийсэн ашигт малтмалын нөөцөөр үйлдвэрийг хэрхэн хангасныг тусган харуулна

#### **48 дугаар зүйл Ашигт малтмалын нөөцийн үнэмшлийг тогтоох**

Газрын хэвлийн хайгуул хийсэн ордын ашигт малтмалын нөөцийг үнэн зөв байдал, тоо хэмжээ, чанар, орших нөхцөл, судалгааны түвшин, эдийн засгийн ач холбогдол, ордыг үйлдвэрлэлийн ашиглалтад бэлтгэсэн байдалд Улсын геологийн сан, мэдээллийн байгууллага магадлан шинжилгээ хийж үнэмшлийг тогтооно.

#### **49 дүгээр зүйл Ашигт малтмалын нөөцийг балансаас хасах**

Олборлосон ашигт малтмалыг, түүнчлэн үйлдвэрийн ач холбогдлоо алдсан, олборлолтын явцад хаягдсан, геологи, хайгуулын цаашидын ажлын буюу орд ашиглах явцад нотлогдоогүй ашигт малтмалын нөөцийг улсын балансаас хасах асуудлыг уг нөөцийг баталсан байгууллага шийдвэрлэнэ.

## **50 дугаар зүйл Ашигт малтмал олборлохоос өөр зориулалтаар ашиглах газрын хэвлийн улсын тоо бүртгэл**

Ашигт малтмал олборлохоос өөр зориулалтаар ашиглах газрын хэвлийн улсын тоо бүртгэлийг геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага эрхлэн хөтөлнө

## **ГУРАВ АШИГТ МАЛТМАЛЫН ТУХАЙ ХУУЛЬ болон БУСАД ЖУРАМ**

### **АШИГТ МАЛТМАЛЫН ТУХАЙН ХУУЛЬ**

Одоогийн Ашигт малтмалын тухай хууль УИХ-аар 2006 онд батлагдсан бөгөөд түүнээс хойш Ашигт малтмал ашигласны төлбөрийн тухай 47 дугаар зүйлд олон удаа өөрчлөлт орсон. Экспортолсон ашигт малтмалд 5%, дотооддоо борлуулсан буюу ашигласан ашигт малтмалд 2.5% байсан АМНАТ-ын үндсэн хувь хэмжээн дээр ашигт малтмалын зах зээлийн үнэ, боловсруулалтын түвшингээс хамаарсан АМНАТ-н нэмэлт хувь хэмжээг ногдуулсан дэлгэрэнгүй хүснэгтийг 2010 онд баталж гаргасан. АМНАТ төлөх хугацааг ‘дараагийн улиралд багтаах’ гэж байсныг ‘богиносгож дараа сарын 20-ны дотор’ болгосон.

АМНАТ ногдуулах дүнг Ашигт малтмалын тухай хуулийн 47 дугаар зүйлийн дагуу Засгийн газраас гаргасан 2016 оны 81-р тогтоолоор тодорхойлсон ‘борлуулалтын үнэлгээ’ -нд үндэслэн тодорхойлдог. Засгийн газрын 2013 оны 131 дүгээр тогтоолын дагуу АМНАТ ногдуулахад тооцох тухайн сарын борлуулалтын жишиг үнийг зарлаж байх үүрэгтэй ажлын хэсгийг Сангийн сайд (СЯ), Уул уурхайн сайд (хуучин нэр, одоо Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд (УУХҮЯ)) нар хамтран байгуулсан.

Энэ ажлын хэсэг нь СЯ, УУХҮЯ, Татварын ерөнхий газар, Гаалийн ерөнхий газар, Ашигт малтмал, газрын тосны газрын төлөөллөөс бүрддэг. “Тухайн сарын борлуулалтын жишиг үнэ” -ийг ямар аргаар тооцдог нь өнөөг хүртэл нийтэд мэдээлэгдээгүй бөгөөд янз бүрийн вэб сайтуудын мэдээллээс харахад олон улсын зах зээлийн үнийн олон эх сурвалжийн жигнэсэн дундаж үнийн тооцоон дээр үндэслэдэг болохыг тэмдэглэх нь зүйтэй.

Засгийн газрын 2016 оны 81-р тогтоолоор тодорхойлсон зах зээлийн үнийн эх сурвалжийн төрлийг дараахь байдлаар үзүүлэв.

<b>Борлуулалтын үнийн эх сурвалж</b>	<b>Ашигт малтмалын төрөл</b>
Лондонгийн металлийн бирж	Зэс, цайр, цагаан тугалга, хар тугалга, молибдени
Монгол банк (Монгол улсын төв банк) -ны зарласан үнэ	Алт, Мөнгө
Зах зээлийн үнэ зарладаг вэб эх сурвалжууд	Төмөр, нүүрс, хайлуур жонш, permonate аммиак, гянтболд, Манганы
Гэрээний худалдах үнэ	Төмөр, нүүрс  (Ашигт малтмал, газрын тосны газрын вэб хуудсанд мэдээлснээр хэрэв гэрээний худалдах үнэ хамтарсан ажлын хэсгийн зарласан "сар бүрийн жишиг үнэ" -ээс 30 хувиас хэтрэхгүй байвал)

Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр ногдуулахтай холбогдуулан “Бүх төрлийн ашигт малтмалд” гэсэн үг хэллэг Ашигт малтмалын тухай хуулийн 47.3.3, 47.10, 47.16 дугаар зүйлүүдэд тусгагдсан байгаа. Ашигт малтмалын тухай хуулинд зарим ашигт малтмал, ялангуяа дагалдах элементүүдтэй холбоотой ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрөөс чөлөөлөх, хөнгөлөх талаар огт дурдаагүй гэдгийг тэмдэглэх нь зүйтэй. Үүний уршгаар СЯ, татварын алба нь Ашигт малтмалын тухай хуулийг шууд үгчлэн ойлгож, бүх төрлийн ашигт малтмалд АМНАТ ногдуулахаар ажиллаж байна.

Үүнээс гадна Засгийн газрын 2019-12-25-ны өдрийн 465 дугаар тогтоолын 2.8-р зүйлд нүүрс, төмрийн хүдэр, төмрийн баяжмалаас бусад экспортын ашигт малтмалын бүтээгдэхүүний үндсэн болон дагалдах элемент/эрдэс бүтээгдэхүүнд Гаалийн лабораторийн шинжилгээнд үндэслэн АМНАТ ногдуулах шаардлагыг зааж өгсөн. Өмнө нь ч яг ижил шаардлагыг Татварын ерөнхий газрын даргын баталсан журмаар 2010-2019 онуудад мөн тавьдаг байсан.

Ашигт малтмалын тухай хуулийн 47-р зүйлийн АМНАТ-тай холбогдох заалтуудыг дор сийрүүлэв:

*47 дугаар зүйл Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр*

47.1. Доор дурдсан этгээд ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр төлөгч байна:

- 47.1.1. ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигч;
- 47.1.2. ашигт малтмал экспортолсон этгээд;
- 47.1.3. Монголбанк, түүнээс эрх олгосон арилжааны банканд алт тушаасан этгээд

*/Энэ хэсэгт 2019 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/  
/Энэ хэсэгт 2019 оны 11 дугаар сарын 22-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/*

47.2. Энэ хуулийн 47.16-д заасан борлуулалтын үнэлгээг дараахь журмаар тооцно

*/Энэ хэсэгт 2019 оны 11 дугаар сарын 22-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/*

- 47.2.1. Хэрэв экспортод бүтээгдэхүүн гаргасан бол олон улсын худалдаанд хүлээн зөвшөөрөгдсөн тухайн сарын дунжийг тогтоох зарчмыг үндэслэн тухайн бүтээгдэхүүний, эсхүл түүнтэй адил төстэй бүтээгдэхүүний олон улсын зах зээлийн үнийг баримтлана
- 47.2.2. Хэрэв дотоодод борлуулсан буюу ашигласан бол тухайн бүтээгдэхүүний, эсхүл түүнтэй адил төстэй бүтээгдэхүүний дотоодын зах зээлийн үнийг үндэслэнэ
- 47.2.3. Хэрэв дотоод, гадаадын зах зээлд борлуулсан бүтээгдэхүүний зах зээлийн жишиг үнийг тодорхойлох боломжгүй тохиолдолд тусгай зөвшөөрөл эзэмшигчийн мэдүүлсэн борлуулалтын орлогыг үндэслэнэ.

47.7. Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг дараах хэмжээгээр ногдуулна:

- 47.3.1. Олборлож өөрийн хэрэгцээнд ашигласан, дотоодод худалдсан, эсхүл худалдахаар ачуулсан нүүрсний нөөц ашигласны [суурь] төлбөр борлуулалтын үнэлгээний 2.5 хувь
- 47.3.2. Монголбанк, түүнээс эрх олгосон арилжааны банканд худалдсан алтанд ногдох нөөц ашигласны [суурь] төлбөр борлуулалтын үнэлгээний 5.0 хувь байх бөгөөд энэ хуулийн 47.5-д заасан хувиар нэмэгдүүлж тооцохгүй;
- 47.3.3. Энэ хуулийн 47.3.1, 47.3.2-г зааснаас бусад бүх төрлийн ашигт малтмалын нөөц ашигласны [суурь] төлбөр тухайн бүтээгдэхүүний борлуулалтын үнэлгээний 5.0 хувь.

*/Энэ хэсэгт 2019 оны 11 дугаар сарын 22-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/*

47.7. Энэ хуулийн 47.3.3-г заасан [суурь] хувь дээр тухайн бүтээгдэхүүний зах зээлийн үнийн өсөлт, боловсруулалтын түвшингээс хамаарч доор дурдсан хувийг нэмэгдүүлж тооцно:

*/Энэ хэсэгт 2019 оны 11 дугаар сарын 22-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/*

№	Бүтээгдэхүүний нэр, төрөл	Хэмжих нэгж	Жишиг үнэлэх бүтээгдэхүүн	Зах зээлийн үнийн түвшин /ам.доллараар /	Бүтээгдэхүүн боловсруулалтын түвшингээс хамаарч үндсэн хувь дээр нэмж ногдуулах хувь		
					Хүдэр	Баяжмал	Бүтээгдэхүүн
1	Зэс	тонн	Зэс /цэвэр металаар/	0-5000 хүртэл	0.00	0.00	0.00
				5000-6000 хүртэл	22.0	11.0	1.00
				6000-7000 хүртэл	24.0	12.0	2.00
				7000-8000 хүртэл	26.0	13.0	3.00

				8000-9000 хүртэл	28.0	14.0	4.00
				9000 ба түүнээс дээш	30.0	15.0	5.00
2	Алт	Унци	Алт /цэвэр/	0-900 хүртэл			0.00
				900-1000 хүртэл			1.00
				1000-1100 хүртэл	-	-	2.00
				1100-1200 хүртэл			3.00
				1200-1300 хүртэл			4.00
				1300 ба түүнээс дээш			5.00
				3	Цайр	тонн	Цайр /цэвэр металлаар/
1500-2000 хүртэл	1.00	0.80	0.40				
2000-2500 хүртэл	2.00	1.60	0.80				
2500-3000 хүртэл	3.00	2.40	1.20				
3000-3500 хүртэл	4.00	3.20	1.60				
3500 ба түүнээс дээш	5.00	4.00	2.00				
4	Молибдени	тонн	Молибдени				
				35000-40000 хүртэл	1.00	0.80	0.50
				40000-45000 хүртэл	2.00	1.60	1.00
				45000-50000 хүртэл	3.00	2.40	1.50
				50000-55000 хүртэл	4.00	3.20	2.00
				55000 ба түүнээс дээш	5.00	4.00	2.50
				5	Төмөр	тонн	Төмрийн хүдэр
60-70 хүртэл	1.00	0.70	0.40				
70-80 хүртэл	2.00	1.40	0.80				
80-90 хүртэл	3.00	2.10	1.20				
90-100 хүртэл	4.00	2.80	1.60				
100 ба түүнээс дээш	5.00	3.50	2.00				
6	Гянтболд	тонн	Гянтболдын баяжмал	0-25000 хүртэл	0.00	0.00	
				25000-30000 хүртэл	1.00	0.80	
				30000-35000 хүртэл	2.00	1.60	-
				35000-40000 хүртэл	3.00	2.40	
				40000-45000 хүртэл	4.00	3.20	

				45000 ба түүнээс дээш	5.00	4.00	
7	Хайлуур жонш	тонн	Хайлуур жоншны хүдэр, баяжмал	0-80 хүртэл	0.00	0.00	
				80-90 хүртэл	1.00	0.90	
				90-100 хүртэл	2.00	1.80	-
				100-110 хүртэл	3.00	2.70	
				110-120 хүртэл	4.00	3.60	
				120 ба түүнээс дээш	5.00	4.50	
8	Флотацийн баяжмал	тонн	Флотацийн баяжмал	0-200 хүртэл		0.00	
				200-230 хүртэл		0.70	
				230-260 хүртэл	-	1.40	-
				260-290 хүртэл		2.10	
				290-320 хүртэл		2.80	
				320 ба түүнээс дээш		3.50	
9	Цагаан тугалга	тонн	Цагаан тугалга /цэвэр металлаар/	0-17000 хүртэл	0.00	0.00	0.00
				17000-18000 хүртэл	1.00	0.80	0.50
				18000-19000 хүртэл	2.00	1.60	1.00
				19	3.00	2.40	1.50
				20000-21000 хүртэл	4.00	3.20	2.00
				21000 ба түүнээс дээш	5.00	4.00	2.50
10	Хар тугалга	тонн	Хар тугалга /цэвэр металлаар/	0-1500 хүртэл	0.00	0.00	0.00
				1500-1800 хүртэл	1.00	0.80	0.40
				1800-2100 хүртэл	2.00	1.60	0.80
				2100-2400 хүртэл	3.00	2.40	1.20
				2400-2700 хүртэл	4.00	3.20	1.60
				2700 ба түүнээс дээш	5.00	4.00	2.00
11	Мөнгө	Унци	Мөнгө /цэвэр металлаар/	0-25 хүртэл			0.00
				25-30 хүртэл			1.00
				30-35 хүртэл		-	2.00
				35-40 хүртэл			3.00
				40-45 хүртэл			4.00
				45 ба түүнээс дээш			5.00
12	Магнезит	тонн	Магнезитийн баяжмал	0-100 хүртэл	0.00	0.00	
				100-120 хүртэл	1.00	0.90	
				120-140 хүртэл	2.00	1.80	-
				140-160 хүртэл	3.00	2.70	
				160-180 хүртэл	4.00	3.60	

				180 ба түүнээс дээш 180 ба түүнээс дээш	5.00	4.50	
13	Хөнгөн цагаан	тонн	Хөнгөн цагаан /цэвэр металлаар/	0-2300 хүртэл	0.00	0.00	0.00
				2300-2600 хүртэл	1.00	0.90	0.50
				2600-2900 хүртэл	2.00	1.80	1.00
				2900-3200 хүртэл	3.00	2.70	1.50
				3200-3500 хүртэл	4.00	3.60	2.00
				3500 ба түүнээс дээш 3500 ба түүнээс дээш	5.00	4.50	2.50
14	Газрны ховор элемент	Кг	Газрын ховор элементийн баяжмал	0-10 хүртэл	0.00	0.00	
				10-20 хүртэл	1.00	0.90	
				20-30 хүртэл	2.00	1.80	-
				30-40 хүртэл	3.00	2.70	
				40-50 хүртэл	4.00	3.60	
				50 ба түүнээс дээш	5.00	4.50	
15	Фосфорит	тонн	Баяжмал	0-70 хүртэл	0.00	0.00	0.00
				70-90 хүртэл	1.00	0.90	0.50
				90-110 хүртэл	2.00	1.80	1.00
				110-130 хүртэл	3.00	2.70	1.50
				130-150 хүртэл	4.00	3.60	2.00
				150 ба түүнээс дээш	5.00	4.50	2.50
16	Цеолит	тонн	Цеолит	0-200 хүртэл	0.00	0.00	
				200-250 хүртэл	1.00	0.90	
				250-300 хүртэл	2.00	1.80	-
				300-350 хүртэл	3.00	2.70	
				350-400 хүртэл	4.00	3.60	
				400 ба түүнээс дээш	5.00	4.50	
17	Судлын кварц	тонн	Кварц	030 хүртэл	0.00	0.00	
				30-40 хүртэл	1.00	0.90	
				40-50 хүртэл	2.00	1.80	-
				50-60 хүртэл	3.00	2.70	
				60-70 хүртэл	4.00	3.60	
				70 ба түүнээс дээш	5.00	4.50	
18	Чулуун давс	Кг	Давс	0-40 хүртэл	0.00	0.00	
				40-50 хүртэл	1.00	0.90	
				50-60 хүртэл	2.00	1.80	-
				60-70 хүртэл	3.00	2.70	
				70-80 хүртэл	4.00	3.60	

				80 ба түүнээс дээш	5.00	4.50	
19	Мөсөн шүү	тонн	Мөсөн шүү	0-140 хүртэл	0.00	0.00	
				140-150 хүртэл	1.00	0.90	
				150-160 хүртэл	2.00	1.80	-
				160-170 хүртэл	3.00	2.70	
				170-180 хүртэл	4.00	3.60	
				180 ба түүнээс дээш	5.00	4.50	
20	Гөлтгөнө	тонн	Гөлтгөнө	0-9 хүртэл	0.00		
				9-11 хүртэл	1.00		
				11-13 хүртэл	2.00	-	-
				13-15 хүртэл	3.00		
				15-17 хүртэл	4.00		
				17 ба түүнээс дээш	5.00		

- 47.6. Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн хувийг тооцох, төлбөр ногдуулах, тайлагнах, төлөх журмыг Засгийн газар батална  
*/Энэ хэсэгт 2019 оны 11 дугаар сарын 22-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/*
- 47.7. Ашигт малтмалыг шууд, эсхүл ашигт агуулгыг нэмэгдүүлэн баяжмал, бүтээгдэхүүн үйлдвэрлэн экспортлоход төлбөрийг давхардуулан ногдуулахгүй бөгөөд тухайн ашигт малтмалд төлбөр ногдуулах үнэлгээ, хувь хэмжээнээс хамаарч энэ хуулийн 47.18-д заасан төлбөрийн баримт, 47.19-д заасны дагуу сууган ногдуулсан тайланг үндэслэн өмнө нь ногдуулсан төлбөрийг хасаж тооцно.  
*/Энэ хэсэгт 2019 оны 11 дугаар сарын 22-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/*
- 47.8. Энэ хуулийн 47.5, 47.17-д заасан хүдэр, баяжмал, бүтээгдэхүүний боловсруулалтын түвшинд тавигдах шаардлага, ангилал, тооцох үндсэн зарчим, аргачлалыг геологи, уул уурхайн болон санхүүгийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн Засгийн газар батална.  
*/Энэ хэсэгт 2019 оны 11 дугаар сарын 22-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/*
- 47.9. Хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь хайгуулын ажлын явцад туршилтын журмаар олборлосон ашигт малтмалын төрөл, тоо, хэмжээг мэргэжлийн хяналтын албанд бүртгүүлж зөвшөөрөл авсны үндсэн дээр худалдан борлуулж болох бөгөөд энэ тохиолдолд ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигчтэй нэгэн адил төлнө  
*/Энэ хэсгийн дугаар нь 2019 оны 11 дугаар сарын 25-ны өдрийн хуулиар өөрчлөгдсөн/*
- 47.10. Монголбанк, түүнээс эрх олгосон арилжааны банканд алт тушаасан этгээдээс бусад энэ хуулийн 47.1-д заасан ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр төлөгч нь худалдсан, худалдахаар ачуулсан болон ашигласан бүх төрлийн ашигт малтмалд ногдох тухайн сарын төлбөрийг дараагийн сарын 20-ны өдрийн дотор, жилийн эцсийн тайлангаар хийсэн эцсийн тооцоогоо дараа оны 02 дугаар сарын 10-ны өдрийн дотор төсөвт төлнө.  
*/Энэ хэсэгт 2019 оны 3 дугаар сарын 26-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/*
- 47.11. Монголбанк, түүнээс эрх олгосон арилжааны банканд алт тушаасан хувь хүнээс бусад энэ хуулийн 47.1-д заасан ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр төлөгч нь тухайн улиралд олборлож худалдсан, худалдахаар ачуулсан, ашигласан ашигт малтмалын тоо хэмжээ, борлуулалтын үнэлгээ, төлбөрийн нийт хэмжээг мэргэжлийн хяналтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас баталсан маягтын дагуу, ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн тайланг татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас баталсан маягтын дагуу улирал тутам өссөн дүнгээр гаргаж, улирлын тайланг дараагийн улирлын эхний сарын 20-ны өдрийн дотор ирүүлнэ Жилийн эцсийн тайланг дараа оны 02 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ



*/Энэ хэсэгт 2019 оны 11 дугаар сарын 22-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/*

47.12. Монголбанк, түүнээс эрх олгосон арилжааны банк нь энэ хуулийн 47.3.2-т заасан хувь хэмжээгээр ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг тушаасан алтны борлуулалтын үнэлгээнээс суутган авч, улсын төсөвт шилжүүлнэ

*/Энэ хэсэг 2019 оны 3 дугаар сарын 26-ны өдрийн хуулиар нэмэгдсэн/*

47.13. Монголбанк, түүнээс эрх олгосон арилжааны банк нь энэ хуулийн 47.12-д заасны дагуу төсөвт шилжүүлсэн ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн тайлан, мэдээг татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас баталсан маягтын дагуу дараа сарын 20-ны өдрийн дотор тус байгууллагад хүргүүлнэ

*/Энэ хэсэг 2019 оны 3 дугаар сарын 26-ны өдрийн хуулиар нэмэгдсэн/*

47.14. Экспортын бүтээгдэхүүний борлуулалтын үнэлгээний үндэслэл болгох олон улсын жишиг үнэ тогтоодог биржийн, зах зээлийн үнийн эх сурвалжийн нэрийг тухайн бүтээгдэхүүний нэр төрлийг харгалзан Засгийн газар нийтэд зарлана.

*/Энэ хэсэгт 2019 оны 11 дугаар сарын 22-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/*

47.15. Хөрөнгө оруулалтын тухай хуулийн дагуу [татвар] тогтворжуулах гэрчилгээ бүхий татвар төлөгчийн тухайд ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг тухайн гэрчилгээнд заасан хувь, хэмжээгээр ногдуулна.

*/Энэ хэсгийн дугаар нь 2019 оны 3 дугаар сарын 26-ны өдрийн хуулиар өөрчлөгдсөн/*

47.16. Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр төлөгч нь доор дурдсан үйл ажиллагаанд бүх төрлийн ашигт малтмалын борлуулалтын үнэлгээнээс ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг энэ хуулийн 47.7-д заасны дагуу давхардуулалгүй ногдуулж улсын төсөвт төлнө:

47.16.1. худалдсан, худалдахаар ачуулсан

47.16.2. экспортолсон

47.16.3. өөрийн хэрэгцээнд ашигласан

*/Энэ хэсэг 2019 оны 11 дугаар сарын 22-ны өдрийн хуулиар нэмэгдсэн/*

47.7. Нүүрс, нүүрсний бүтээгдэхүүний ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг энэ хуулийн 47.3.3-т заасан хувь дээр тухайн бүтээгдэхүүний нэр төрөл, зах зээлийн үнийн өсөлтөөс хамаарч доор дурдсан хувийг нэмэгдүүлж тооцно:

*/Энэ хэсэг 2019 оны 11 дугаар сарын 22-ны өдрийн хуулиар нэмэгдсэн/*

№	Бүтээгдэхүүний нэр	Хэмжих нэгж	Үнэлгээний зорилгоор жишиж бүтээгдэхүүн	Зах зээлийн үнийн түвшин /ам.доллараар/	Бүтээгдэхүүний төрлөөс хамааран нэмж ногдуулах хувь
1	Түүхий нүүрс	тонн	Нүүрс	0-25 хүртэл	0.00
				25-50 хүртэл	1.00
				50-75 хүртэл<	2.00
				75-100 хүртэл<	3.00
				100-125 хүртэл<	4.00
				125 ба түүнээс дээш	5.00
2	Боловсруулсан нүүрс (хуурай болон нойтон аргаар технологийн	тонн	Нүүрс	0-100 хүртэл	0.00
				100-130 хүртэл	1.00
				130-160 хүртэл	1.50
				160-190 хүртэл	2.00
				190-210 хүртэл	2.50

	боловсруулалт хийсэн)			210 ба түүнээс дээш	3.00
3	Эцсийн бүтээгдэхүүн (хагас кокс, кокс, хий, шингэн түлш, нүүрс-химийн бүтээгдэхүүн)	тонн	Кокс	0-160 хүртэл	0.00
				160-190 хүртэл	0.50
				190-210 хүртэл	1.00
				210-240 хүртэл	1.50
				240-270 хүртэл	2.00
				270 ба түүнээс дээш	2.50

47.18. Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигч болон ашигт малтмал дамжуулан борлуулсан этгээд ашигт малтмал худалдсан, худалдахаар ачуулсан тухай бүр татварын хууль тогтоомжид заасан төлбөрийн баримт үйлдэх бөгөөд уг төлбөрийн баримтад ашигт малтмалын нэр төрөл, ангилал, тоо хэмжээ, борлуулалтын үнэлгээ, ногдуулсан ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн дүнг тусгасан байна

*/Энэ хэсэг 2019 оны 11 дугаар сарын 22-ны өдрийн хуулиар нэмэгдсэн/*

47.19. Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшдэггүй этгээдээс ашигт малтмал худалдан авсан энэ хуулийн 47.1.3-т зааснаас бусад төлбөр төлөгч нь худалдан авсан ашигт малтмалд ногдох ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг суутган авах бөгөөд 47.10, 47.11-д заасны дагуу тайлагнаж төсөвт төлнө

*/Энэ хэсэг 2019 оны 11 дугаар сарын 22-ны өдрийн хуулиар нэмэгдсэн/*

47 дугаар зүйлийн 2 Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр

47<sup>2</sup>.1. Эрх бүхий байгууллагын зөвшөөрснөөр стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын төрийн эзэмшлийн хувь, хэмжээг гэрээний нөгөө талд шилжүүлэхээр талууд тохиролцсон тохиолдолд төрийн эзэмшлийн хувь, хэмжээг шилжүүлэн авч байгаа тал буюу ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын ашигт малтмалын нөөц ашигласны тусгай төлбөрийг энэ хуулийн 47.2-т заасан журмын дагуу тооцож улсын төсөвт төлнө.

47<sup>2</sup>.2. Энэ хуулийн 472.1-д заасан стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын ашигт малтмалын нөөц ашигласны тусгай төлбөрийн хувь, хэмжээг Засгийн газар батална

47<sup>2</sup>.3. Энэ хуулийн 5.3-5.5-д заасан стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын ашигт малтмалын нөөц ашигласны тусгай төлбөрийн хувь, хэмжээ нь тухайн ордын онцлогоос хамаарч 5 хувиас хэтрэхээргүй байна

*/Энэ хэсэг 2015 оны 2 дугаар сарын 18-ны өдрийн хуулиар нэмэгдсэн/*

47 дугаар зүйлийн 3 Үүсмэл ордоос олборлосон ашигт малтмалын бүтээгдэхүүнд ногдох ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр

Үүсмэл ордоос олборлосон бүтээгдэхүүнд ногдох ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн хэмжээ тухайн бүтээгдэхүүний борлуулалтын үнэлгээний 2.5 хувь, энэ хуулийн 47.5-д заасан нэмэлт төлбөрийн хэмжээ 0 хувьтай тэнцүү байна

47<sup>3</sup>.2. Энэ хуулийн 473.1-д заасныг үл харгалзан алтанд ногдох ашигт малтмалын нөөц ашигласны нэмэлт төлбөрийг энэ хуулийн 47.5-д заасны дагуу ногдуулна

Энэ хуулийн 473.1, 473.2-т заасан борлуулалтын үнэлгээг энэ хуулийн 47.2-т заасан зарчмаар тодорхойлно

*/Энэ хэсэг 2016 оны 11 дугаар сарын 10-ны өдрийн хуулиар нэмэгдсэн/*

## **АШИГТ МАЛТМАЛЫН НӨӨЦ АШИГЛАСНЫ ТӨЛБӨРИЙН ТУХАЙ ЖУРАМ**

Нүүрс, төмрийн хүдэр, төмрийн баяжмалаас бусад дагалдах элементэд гаалийн лабораторийн шинжилгээнд үндэслэн ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр ногдуулахтай холбогдуулан Засгийн газрын 2019 оны 465 тоот тогтоолоор батлагдсан "АМНАТ-ын хувийг тооцох, төлбөр ногдуулах, тайлагнах, төлөх журам" -ын холбогдох зүйл, заалтыг дор харуулав.

### **“Хоёр АМНАТ ногдуулах борлуулалтын үнэлгээг тооцох**

2.1. АМНАТ ногдуулах борлуулалтын үнэлгээг дараахь байдлаар тооцно

2.1.1. тухайн сард дотоодын зах зээлд худалдсан, худалдахаар ачуулсан, өөрийн хэрэгцээнд ашигласан ашигт малтмалын бүтээгдэхүүний борлуулалтын үнэлгээг тухайн бүтээгдэхүүний, эсхүл түүнтэй адил төстэй бүтээгдэхүүний дотоодын зах зээлийн үнийг баримтлан;

2.1.2. тухайн сард экспортлосон, экспортлохоор ачуулсан ашигт малтмалын бүтээгдэхүүний борлуулалтын үнэлгээг Ашигт малтмалын тухай хуулийн 47.2.1-д заасны дагуу Засгийн газраас тогтоосон үнийн эх сурвалжид үндэслэн нийтэд мэдээлсэн үнийг баримтлан;

2.1.3. Монголбанк, түүнээс эрх олгосон арилжааны банканд худалдсан алт болон мөнгөний борлуулалтын үнэлгээг Монголбанкнаас тухайн өдөр зарласан үнийг баримтлан

2.2. Ашигт малтмалын хүдэр, баяжмал, бүтээгдэхүүний агуулгын хувь нь Засгийн газраас тогтоосон үнийн эх сурвалжид үндэслэн нийтэд мэдээлсэн тухайн ашигт малтмалын агуулгын хувиас ялгаатай тохиолдолд нийтэд мэдээлсэн жишиг үнийн мэдээлэлд заасан агуулгын хувь, үнээс тухайн ашигт малтмалын нэгж агуулгын хувьд ногдох үнийг тодорхойлон борлуулж байгаа ашигт малтмалын агуулгын хувь, хэмжээнд хувь тэнцүүлэх зарчмаар борлуулалтын үнэлгээг тооцно

2.3. Дотоодын зах зээлд борлуулж байгаа бүх төрлийн ашигт малтмалын агуулга, түүний хувь, шинж чанар, ангиллыг лабораторийн дүгнэлтэд үндэслэн тодорхойлно. Лаборатори нь Монгол Улсын, эсхүл олон улсын итгэмжлэгдсэн лаборатори байна

